В ХЭСЭГ: СУУРЬ ҮНЭЛГЭЭ

БҮЛЭГ B7a: БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ

Агуулга

7 БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ 3

7.1 УДИРТГАЛ 3
7.1.1 Хамрах хүрээ 3
7.1.2 Зорилго, зорилтууд 3
7.1.3 Монгол улсын биологийн төрөл зүйлийн талаарх бодлого зохицуулалт болон хамгаалалт 3
7.2 АРГАЧЛАЛ 9
7.2.1 Ургамлын аймаг ба ургамалжилт 12
7.2.2 Амьтны аймаг 14
7.2.3 Мэдээллийн хязгаарлагдмал байдал 16
7.3 СУДАЛГААНЫ ҮР ДҮН – УРГАМАЛЖИЛТ БА УРГАМЛЫН АЙМАГ 17
7.3.1 Фитогазарзүйн болон эко бүсийн тогтолцоо 17
7.3.2 Өмнө Говийн ургамлын бүлгэмдлүүд 17
7.3.3 Гүний Хоолойн усны цооногийн талбай / ус дамжуулах шугам хоолойн талбай 19
7.3.4 Байнгын нисэх буудлын талбай 24
7.3.5 Уурхайн лицензит талбай 24
7.3.6 Дэд бүтцийн зурвас дагуух газар 30
7.3.7 Хамгаалах шаардлагатай ургамлууд 34
7.4 СУДАЛГААНЫ ҮР ДҮН – АМЬТНЫ АЙМАГ 43
7.4.1 Амьтны аймаг тархах газарзүйн орчин 43
7.4.2 Сээр нуруугүй амьтан 43
7.4.3 Загас 44
7.4.4 Газар усны амьтан 44
7.4.5 Хайрст амьтад (гүрвэл, могой) 45
7.4.6 Шувуу 46
7.4.7 Хөхтөн 53
7.4.8 Амьтадын хөгжил хувьсал 59
7.5 ЧУХАЛ АМЬДРАХ ОРЧНЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ 60
7.5.1 Чухал Амьдрах Орчин гэж юуг хэлэх вэ? 60
7.5.2 Чухал амьдрах орчныг тодорхойлох аргачлал 63
7.5.3 Чухал амьдрах орчныг тодорхойлох ажлын үр дүн 63
7.5.4 Чухал амьдрах орчны тодорхойлоход өгөх дүгнэлт 71
7.6 ОЮУ ТОЛГОЙ ТӨСЛИЙН НЭН ЧУХАЛ БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН БҮРДЭЛ ХЭСГҮҮД 73
7.7 ТҮРЭМГИЙ ТӨРӨЛ ЗҮЙЛҮҮД 77
7.8 ХУУЛИЙН ДАГУУ ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ БОЛОН ОЛОН УЛСАД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДСӨН ГАЗАР НУТГУУД 77
7.8.1 Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгууд 77
7.8.2 Өмнөговь аймаг дахь тусгай хамгаалалттай газар нутгууд 78
7.8.3 Говийн Бага Дархан Цаазат Газар 80
7.8.4 Шувуудад Чухал Газрууд 83
7.9 ОЮУ ТОЛГОЙ ТӨСЛИЙН БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН СУУРЬ МЭДЭЭЛЛИЙН ХУРААНГУЙ 83

Зураг

Зураг 7.1: Төв Азийн Говь цөлийн эко бүсэд орших Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ, эко системүүд 17
Зураг 7.2: Бариулт бүйлс (Amygdalus pedunculata), Оюу Толгой төслийн Нөлөөллийн Бүс, 2011 оны 5 сар 20
Зураг 7.3: Ахар навчит баглуур (Anabasis brevifolia), Оюу Толгой төслийн Нөлөөлийн Бүсд түгээмэл тохиолддог жижиг бутлаг ургамал 21

Зураг 7.4: Гүний Хоолойн усны цооногийн талбай ба ус дамжуулах хоолойн орчмын ургамлын бүлгэмдлүүд (ЖЭМР, 2010) 23
Зураг 7.5: Оюу Толгойн ургамлын хяналт шинжилгээний 1-р цэг, 2011 оны 5 сар, хулан хойргот (Potaninia mongolica) хэвшил 26
Зураг 7.6: Оюу Толгой уурхайн лицензит талбай дахь ургамлын бүлгэмдлүүд (7.1-р хүснэгтийг үзнэ үү) 30
Зураг 7.7: Дэд бүтцийн зурвасын Ургамалжилтын хэвшлүүд 33
Зураг 7.8: Гүний Хоолойн сав газар дахь заган ой, 2011 оны 5-р сарын 18 35
Зураг 7.9: Ундай голын хөндий дэхь Сибирь хайлаас, 2011 оны 5-р сар 36
Зураг 7.10: Дэд бүтцийн зурвасын зүүн талд Хайлаас нутагшуулсан нь, 2011 оны 5-р сар 36
Зураг 7.11: Гашуун Сухайтын замын орчим дахь Их Гүн Усний Хоолойн дахь өгөршсөн улиангарын төгөл, 2011 оны 5-р сар 37
Зураг 7.12: Булан Сухайт дахь сухай моднууд 38
Зураг 7.13: Гүний Хоолой дахь Сибирь хармаг (Nitraria sibirica) бүхий довцогууд, 2011 оны 5-р сар 39
Зураг 7.14: Толбот бэрээмэг (Arnebia guttata), Уурхайн лицензит талбай, 2011 оны 5 сар 43
Зураг 7.15: Ханбогд дахь Монгол бахын шанаган хорхой (Pseudepidalea raddei), 2011 оны 5 сарын 22 44
Зураг 7.16: Говийн гүрвэл (Eremias przewalskii), Бор Овоогийн булаг, 2011 оны 5 сар 45
Зураг 7.17: Хонин гүрвэл (Phrynocephalus cf. przewalskii), Уурхайн Лицензит талбай, 2011 оны 5 сар. 46
Зураг 7.18: Нарийн могой (Coluber spinalis), Ханбогд сумын нутаг, 2011 оны 5 сар 46
Зураг 7.19: Хайлаас модон дээр сууж буй бөвөөлжин өвөөлж, УЛТ-н орчимд, 2011 оны 5 сар 51
Зураг 7.20: Хонин гүрвэл зуусан Зээрд шонхор, 2011 оны 5 сар 51
Зураг 7.21: Дэд бүтцийн зурвасын орчимд байгаа Монгол ногтруу, 2011 оны 5 сар 52
Зураг 7.22: Жороо тоодог, Галбын Говийн ШЧГ 52
Зураг 7.23: Дэд Бүтцийн Зурвасын зүүн талын ГБДЦГ-ын Б хэсэг дэхь хулан, 2011 оны 5-р сар 59
Зураг 7.24: Дэд Бүтцийн Зурвасын баруун талд Дайчин Загийн орчим дахь хулан, 2011 оны 5-р сар 59
Зураг 7.25: (TBC & FFI 2011 –н 2а ба 2б зургийг ашиглав)Том хөхтөн амьтан /а/ болон бусад бүх төрөл зүйл /б/, төрөл зүйлүүдийн өвөрмөц бүрдэл, хувьслын гол үйл явц, экосистемийн гол үйлчлэлүүд, орон нутгийн ард иргэдийн хувьд нийгэм, эдийн засаг, соёлын ач холбогдол бүхий биологийн төрөл зүйлд зориулсан судалгааны орон зайн нэгж 65
Зураг 7.26: Өмнөговь аймаг дахь Тусгай хамгаалалттай газар нутгууд ба Шувуудад чухал газрууд 79
Зураг 7.27: ГБДЦГ-г дайран өнгөрч буй замууд 82

Хүснэгт

Хүснэгт 7.1: Уурхайн лицензит талбайн ургамлын бүлгэмдлүүд, хэвшлүүд (Зураг 7.6-ийг үзнэ үү). 26
Хүснэгт 7.2: Монгол Улсын хуулиар ховор болон нэн ховор гэж тодорхойлогдсон төслийн НБ дэхь ургамлын төрөл зүйлүүд 40
Хүснэгт 7.3: Оюу Толгой төслийн НБ дэхь дэлхийн хэмжээнд ховордсон шувуудын төрөл зүйл 48
Хүснэгт 7.4: Оюу Толгой төслийн НБ дэхь ховордсон хөхтөн амьтад 55
Хүснэгт 7.5: Устаж байгаа/ эндемик/хязгаарлагдмал тархацтай төрөл зүйлүүдийн чухал амьдрах орчин, 1 ба 2 дугаар зэрэглэлийг тодорхойлох тоон шалгуур / ГС6-ийн 9 дүгээр Бүлэгийн 1 ба 2-р шалгуурууд (2006 оны)/ TBC (2010) 62
Хүснэгт 7.6: Шалгуур 1, 2 ба 3-т тохирох төрөл зүйл ба Бүлэг 9-тэй харьцуулсан харьцуулалт (Чухал амьдрах орчныг илэрхийлэгч төрөл зүйлүүдийг тод хараар тэмдэглэв) 66
Хүснэгт 7.7: Чухал амьдрах орчны шаардлагад тэнцэх үнэ цэнэ бүхий биологийн төрөл зүйлийн бүрдэл хэсгүүд 73
Хүснэгт 7.8: Оюу Толгой төслийн Чухал амьдрах орчны үнэлгээний нэгж талбай дахь нэн чухал биологийн төрөл зүйлийн бүрдэл хэсгүүд 75
Хүснэгт 7.9: Өмнөговь аймаг дахь улсын тусгай хамгаалалттай газар нутгууд 78

ХАВСРАЛТ А. Ургамлын Бүлгэмдлүүд ба Хэвшлүүд

ХАВСРАЛТ В. Зүйлийн Жагсаалт

ХАВСРАЛТ С: БТЗТҮ Хавсралт 2: Чухал Амьдрах Орчны Үнэлгээ: ОУСК Гүйцэтгэлийн Стандарт 6 / ЕСБХБ Гүйцэтгэлийн Шаардлага 6

7 БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ

7.1 УДИРТГАЛ

7.1.1 Хамрах хүрээ

БОННБҮ-ний энэхүү бүлэг нь Монгол улсад биологийн төрөл зүйлийн хамгааллын хууль эрх зүйн болон бодлогын хамрах хүрээ, төслийн нөлөөллийн бүс дэх амьтан болон ургамлын аймаг ба Оюу Толгой төслийн нөлөөллийн бүс (НБ) дотор болон уг бүсийн ойролцоо орших тусгай хамгаалалттай болон тодорхой газар нутгуудын талаар авч үзэх болно. Мөн түүнчлэн энэхүү бүлэг нь Чухал Амьдрах Орчныг Олон Улсын Санхүүгийн Корпорацийн (ОУСК) 2006 оны хувилбар болох Гүйцэтгэлийн стандарт 6 (ГС6) болон Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны (ЕБХБ) Гүйцэтгэлийн шаардлага 6 (ГШ6)-н дагуу тодорхойлох шалгуур шинжүүрүүдийг үнэлнэ. Энэхүү бүлгийн зорилтын дагуу Оюу Толгой төслийн нөлөөллийн бүсд Өмнөговь аймгийн Ханбогд, Манлай сумдыг хамруулав. Гарсан дүгнэлтүүдийг Биологийн төрөл зүйлийн түргэвчилсэн үнэлгээний (БТЗТҮ) багийн дүгнэлтүүдтэй харьцуулсан бөгөөд үүнийг тус БОННБҮ-д хавсаргасан (Хүснэгт 1-г үзнэ үү). Зарим арга зүй болон үр дүн нь БТЗТҮ-д тусгаснаас зарим талаар өөр байв. Үүнийг холбогдох хавсралтаас дэлгэрүүлж үзнэ үү.

7.1.2 Зорилго, зорилтууд

Энэхүү бүлгийн зорилго нь Оюу Толгой төслийн нөлөөллийн бүсд орших биологийн төрөл зүйлүүдийг тодорхойлох ингэснээр онцгой анхаарал шаардсан биологийн төрөл зүйлийн чухал бүрэлдэхүүн хэсгүүдийг хожим нөлөөлөх байдлын үнэлгээнд ашиглах мөн эдгээр чухал төрөл зүйлүүдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг тодорхойлж боловсруулахын тулд тодорхойлох явдал юм. Мөн энэхүү бүлэг нь төслийн гүйцэтгэл нь биологийн төрөл зүйлүүдийн тал дээр зээлдэгчдийн тавидаг шаардлагууд, тухайлбал чухал амьдрах орчныг тодорхойлох тухай ОУСК-ийн ГС6 (2006 оны хувилбар), ЕСБХБ-ны ГШ6 (7.2.5-г үзнэ үү)-г биелүүлж байгаа эсэхийг үнэлэх үнэлгээг хөнгөвчлөх зорилготой.

7.1.3 Монгол улсын биологийн төрөл зүйлийн олон янз байдлын талаарх бодлого зохицуулалт болон хамгаалалт

Олон улсын стандартууд

ОУСК-ын 2006 оны хувилбар болох Гүйцэтгэлийн стандарт 6 (“ГС 6”) нь Биологийн төрөл зүйл болон Байгалийн тогтвортой нөөцийн менежментийн асуудлуудыг (А2 Бүлгийн 2.8.2 Хэсэг) авч үздэг. ГС6-д тодорхойлсон шаардлагуудад нийгэм болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний ажлын нэгэн хэсэг болгон биологийн төрөл зүйлийн бүхий л түвшинд төслөөс үзүүлэх нөлөөллийн эрчмийг үнэлэх явдал багтана. Энэхүү үнэлгээн нь биологийн төрөл зүйлд үзүүлэх томоохон нөлөөлөл тухайлбал амьдрах орчны сүйрэл болон түрэмгий харь зүйлүүд дээр төвлөрнө.

ЕСБХБ-ны ГШ6 нь биологийн төрөл зүйлүүдийн талаар авч үздэг бөгөөд дараах зорилтуудтай: биологийн төрөл зүйлүүдэд учрах нөлөөллөөс зайлсхийх, багасгах, бууруулах мөн тохиромжтой үед цэвэр алдагдалгүй байх буюу цэвэр эерэг нөлөөлөлд хүрэх зорилгоор томоохон үлдэгдэл нөлөөллийг нөхөн хамгаалах явдал юм (А2 Бүлгийн 2.8.3 Хэсэг).

Олон улсын гэрээ, конвенциуд

Монгол улс нь биологийн төрөл зүйлийг хамгаалахтай холбоотой байгаль орчны олон талт хэд хэдэн гэрээ хэлэлцээр, протоколуудад нэгдэн орсон. Эдгээр нь:

- *Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай олон улсын конвенци (CMS):* Энэхүү конвенци нь хуурай газрын, усан орчны болон агаараар нүүдэллэдэг төрөл зүйлүүдийг тархац нутгийн хэмжээнд хамгаалах зорилготой. Энэхүү Зэрлэг амьтдын Нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай олон улсын конвенцийн хүрээнд ховордсон тодорхой төрөл зүйлүүдэд чиглэгдсэн тодорхой тооны гэрээ хэлэлцээрүүд байгуулж, харилцан ойлголцлын санамж бичгүүдийг үзэглэсэн. Монгол улс нь энэ конвенцийг баталсан бөгөөд нүүдлийн махчин шувуудыг тархац нутаг, тоо толгойн динамик болон амьдрах орчны хувьд хамгааллын таатай нөхцлийг бий болгох зорилгоор Африк, Евроазийн нүүдлийн махчин шувуудыг хамгаалах тухай санамж бичигт (2008 оны 11 сарын 1-нд хүчин төгөлдөр болсон) гарын үсэг зурсан орон юм;

- *Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай Конвенци (1971 оны Рамсарын конвенци, 1998 онд батлагдсан):* Энэхүү ус намгархаг газрын тухай конвенци нь олон улсад ач холбогдол бүхий ус намгархаг газрыг хамгаалах болон нийт ус намгархаг газрыг тогтвортой ашиглах чиглэлээр тухайн улсын үйл ажиллагааны болон олон улсын хамтын ажиллагааны цар хүрээг тогтоож өгдөг;
- *Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн* ховордсон *зүйлийг* олон улсын *хэмжээнд худалдаалах тухай конвенц (1973 оны 3-р сар):* Тус конвенци нь зэрлэг амьтан болон ургамлын гаралтай зүйлсийг олон улсын зах зээл дээр худалдах явдал нь тэдгээрийн оршин тогтнолд сөргөөр нөлөөлөхгүй байх явдлыг хангахад чиглэгдсэн.
- *Бернийн Конвенци*: Европийн зэрлэг амьтад болон байгалийн амьдрах орчныг хамгаалах тухай 1979 оны Бернийн Конвенци нь 1982 оны 6-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болжээ.
- *Цөлжилттэй тэмцэх тухай олон улсын конвенци (1994 оны 6 сар):* Энэхүү конвенцийн зорилго нь цөлжилттэй тэмцэх, ган гачиг, цөлжилтийн гамшиг нүүрлэсэн орнуудад ган гачигийн үр дагаварыг олон улсын хамтын ажиллагааны дэмжлэгтэйгээр бүх түвшинд үр дүнтэй арга хэмжээ авах замаар бууруулах явдал юм.
- *Биологийн төрөл зүйлийн тухай конвенци (1992 оны 6 сар):* Биологийн төрөл зүйлийн тухай конвенци нь тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн бөгөөд биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хадгалан хамгаалах, түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг тогтвортой ашиглах ба генетикийн нөөцийг ашигласнаас ач тусыг шударга, тэнцүү хуваарилах зэрэг гурван гол зорилгыг дэвшүүлсэн.

Ургамал, ойг хамгаалах тухай Монгол улсын хуулиуд

Дараах хууль журмууд нь Монгол улсад ургамлын аймгийг хамгаалах үйл ажиллагааг зохицуулж байдаг.

Байгалийн ургамлын тухай хууль, 1995

Энэхүү хуулийн зорилго нь ой модноос бусад байгалийн ургамлыг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх зэрэг үйл ажиллагааг зохицуулахад оршино. Уг хуулиар ургамлыг гал түймэр, өвчин, хортон мэрэгч, хүний буруу үйл ажиллагаанаас хамгаалах арга хэмжээг авахыг шаарддаг. Мөн иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд, бусад газар ашиглагчид өөрсдийн эзэмшин ашиглаж буй газартаа ийм арга хэмжээг өөрсдийнхөө зардлаар хэрэгжүүлэх шаардлагатай юм. Төр засгийн байгууллагаас тусгайлан зөвшөөрөл олгохоос бусад тохиолдолд ургамлыг хамгаалах арга хэмжээ болгож химийн бодис хэрэглэх явдлыг хориглодог. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд болон бусад субъектууд “маш ховор ургамал” бүхий газрыг ургамал хамгаалах үйл ажиллагаа явуулахаас бусад аливаа зорилгоор эзэмшихийг хориглосон. Байгалийн ургамлын тухай хуульд ховор ургамал гэдгийг байгалийн жамаар нөхөн сэргэх чадвар хязгаарлагдмал, тархац, нөөц багатай, устаж болзошгүй ургамал хэмээн тодорхойлсон.. Энэ ангилал нь Олон улсын байгаль хамгаалах холбооны (IUCN) үнэлгээний шалгуур үзүүлэлтэнд тулгуурлаагүй.

Байгалийн ургамлыг ашигласны төлбөрийн тухай хууль байдаг бөгөөд энэ нь нэн ховор, ховор, элбэг ургамлуудыг ашигласны төлбөрийг тогтоож өгдөг. Энэхүү төлбөр хураамжийг тусгай зөвшөөрөл авахдаа тухайн сум буюу дүүрэгт төлөх ёстой.

Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хууль, 1996

Энэ хуулийн зорилт нь ой, хээрийг түймрээс сэргийлэх, түймэртэй тэмцэхтэй холбогдох үйл ажиллагааны журам, үүрэг хариуцлагыг тогтоож өгөх явдал юм. Энэ хуулийн дагуу аж ахуйн нэгжүүд дараах үүрэг, хариуцлагуудыг хүлээдэг. Үүнд:

- Өөрсдийгөө болон өөрсдийн хүрээлэн буй орчноо гал түймрээс хамгаалах, гал түймэртэй тэмцэх;
- Хэрэв гал гарвал өөрийн ажиллах хүч, машин, тээврийн хэрэгслийг ашиглан гал түймрийг унтраах арга хэмжээг авах ба гарсан галын талаар сум, дүүргийн засаг даргад мэдэгдэх;
- Галын аюултай бодис, шатах, тослох материалыг хэрэглэх, тээвэрлэх, хадгалах журам, горимыг чанд мөрдөх.

Ойн тухай хууль, 2007

Энэхүү хуулийн зорилго нь Монгол улсад ой модыг хамгаалах, эзэмших, тогтвортой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Бусад хуулиудын дотроос чухамхүү энэ хууль нь Засгийн газрын эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авалгүйгээр хуш, гацуур, хайлаас зэрэг модыг огтлох, ашиглахыг хориглодог.

Ан амьтныг хамгаалах тухай Монгол улсын хуулиуд

Амьтны аймгийн тухай Монгол улсын хууль нь *Монгол улсын Үндсэн хууль* (1992), *Байгаль орчныг хамгаалах тухай хууль* (1995), *Амьтны аймгийн тухай хууль* (2000) болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. Амьтан агнах явдлыг *Ан агнуурын тухай хуулиар* зохицуулдаг (2000). Монгол улсын хуулиар бол, хэрэв Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ нь энэхүү хуулиудтай нийцэхгүй байвал, олон улсын гэрээний зүйл заалтуудыг мөрдөнө гэж заасан. Иймд олон улсын гэрээний нөхцлүүдийг Оюу Толгой төсөлд хамааралтай бол авч үзэх шаардлагатай юм. Зэрлэг амьтдын талаарх гол хуулиудын тоймыг доор үзүүлэв.

Амьтны аймгийн тухай хууль, 2000 оны 5 сарын 5

Энэхүү хуулийн зорилго нь газар, усанд амьдардаг амьтдыг хамгаалах, өсгөн үржүүлэх явдлыг зохицуулахад оршино. Энэ хуулинд амьтны аймгийг ашиглахад тавих хязгаарлалтуудын тухай зүйл, Олон улсын байгаль хамгаалах холбооны (IUCN) ховордсон амьтдын Улаан дансанд ховор болон устаж болзошгүй хэмээн тэмдэглэгдсэн төрөл зүйлүүдийн бүртгэл, байгалийн амьдрах орчин ба нүүдлийн замналыг хамгаалах, тусгай хамгаалалттай газар байгуулах болон тэдгээрийг ашиглах журам зэргийг тодорхойлсон зүйл заалтуудыг оруулсан байдаг.

Амьтны аймгийн тухай хуулинд "нэн ховор амьтан" гэж тархац нутагтаа бүхэлдээ, эсхүл ихэнх хэсэгт тоо толгой эрс цөөрсөн, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон амьтныг тодорхойлсон байдаг. "Ховор амьтан" гэж тархац нутагтаа тоо толгой цөөрсөн, нөөц багатай, устаж болзошгүй амьтныг хэлнэ. Энэхүү ангилал нь Олон улсын байгаль хамгаалах холбооны (ОУБХХ) үнэлгээний шалгуур үзүүлэлтэнд тулгуурлаагүй.

Ан агнуурын тухай хууль, 2000 оны 5 сарын 5

Энэ хуулийн зорилт нь агнуурын амьтныг агнах, барих, агнуурын нөөцийг тогтвортой ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. “Ан агнуурын менежмент” гэж амьтдын тархац нутаг болон тоо толгойн тухай илүү мэдлэгтэй бослны үндсэн дээр тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх агнуурын бүс нутагт ан амьтныг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг нэрлэнэ. Ан агнуурын менежментийн тайлан илтгэлүүд, үнэлэлт дүгнэлтүүд нь ан амьтны нөөцийг хадгалах, өсгөн үржүүлэх, зүй зохистой ашиглах үндэс болдог. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон эрхийн дагуу агнуурын менежментийг итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллага гүйцэтгэдэг. Ан агнуурын хууль нь агнах, барих төлбөр хураамж, ан агнуурт тавих хязгаарлалт, аргазүй мөн ан агнуур хийх зөвшөөрөгдсөн улирал зэргийг тогтоож өгдөг бөгөөд гарсан зөрчлүүдэд хүлээлгэх хариуцлага, иргэдийн өгсөн мэдээлэлд олгох шагнал урамшуулал зэргийг зааж өгдөг.

Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал өөрсдийн харъяа нутаг дэвсгэр дээрх нэн ховор болон ховордсон амьтдыг хамгаалах арга хэмжээ, төсвийг тодорхойлж хэрэгжүүлэх эрхтэй байдаг. Эдгээр эрхүүдэд амьтны аймгийг хамгаалах тухай холбогдох хууль, журмыг уялдуулах, хэрэгжүүлэх мөн байгаль орчны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх явдал багтана.

Сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал ба засаг дарга нь өөрсдийн харьяа нутаг дэвсгэр дээрхи нэн ховор ба ховор амьтдыг хамгаалах арга хэмжээ ба төсвийг тодорхойлж хэрэгжүүлэх эрхтэй.

Нэн ховор амьтдыг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг хэрэгжүүлэх замаар мөн агнах барихыг хориглох зүйл заалтаар хамгаалдаг бөгөөд зөвхөн шинжлэх ухааны зорилгоор буюу эсвэл төв захиргааны удирдлагаас тусгай зөвшөөрөл олгохоос бусад тохиолдолд хориглосон байдаг. Монгол улсад ан амьтныг хамгаалах өөр олон төрлийн нэмэлт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх боломжтой байдаг. Үүнд:

- Олон улсын болон Монгол улсын “Улаан ном”[1]-нд нэн ховор болон ховор амьтдыг жагсаан оруулах,
- Амьтдын оршин амьдрах нутаг дэвсгэрийг хамгаалах, нүүдлийн хөдөлгөөний замыг саадгүй байх явдлыг хангах,
- Тусгай хамгаалалттай газар бий болгох, тэдгээрийн ашиглалтыг зохицуулах,
- Амьтдыг тэдгээрийн унаган амьдрах орчинд дахин нутагшуулах,
- Амьтдыг аж үйлдвэрийн болон эдийн засгийн үйл ажиллагаанаас үүдэлтэй аюулаас хамгаалах,
- Био-техникийн арга хэмжээ авах,
- Өвчин эмгэг, байгалийн гамшиг, бусад аюул осолд нэрвэгдсэн амьтдад туслах зэрэг багтана.

Гэрээний дагуу газар эзэмшиж байгаа аж ахуйн нэгжүүд нь аж үйлдвэрийн үйл ажиллагаа, байгалийн гамшиг болон бусад аюулаас амьтдыг хамгаалах, байгаль хамгаалах био-техникийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх үүрэгтэй юм.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол улсын хууль эрх зүйн орчин

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол улсын хууль тогтоомж нь үндэслэл сайтай бөгөөд улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон тэдгээрийн орчны бүс дотор явуулж болох зөвшөөрөгдсөн үйл ажиллагаануудыг маш тодорхой зааж өгсөн. Дараах хууль тогтоомж нь Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай харилцааг зохицуулдаг.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1995)

1995 оны 4 сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн энэхүү хууль нь улсын тусгай хамгаалалттай бүсэд хамаарагдах газруудыг тогтоох, менежментийг хэрэгжүүлэх, газар ашиглах харилцааг зохицуулдаг. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг дараах дөрвөн төрөлд хуваажүзнэ. Үүнд: Дархан цаазат газар, Байгалийн цогцолборт газар, Байгалийн нөөц газар, Дурсгалт газар орно. Эдгээр тусгай хамгаалалттай газар нутгууд нь БОАЖЯ-ны харьяанд байдаг бөгөөд эдгээр төрлүүдийг доорх хэсэгт дэлгэрэнгүй тайлбарлан үзүүлэв. Үүнд:

- **Дархан цаазат газар (ДЦГ**) – Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, хэв шинжийг төлөөлж чадах, унаган төрх байдлаа хадгалсан байдал, шинжлэх ухааны болон соёл иргэншлийн онцгой ач холбогдлыг нь харгалзан байгаль орчны тэнцвэрт байдлыг хангахад чухал газар нутгийг хэлэх бөгөөд дараах бүсүүдэд хуваана:
    - Онгон бүс – зөвхөн ажиглалт, судалгаа шинжилгээ явуулах боломжтой,
    - Хамгаалалтын бүс - судалгаа шинжилгээ болон хамгаалалтын арга хэмжээг явуулна,
    - Хязгаарлалтын бүс – аялал жуулчлал, уламжлалт шашны зан үйл, зарим ургамлыг түүхийг нөхөн сэргээх үйл ажиллагаа зөвшөөрөгдөнө. Ан агнуур хийх, мод бэлтгэх, барилга барих зэргийг хориглосон,
    - Орчны бүс (тусгай хуулиар зохицуулагддаг).
- **Байгалийн цогцолборт газар** - Байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, түүх, соёл, шинжэх ухааны болон танин мэдэхүй, экологийн ач холбогдол бүхий авсан газар нутгийг хэлэх бөгөөд дараах бүсүүдэд хуваана:
    - Онцгой бүс - судалгаа шинжилгээ болон хамгаалалтын арга хэмжээг явуулахыг зөвшөөрнө,

[1] Монгол улсын Улаан Ном (1997) нь Олон улсын байгаль хамгаалах холбооны (IUCN) үнэлгээний шалгуур шинжүүрүүд дээр тулгуурлаагүй. Олон улсын байгаль хамгаалах холбооны (IUCN) үнэлгээний шалгуур шинжүүрүүд дээр үндэслэн сүүлд хэвлэгдсэн гарсан Монгол улсын Улаан Данс нь загас, хэвлээр явагчид болон хөхтөн амьтдад зориула 2006 онд хэвлэгдэн гарсан. Шувууд болон эмийн ургамлын Улаан дансны гүйцэтгэл төгсгөлийн шатандаа явж байна.

- Аялал, жуулчлалын бүс – аялал жуулчлал, загасчлал болон дээр дурьдсан үйл ажиллагаануудыг явуулахыг зөвшөөрнө,
- Хязгаарлалтын бүс – мал бэлчээрлүүлэхээс гадна дээр дурьдсан үйл ажиллагаанууд, хязгаарлагдмал тооны барилга байгууламжийг зохих зөвшөөрлийн дагуу барих.

- **Байгалийн нөөц газар** нь дөрвөн төрөлд хуваагдана:
  - Байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах зорилго бүхий **байгалийн иж бүрдлийн нөөцөт газар**,
  - Ховор ховордсон ургамал, амьтныг хамгаалах, тэдгээрийн нөхөн үржих нөхцлийг бүрдүүлэх зорилго бүхий **биологийн нөөцөт газар,**
  - Эртний амьтан, ургамлын ховор олдворыг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий **байгалийн түүхэн олдворын нөөцөт газар,**
  - Газрын өвөрмөц тогтоц, илэрц, тэдгээрийн бүтцийг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий **геологийн нөөцөт газар**.
- **Дурсгалт газрыг** дараахь төрөлд хуваана:
  - Тухайн газар нутаг дахь **байгалийн дурсгалт газар**
  - Барилга болон хүний хийж бүтээсэн бусад **түүх, соёлын дурсгалт газар**.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1995) нь тусгай хамгаалалттай газар нутгийн (ТХГ) янз бүрийн бүсүүдэд явуулж болох тодорхой үйл ажиллагаануудад хязгаарлалт тогтоосон. Эдгээр хязгаарлалтуудыг доор дурьдав[2]. Түүнчлэн тус хуулийн 5.3-р зүйлд зааснаар улсын хил хамгаалах байгууллага нь улсын хил дээрх болон улсын хил орчмын тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх журмыг тогтооно гэж заасан байдаг. Төслийн хувьд, энэ нь Гашуун Сухайтын хилийн шалган нэвтрүүлэх цэг болон улсын хил рүү тусгай хамгаалалттай газар нутгаар дамжин өнгөрөх замын хэсэгтэй хамаатай. Төслийн баяжмал экспортлох болон бараа материал оруулж ирэх явдалтай холбоотой хил орчмын үйл ажиллагаанууд нь доор дурьдсан газар ашиглалтын зохицуулалтаас илүүтэйгээр дээрхи хуулийн 5.3-р зүйлийг баримтлан зохицуулагдана.

- **Онгон бүс**

  ТХГ-ийн Онгон бүсэд явуулах үйл ажиллагаа нь тухайн газар нутгийн байгалийн унаган төрх, бүрэн бүтэн байдлыг хадгалахад чиглэгдсэн хамгаалалтын арга хэмжээгээр хязгаарлагдана. Онгон бүсэд байгалийн амьдрах орчныг нь хөндөхгүйгээр зөвхөн ажиглалт, судалгаа, шинжилгээний ажил явуулж болно. Оюу Толгойн зам энэхүү бүсээр дайрч өнгөрөхгүй.

- **Хамгаалалттай бүс**

  Хамгаалалттай бүсэд байгалийн гамшгаас болон бусад тохиолдлоос учирсан хор уршгийг арилгахтай холбогдсон тодорхой үйл ажиллагаа, арга хэмжээг хэрэгжүүлнэ. Оюу Толгой төсөл энэ бүсэд ямар нэгэн үйл ажиллагаа явуулахгүй.

- **Хязгаарлалтын бүс**

  Хязгаарлалтын бүсэд онгон болон хамгаалалтын бүсэд явуулж болох дээр дурьдсан үйл ажиллагаа, хөрс, ургамлан бүрхэвчийг нөхөн сэргээх, ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх, ан амьтны тооллого, тэдгээрийн тоо, нас, хүйс, сүргийн бүтцийг зохицуулах үйл ажиллагааг батлагдсан хөтөлбөр, аргачлалын дагуу явуулах, халуун хүйтэн рашаан, эмчилгээ, сувилгааны чанартай бусад эрдсийг ашиглах, байгалийн аялал жуулчлалыг тогтоосон зам, чиглэлээр зохих журмын дагуу зохион байгуулах, аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах, зураг авах, дууны болон дүрс бичлэг хийх, тэдгээрийг зохиол бүтээл туурвихад ашиглах, уул, овоо тахих, уламжлалт зан үйлийн бусад ёслол үйлдэх, нутгийн оршин суугчид ахуйн хэрэгцээндээ зориулан байгалийн дагалт баялаг,

[2] Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол улсын хууль, 1994 оны 11 сарын 15, Нэгдүгээр бүлэг Нийтлэл үндэслэл

эмийн болон хүнсний ургамлыг зохих журмын дагуу түүж ашиглах зэргээс бусад эдийн засгийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Оюу Толгой төсөл (өөрөөр хэлбэл, Оюу Толгой – Гашуун Сухайт чиглэлийн зам) энэ бүсээр 13 км газрыг дайрч өнгөрнө.

- **Орчны бүс**

Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)

1997 оны 10 сарын 23-наас хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн энэхүү хууль нь дархан цаазат газар болон байгалийн цогцолборт газруудын орчинд тогтоосон болон байгалийн нөөц газар ба дурсгалт газруудын орчинд тогтоож болох болох орчны бүсэд явуулах үйл ажиллагааг зохицуулална. *Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуулинд* (1997) орчны бүсийг доорх байдлаар тодорхойлсон байдаг:

> *"Дархан цаазат газар болон байгалийн цогцолборт газарт бодитой үүссэн болон үүсч болох сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, хамгаалахын тулд болон олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн амьжиргааг хангах, байгалийн нөөцүүдийг зүй зохистой ашиглах шаардлагуудыг бий болгох зорилготойгоор бий болгосон газар нутаг юм"*[3].

Монгол улсад тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсэд эдийн засгийн үйл ажиллагаа явуулахыг хориглоогүй байдаг ч, хязгаарлагдмал тооны үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөг. Байгууллага, аж ахуйн нэгжүүд арилжааны зорилгоор мод бэлтгэх, ан агнуур хийх, анчдын отгийг байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, олборлох, усан сан байгуулах, үерийн хаалт, далан байгуулах зэрэг үйл ажиллагааг хуулийн дагуу явуулах ёстой бөгөөд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэх ёстой байдаг.

Оюу Толгой – Гашуун Сухайт чиглэлийн сайжруулсан зам нь Говийн Бага Дархан Цаазат Газрын (ГБДЦГ) орчны бүсийн нутгаар 32 км газар үргэлжлэн дайрч өнгөрөх бөгөөд ийм учраас Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуулийн (1997) зүйл заалтуудыг дагаж мөрдөх ёстой юм. ГБДЦГ-аар дайрч өнгөрөх Оюу Толгой – Гашуун Сухайт чиглэлийн замыг барихын тулд авбал зохих зөвшөөрлийг авах үйл явцыг доор товч сийрүүлэн үзүүлэв.

ГБДЦГ-н хязгаарлалтын бүс болон орчны бүсээр дайрч өнгөрөх Оюу Толгой – Гашуун Сухайт чиглэлийн замын зөвшөөрөл олгох тухай

Оюу Толгой – Гашуун Сухайт чиглэлийн ("Оюу Толгой – Гашуун Сухайт") замын төсөлд 2 удаа БОНБНҮ боловсруулж шүүмж хийлгэсний дараа холбогдох удирдлагуудын зөвшөөрлийг авсан:

Оюу Толгой төслийн БОНБНҮ-ний 1-р боть **Оюу Толгойгоос Гашуун Сухайт хүртэлх тээвэр, дэд бүтцийн зурвас**[4]	Гашуун Сухайтаас Оюу Толгой хүртэл баруун талаараа буюу одоогийн нүүрсний замын чиглэлээр тавигдахаар төлөвлөж байсан зам болон эрчим хүчний шугамын анхны төсөлд хийгдсэн БОНБНҮ. Говийн бага дархан цаазат газар (ГБДЦГ) ба орчны бүсээр дайрч өнгөрөх зөвшөөрөл олгогдсон. Байгаль орчин аялал жуулчлалын яам зөвшөөрөл олгосон бөгөөд тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа болон улсын хил хамгаалах байгууллагаар баталгаажуулсан.	2004 оны 4 сард өргөн барисан	2004 оны 5 сард баталсан
Оюу Толгой төслийн БОНБНҮ-ний 1-р боть, нэмэлт тодотгол **Оюу Толгойгоос Гашуун Сухайт хүртэлх тээврийн зурвасын чиглэлийг өөрчлөх тухай**	Гашуун Сухайт хүртэлх зүүн чиглэлийн замын шинэчилсэн чиглэлийн үнэлгээ /баруун чиглэлийн замаар нүүрсний тээвэрлэлтийн хөдөлгөөний улмаас байгаль орчинд учруулсан өнөөгийн хохирлын үнэлгээг оруулсан/. Байгаль орчин аялал жуулчлалын яам зөвшөөрөл олгосон бөгөөд тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа болон улсын хил хамгаалах байгууллагаар баталгаажуулсан.	2006 оны 12 сард өргөн барисан	2007 оны 3 сард баталсан

[3] Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль, 1997 оны 10 сарын 23, Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл

[4] Дэд бүтэцийн зурвас хэмээх тодорхойлолтонд Монгол-Хятадын хилээс Оюу Толгой төслийн талбай хүртэлх зам болон цахилгаан дамжуулах шугам хоёрыг багтаасан зурвас газрыг ойлгоно.

Оюу Толгой болон Зам Тээвэр Барилга Хот Байгуулалтын Яамны хооронд байгуулсан гэрээнд хоёр тал 2010 оны 11 сарын 12-ны өдөр гарын үсэг зурсан. Энэхүү гэрээгээр тус замын техник-эдийн засгийн үндэслэлийг (үүн дотроо ГБДЦГ-н орчны бүс болон хязгаарлалтын бүсийг дамжин өнгөрч буй замыг хэсгийг оролцуулан) баталсан бөгөөд гэрээт гүйцэтгэгчийг шалгаруулах цаашдын тендерийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтоож өгсөн[5]. Тус гэрээнд байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны талаар тодорхой зүйл заалт тусгагдаагүй. Гэрээт гүйцэтгэгч шалгарсан үед “Оюу Толгой” компани нь Оюу Толгой – Гашуун Сухайт чиглэлийн зам барих ажилд зориулан газрын эзэмшлийн тухай тодорхойлолт гаргаж өгөх хүсэлтийг Өмнөговь аймгийн засаг даргад тавих болно.

7.2 АРГАЧЛАЛ

Энэхүү бүлэгт дурьдаж буй суурь судалгааны мэдээллүүд нь холбогдох төрийн байгууллагуудаар батлагдсан Оюу Толгой төслийн БОНБНҮ-ний тайлангуудад зориулж цуглуулсан мэдээнүүд, Оюу Толгойн ажилтнууд, зөвлөхүүдийн явуулсан хээрийн судалгаа, ном хэвлэлээс авсан материал, Биологийн төрөл зүйлийн түргэвчилсэн үнэлгээ (“БТЗТҮ” – “Фауна энд Флора Интернэшнл”, Биологийн төрөл зүйлийн зөвлөх ба Монголын мэргэжилтнүүд)-ний хүрээнд 2011 онд хийгдсэн хээрийн судалгаа, мэргэжилтнүүдтэй хийсэн хэлэлцүүлэгийн дүн, зохих хэвлэмэл материалаас бүрдэнэ. Энэхүү БОНБНҮ-ний хээрийн судалгаа, БТЗТҮ-ний тодорхой аргачлалуудыг доор авч үзэв. Биологийн төрөл зүйлийн түргэвчилсэн үнэлгээний хөтөлбөрийн тойм болон нь энэхүү БОННБҮ-ий тайлангийн биологийн төрөл зүйлийн суурь судалгааг боловсруулах болон нөлөөллийн үнэлгээний бүлгүүдтэй хэрхэн уялдаж байгааг Хүснэгт 1-т үзүүлэв.

Энэхүү суурь судалгааны мэдээллийн нэг гол эх сурвалж нь Биологийн төрөл зүйлийн зөвлөх болон “Фауна энд Флора Интернэшнл”-ийн хамтран бэлтгэсэн “Оюу Толгой төслийн Чухал амьдрах орчны үнэлгээ: ОУСК-ын Гүйцэтгэлийн стандарт 6 (ГС6)/ ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 6 (Техникийн илтгэл)” юм. Үүнээс гадна дотоодын шинжээчидтэй хамтран БТЗТҮ-ний хүрээнд хийгдсэн хээрийн судалгааны тайлангууд нь мөн эх сурвалж болсон.

[5] Оюу Толгой болон Зам Тээвэр, Барилга Хот Байгуулалтын Яам хооронд 2010 оны 11 сарын 12-нд байгуулсан гэрээ.

Хүснэгт 1: Биологийн төрөл зүйлийн олон янз байдлын түргэвчилсэн үнэлгээ (БТЗТҮ): тойм

“Оюу Толгой” нь Оюу Толгой төсөлд зориулсан ОУСК-ын ГС6 удирдамж баримт бичгийн дагуу ОУСК-ын ГС6, ЕСБХБ-ны ГШ6 - биологийн төрөл зүйлийн гүйцэтгэлийн стандартуудад нийцэхүйц тайлан боловсруулах гэрээг “Фауна энд Флора Интернэшнл” компанитай байгуулсан (ОУСК 2009). Үүнийг Биологийн төрөл зүйлийн зөвлөх компаний мэргэжилтнүүдийн туршлагыг ашиглан, мөн Зэрлэг Амьтдыг Хамгаалах Нийгэмлэг, ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн Шувуу судлалын лабораторийн дэргэдэх Байгаль Судлал, хамгаллын төв, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хетелберийн газар, Улсын их сургуулиуд болон бусад байгууллагуудын дотоодын болон гадаадын мэргэжилтнүүдийн томоохон, туршлагатай баг бүрэлдэхүүний оролцоотойгоор хийж гүйцэтгэсэн.

БТЗТҮ-ний хүрээнд FFI-ийн зүгээс биологийн төрөл зүйлийн талаарх шаардлагатай мэдээллийг бататгах зорилгоор хэд хэдэн хээрийн судалгаануудыг явуулсан. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлын улмаас шувуу, ургамлын аймаг, томоохон хөхтөн амьтдыг хамарсан өргөн судалгаа явуулах нь боломжгүй гэж үзсэн бөгөөд үүний оронд тодорхой сэдвүүд дээр илүү нарийвчилсан судалгааг шилдэг мэргэжилтнүүд явуулсан. Томоохон сүүн тэжээлтэн амьтдыг агаараас тандан судлах боломжийг судалсан боловч тухайн үед бэлэн байсан нисэх онгоцны аюулгүй байдалд хяналт тавих боломжгүй байв. Иймээс хээрийн нарийвчилсан судалгаанд сонгосон сэдвүүд нь:

- Жижиг хөхтөн амьтад (үүнээс зарим ховордсон төрөл зүйлүүд төслийн нөлөөллийн бүсэд байж болзошгүй гэж үзсэн),
- Заган (*Haloxylon ammodendron*) ой, хайлаас мод (*Ulmus pumil*)-ны тархац, тоо хэмжээний өөрчлөлт,
- Эмийн ургамлын тархац, хэрэглээ,
- Бэлчээрийн чанар ба
- Цахилгаан дамжуулах шугамын дагуух жороо тоодог (*Chlamydotis undulata*) байв.

Дээрх тайлангуудыг 2011 оны 7-оос 9 сарын хооронд боловсруулан гаргасан БТЗТҮ-ийн гол үр дүнгүүдэд нэгтгэж оруулсан. Эдгээр үр дүнгүүд нь:

- Оюу Толгой төслийн Биологийн төрөл зүйлийн олон янз байдлын бодлого (Хавсралт A, *Бүлэг С6: Биологийн төрөл зүйлийн олон янз байдал ба Экосистемийн үйлчилгээнд Нөлөөлөх байдлын үнэлгээ*),
- ГС6 / ГШ6 Оюу Толгой төслийн Чухал Амьдрах Орчны тухай тайлан (Хавсралт C),
- Оюу Толгой төслийн биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөлөл, тэдгээрийг бууруулах арга хэмжээ (Хавсралт B, *Бүлэг С6: Биологийн төрөл зүйлийн олон янз байдал ба Экосистемийн үйлчилгээнд Нөлөөлөх байдлын үнэлгээ*),
- Оюу Толгой төслийн Биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийг нөхөн хамгаалах бодлого (Хавсралт C, *Бүлэг С6: Биологийн төрөл зүйлийн олон янз байдал ба Экосистемийн үйлчилгээнд Нөлөөлөх байдлын үнэлгээ*) ба
- Оюу Толгой төслийн цэвэр эерэг нөлөөллийн урьдчилсан төлөв (Хавсралт D, *Бүлэг С6: Биологийн төрөл зүйлийн олон янз байдал ба Экосистемийн үйлчилгээнд Нөлөөлөх байдлын үнэлгээ*).

.

Хүснэгт 1 (үргэлжлэл): Биологийн төрөл зүйлийн олон янз байдлын түргэвчилсэн үнэлгээ (БТЗТҮ): тойм

Дээр дурьдсан БТЗТҮ-ий үр дүнгүүдийг Оюу Толгой төслийн БОННБҮ-нд ашиглах мөн хавсаргах зорилгоор боловсруулсан. Үүнд:



Дээрх зурагт үзүүлснээр Оюу Толгой төслийн нөлөөллийн бүс дэх биологийн төрөл зүйлийн энэхүү суурь үнэлгээ нь БТЗТҮ-ний хээрийн судалгааны ажлын үр дүн болон төслийн нөлөөллийн бүс дэх БТЗТҮ-ний чухал амьдрах орчны үнэлгээний үр дүнгүүдийг нэгтгэсэн. БТЗТҮ хөтөлбөрийн бусад үр дүнгүүдийг Оюу Толгой төслийн энэхүү БОННБ үнэлгээний Биологийн төрөл зүйлийн нөлөөллийн

7.2.1 Ургамлын аймаг ба ургамалжилт

Оюу Толгой төслийн талбайн ургамлын аймаг ба ургамалжилтын талаарх мэдээллийг ургамал судлалын ном хэвлэл, төслийн янз бүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн БОНБНҮ-үүд, төслийн дэд бүтцийн зарим бүрэлдэхүүн хэсгүүдэд (жишээлбэл, Гүний хоолой усан хангамжийн цооногийн талбай, Оюу Толгойгоос Гашуун Сухайт хүрэх замын зурвас) хамаарах ургамлын аймаг, ургамалжилтын хээрийн судалгааны тайлан гэх зэрэг эх сурвалжуудаас авсан. Мөн үүнээс гадна БТЗТҮ-ний хүрээнд хийсэн Ханбогд суман дахь заг болон хайлаас модны популяцийн судалгааг (2011 онд Шмидт явуулсан) энэхүү суурь судалгааны бүлэгт нэгтгэн оруулсан. Боломжтой газар нь янз бүрийн хээрийн судалгаануудын дээж авах аргачлалыг холбогдох дэд гарчгууд доор оруулсан байгаа. Оюу Толгой төслийн хэрэгжүүлж буй дотоод хяналт шинжилгээний хөтөлбөрөөр дамжуулан дээж авах ажлын мэдээллийг нэмж оруулсан бөгөөд энэ ажлын хүрээнд уурхайн лицензит талбайн 36 цэгт ургамалжилтын хяналт шинжилгээг хийж байгаа юм. Энэхүү мэдээллийн гол эх сурвалжуудыг доор жагсаан үзүүлэв:

- Байгалийн ургамлын тухай хууль, 1995
- Ж. Санжид, Биологийн хүрээлэн, Оюу Толгойн ургамлан бүрхэвч, тэдгээрийн онцлогууд, 2003 оны 7 сар,
- Оюу Толгой төслийн БОНБНҮ, 1-р боть, Оюу Толгой- Гашуун Сухайт чиглэлийн зам, дэд бүтцийн зурвас, Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон Хяналт шинжилгээний хөтөлбөр, “Эко-Трейд” ХХК, 2004,
- Оюу Толгой төсөл, Хойд Хюго ордын 2-р босоо амны БОНБНҮ-ний тайлангийн нэмэлт тодотгол, “Эко-Трейд” ХХК, Улаанбаатар, 2005,
- Оюу Толгой төслийн Гүний Хоолой ба Галбын Говийн гүний усны нөөцийн ашиглалт, “Эко-Трейд” ХХК, 2005,
- Оюу Толгой төслийн БОНБНҮ, 3-р боть, Олборлолт ба боловсруулалт, “Эко-Трейд” ХХК, УБ, 2006,
- Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ, Ухаа-худаг II үе шат, “Энержи Ресурс” ХХК, ERM ба Sustainability, 2009,
- Оюу Толгой төслийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны дэд багц, Бодлого судлалын төв, Хүн амын сургалт, судалгааны төв, 2009,
- Оюу Толгой төслийн байгаль орчны жилийн тайлан, 2009 он,
- Вон Верхден, Х.К. Веще ба Г. Мехе. 2009. Монгол орны өмнө Говийн ургамлын бүлгэмдлүүд. Фитокоэнологиа 39(3): 331-376,
- Оюу Толгой төслийн Гүний хоолойн гүний усны нөөцийг ашиглах БОНБНҮ-ий 2005 тайланд оруулсан нэмэлт тодотгол. “ЖЕМР Консалтинг” ХХК, 2010,
- Байнгын нисэх онгоцны буудлын БОНБНҮ, 2011 оны 2 сар, ба
- С. Шмидт, Э. Баасандамба, А. Хауленбек, Д. Буг, Заг болон хайлаас модны үнэлгээ, Ханбогд сум, ОУСК-ын Оюу Толгойн чухал амьдрах орчны анализ – Гүйцэтгэлийн стандарт 6. Шинэ Зеландын Байгалийн Хүрээлэн – Олон нийтийн санаачилгад тулгуурласан хамгаалалтын арга хэмжээ, 2011 оны 8 сар.

Уурхайн лицензит талбай

Уурхайн лицензит талбай дахь ургамлын бүрхэвчийг “Эко-Трейд” ХХК нь 2006 онд экологийн өөр өөр ургах орчин нөхцөл, ургамлын бүлгэмдлүүдийг тодорхойлох зорилгоор 10 м x 10 м (100 $м^2$)-ийн хэмжээтэй хэсэгчилсэн талбайнуудад бичиглэл хийн судалсан. 100 $м^2$ хэмжээтэй судалгааны талбайнуудыг мөн дотор нь арай жижиг 1 $м^2$ хэмжээтэй талбайнуудад хуваан торлож ургамлын хэвшлийн ангиллын тухай илүү тодорхой мэдээлэл цуглуулахын тулд хэд хэдэн үзүүлэлтүүдийг

(зүйлийн бүрэлдэхүүн, элбэгшил, нягтшил, хамгааллын статус) хэмжсэн. Ховор, нэн ховор болон хамгаалах шаардлагатай төрөл зүйлүүдийг тодорхойлох үүднээс судалгааны үеэр авсан ургамлын дээжүүдийг цуглуулж Монгол орны ургамлын аймгийн тухай гол ном хэвлэлүүд, Монгол орны Улаан номонд (1997) орсон Ургамлын жагсаалт, мөн Байгалийн ургамлын тухай Монгол улсын хуулийн (1995) зүйл заалтуудтай харьцуулсан.

Уурхайн лицензит талбайд ховор ургамлын судалгааг 2005 оны 8 сард явуулсан ("Эко Трейд", 2006). Энэхүү судалгааны явцад ажиглагдсан ховор болон нэн ховор ургамлын байршлыг нарийн тодорхойлж, тухайн ургамлын популяцийг хамгаалах арга хэмжээг боловсруулсан (Олборлолт болон боловсруулалтын БОНБНҮ-ний 6-р бүлгийн 6.3-р хүснэгтийг үзнэ үү).

Уурхайн лицензит талбайн хэмжээн дэхь ургамлын бүрхэвчийн зураглалыг дээр дурьдсан хээрийн судалгааны үр дүн мөн шугаман трансектийн судалгаа ба өндөр үзүүлэлт бүхий сансрын хиймэл дагуулын зураг зэргийг ашиглан боловсруулсан. Ургамлын хэвшлүүдийн бичиглэлийг хийхдээ ажиглагдсан зонхилогч зүйлүүд дээр тулгуурласан бөгөөд ийнхүү гаргасан ургамалжилтийн зургийг энэ тайлангийн Хавсралт В11.1-д үзүүлсэн болно. Уурхайн лицензит талбайд тодорхойлогдсон ургамлын бүлгэмдлүүдийг доорх 7.3.5 Хэсэгт нэгтгэн үзүүлэв.

Оюу Толгой төслийн уурхайн лицензит талбайд ургамын судалгааг явуулахаас өмнө нилээд хэмжээний хайгуулын ажил тухайлбал газрын гадаргаас сувган дээж авах, өрөмдлөг хийх, холбогдох зам, кэмпүүдийг байгуулах зэрэг ажлуудыг хийгдсэн байв. Ашигт малтмалын хайгуулын ажил төвлөрсөн газарт ургамлан бүрхэвч эвдрэл доройтолд орсон байсан бөгөөд улмаар лицензит талбайн хувьд ургамлан нөмрөгийн суурь нөхцөл байдлыг илэрхийлж чадахуйц мэдээлэл боловсруулах явдал хязгаарлагдмал байв.

Цооногийн талбай, ус дамжуулах шугам хоолойн талбай

Гүний Хоолойн ургамлын бүрхэвчийн судалгааг ургамал судлаач Ж. Санжид 2004 оны 3 сард явуулсан ("Эко Трейд", 2009). 25 м х 25 м, 100 м х 100 м харьцаатай талбайд бичиглэл хийнургамлын судалгааг явуулсан, гэвч судалгаанд хамрагдсан талбай тус бүрийн тоог уг тайланд дурьдаагүй байна. Судалгааны талбай доторх ургамлын зүйлүүдийн бүрхэвч, элбэгшлийг бүртгэсэн байна. Судалгааны талбай дахь ургамлын хэвшлийг зонхилогч зүйл болон тухайн ургах орчин дээр үндэслэн тодорхойлж зураглал хийсэн. Ургамлын зүйлүүдийн үндэсний уртын хэмжээг тодорхой ургамлын хэвшлүүд гүний уснаас хэрхэн хамааралтай болохыг тодорхойлох зорилгоор тэмдэглэсэн.

Гүний Хоолойн ургамлын бүрхэвчийн талаарх хоёр дахь судалгааг 2008 онд гүйцэтгэсэн бөгөөд үүний үр дүнг JEMR компаний боловсруулсан тайланд авч үзсэн (2010). JEMR (2010) компаний явуулсан судалгаагаар судалгааны талбайд тохиолдох ургамлын хэвшлүүдийг зонхилогч ургамлын төрөл зүйлүүд болон ургах орчны мэдээн дээр тулгуурлан зураглал гаргасан. Ургамалжилтийн зургийн үр дүнг доорх 7.3.3 хэсэгт үзүүлсэн болно.

Зам болон цахилгаан дамжуулах шугам (Дэд бүтцийн зурвас)

Оюу Толгой - Гашуун Сухайт чиглэлд тухайн үед төлөвлөж байсан зам дагуух ургамлын аймаг, ургамалжилтын хээрийн судалгааг 2006 оны 5 сард явуулсан ("Эко Трейд", 2006). Карьерийн ойролцоох талбай болон ургамлын янз бүрийн хэвшлүүд тохиолдож байгаа газруудад 10 х 10 м-ийн хэмжээтэй талбайнуудад ургамлан бүрхэвч, биомасс, зүйлийн бүрэлдэхүүн зэргийг судлан бүртгэсэн. Судалгаа хийсэн талбайнуудын тоо, байршлыг бүртгээгүй байна.

Дэд бүтцийн зурвасын дагуу ургамлын аймаг, ургамалжилтын хоёр дахь хээрийн судалгааг 2010 оны 10 сард явуулсан байна ("Эко Трейд", 2010). Хээрийн судалгааны мэдээг дэд бүтцийн зурвасын дагуу 10 х 10 м-ийн хэмжээтэй 6 талбайгаас цуглуулсан бөгөөд ургамлын зүйлийн тархац, элбэгшил, ховор, устаж болзошгүй, нутгийн унаган ургамал байгаа эсэх зэргийг бүртгэсэн. Судалгааны талбайнуудыг төслийн талбайд ажиглагдсан ургамлын хэвшлийн олон янз байдал ажиглагдсан ургах орчнуудад сонгон бичиглэл хийсэн.

Эко Трейд ХХК нь (2010) Зам болон цахилгаан дамжуулах шугамын дэд бүтцийн зурвасын дагуу тохиолдох ургамлын хэвшлүүдийн тархцын зургийг гаргасан байна. Цооногийн талбай, ус дамжуулах шугам хоолойн талбайн хувьд ургамлын хэвшлийг зонхилогч ургамлын зүйлүүд болон ургамлын ургах орчин зэрэг дээр үндэслэн тодорхойлсон.

Нисэх онгоцны буудлын талбай

Шинээр төлөвлөж буй байнгын ажиллагаатай нисэх онгоцны буудлын талбайд ургамлын аймаг, ургамалжилтын судалгааг 2010 онд явуулсан (OSMT 2011). Судалгааны талбайд 25 х 25 м-ийн хэмжээтэй талбайнуудад ургамлын зүйлийн бүрдэл, зонхилогч зүйлүүд, хөрсний гадарга, ургамалжилтын нөхцөл зэргийг тодорхойлсон боловч, судалгаа хийсэн талбайнуудын тоог бүртгээгүй байна. OSMT ХХК нь (2011) тус нисэх онгоцны буудлын судалгааны талбай дахь ургамалжилтын зургийг гаргасан бөгөөд ургамлын зонхилогч зүйлүүд, ургамалжилт ажиглагдаж байгаа газрын ургах орчин зэрэг дээр үндэслэн ургамлын хэвшлүүдийг тодорхойлон гаргасан байна.

7.2.2 Амьтны аймаг

Төслийн нөлөөллийн бүс дэх амьтны аймгийн суурь судалгааны мэдээллийг төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн БОНБНҮ-үүд зэрэг хэд хэдэн эх сурвалжуудаас авсан. Төслийн нөлөөллийн бүсд байгаа амьтны төрөл зүйлүүдийн талаарх нэмэлт мэдээллийг 2010 оны 8 сард эхлүүлсэн Оюу Толгойн амьтны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс авсан байна. Өмнө Говийн бүсд хамгаалах шаардлагатай төрөл зүйлүүдийн талаархи хэвлэл, судалгааны материалтай мөн танилцсан. Энэхүү онцгой төрөл зүйлүүдэд жороо тоодог (*Chlamydotis undulates*), идлэг шонхор (*Falco cherrug*), хулан (*Equus hermionus*) зэрэг орно. БТЗТҮ-ний хөтөлбөрт Ханбогд сумын жижиг хөхтөн амьтны судалгааг оруулсан бөгөөд судалгааны дүнг энэхүү суурь судалгааны бүлэгт нэгтгэн оруулсан болно.

Ашигласан гол эх сурвалжуудын жагсаалтыг дор үзүүлэв:

- Оюу Толгой төслийн БОНБНҮ, 1-р боть, Оюу Толгой-Гашуун Сухайт чиглэлийн зам, дэд бүтцийн зурвас, Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон Хяналт шинжилгээний хөтөлбөр, “Эко-Трейд” ХХК, 2004,
- Оюу Толгой төслийн БОНБНҮ, 2-р боть, Гүний Хоолой, Галбын Говийн гүний усны нөөцийг ашиглах, “Эко-Трейд” ХХК, 2005,
- Э. Л. Кларк, Ж. Мөнхбат, С. Дуламцэрэн, Ж. Э. М Бэйлий, Н. Батсайхан, С. Р. Б. Кинг, Р. Самъяа, М. Стюббе (зохиогчид, редакторууд) (2006). Монгол орны хөхтөн амьтдыг хамгаалах Үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө. Бүс нутгийн улаан номын жагсаалт, Боть 2, Лондон хотын Амьтан судлалын нийгэмлэг, Лондон,
- П. Казенски, Д. П. Шеехи, С. Волзер, Д. Е. Жонсон, Д. Лхагвасүрэн, С.М. Шеехи. 2006. Бэлчээрлэх орон зай байна уу? Хүний хүчин зүйлийн улмаас хуланд учирч буй аюул. Монголд зохион байгуулагдсан хэлэлцүүлгүүд, Зүүн Ази, Номхон далайн байгаль орчин, нийгмийн хөгжлийн яам, Вашингтон Д.С, Дэлхийн банк (2006 оны 9 сар),
- Оюу Толгой төслийн БОНБНҮ, 3-р боть, Олборлолт ба боловсруулалт, “Эко-Трейд” ХХК, УБ, 2006,
- Оюу Толгой төслийн дотоодын нисэх онгоцны буудлын байршлыг шилжүүлэх ажлын БОНБНҮ, “Эко-Трейд” ХХК, 2007 он,
- Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ, Ухаа худаг II үе шат, “Энержи Ресурс” ХХК, ERM ба Sustinability, 2009,
- Оюу Толгой төслийн Нийгэм, эдийн засаг, байгаль орчны дэд багц, Бодлого судлалын төв, Хүн амын сургалт, судалгааны төв, 2009,
- Оюу Толгой төслийн байгаль орчны жилийн тайлан, 2009 он,
- Ажил үүргийн тодорхойлолт-эхний хувилбар, 2010 оны 7 сарын 6-ны байдлаар –Говийн Бага Дархан Цаазат Газар болон түүний залгаа нутгуудын ан амьтны хяналт шинжилгээ, хамгааллын хөтөлбөрийг боловсруулах,
- Оюу Толгой төслийн Гүний хоолойн усан хангамжийн БОНБНҮ-ий Тайлан 2005-д оруулсан нэмэлт тодотгол. Боть II, “ЖЕМР Консалтинг” ХХК, 2010,

- Т. Валтон, 2010. Өмнө Говийн бүсийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ. Монголд зохион байгуулагдсан хэлэлцүүлгүүд, Зүүн Ази, Номхон далайн байгаль орчин, нийгмийн хөгжлийн яам, Вашингтон Д.С, Дэлхийн банк,
- Н. Батбаяр, Б. Батсүх, Б.Стеэйсий, Ж энд Эй Бронлич. Галбын Говь дахь устаж болзошгүй гол төрөл зүйлүүд: Бүсийн хөгжлийн хувилбаруудын төлөв байдал ба нөлөөллийн үнэлгээ. Улаан баатар: Дэлхийн банк, Бэрдлайф Интэрнэшнл ОУБ. 2011 оны 2 сар,
- Байнгын нисэх онгоцны буудлын БОНБНҮ, 2011 оны 2 сар,
- Н. Батсайхан, С. Баттулга, Д. Дармаа 2011. Оюу Толгой төслийн талбай болон Говийн Бага Дархан Цаазат Газрын “А” ба “Б” хэсгийн жижиг хөхтөн амьтдын төрөл зүйлийн судалгааны эхний тайлан. Улаанбаатар,
- П. Д. Каженский, П. Шеехи, С. Валцер, Д.Е. Жонсон, Д. Лхагвасүрэн ба С.М. Шеехи. 2006. Бэлчээрлэх орон зай байна уу? Хүний хүчин зүйлийн улмаас хуланд учирч буй аюул. Монголд зохион байгуулагдсан хэлэлцүүлгүүд, Зүүн Ази, Номхон далайн байгаль орчин, нийгмийн хөгжлийн яам, Вашингтон Д.С, Дэлхийн банк,
- П. Каженский, Р. Кюэн, Б. Лхагвасүрэн, С. Пийтш, В. Янг ба С. Валцер. 2011. Монгол орны Говь дахь Азийн хулангийн популяцийн холбоотой байдал. Байоложикал Консерватион 144:920-929.
- О. Ууганбадрах, С. Баттулга, Б. Ганбат, 2011. Хоёрдахь судалгааны сүүлийн тайлан. Оюу Толгой төслийн талбай болон Говийн Бага ДЦГ-ын “А” болон “Б” бүс дэхь жижиг хөхтөн амьтны төрөл зүйлүүд,
- *http//:www.zuil.mn.*

Уурхайн лицензит талбай

Оюу Толгой төслийн уурхайн лицензит талбай дахь хуурай газрын сээр нуруутан амьдын эхний ээлжийн суурь судалгааг 2002 онд явуулж, 2003 онд давтан явуулсан (“Эко Трейд”, 2006). Суурь судалгааг талбайн төвөөс 10-15 км-ийн радиуст явуулсан тул, лицензит талбай бүхлээрээ орсон төдийгүй ойр орчмын чухал нутгууд бас хамрагдсан байна.

Эко Трейд ХХК нь лицензит талбайд явуулсан амьтны аймгийн судалгааныхаа аргазүйг тайландаа дурьдаагүй. Энэ судалгаанд өдрийн тодорхой цагт ажиглалт явуулах мөн шугаман трансектийн аргаар судалгаа явуулах болон бусад тоон аргууд ашиглагдаагүй гэж үзэж байгаа бөгөөд үүний оронд судалгааны бүс нутагт өдрийн цагаар санамсаргүй явж байх замд амьтдыг тохиолдлоор харсан жишээнүүдийг тэмдэглэсэн байна. Иймэрхүү төрлийн судалгаа нь өдрийн хугацаанд идэвхтэй хөдөлгөөнд байдаг дунд болон том биетэй хөхтөн амьтад, шувууд, хэвлээр явагч зэрэгт чиглэсэн байх боловч шөнийн хэвлээр явагчид, (сарьсан багваахай зэрэг) жижиг хөхтөн амьтад, мөн усны амьтдыг төдий л тодорхой гарган харуулж чадаагүй. Бүх төрлийн амьтдыг олж ажиглах магадлалыг нэмэгдүүлэхийн тулд судалгааг боломжтой үед амьтдын идэш тэжээл элбэг газар, булаг шандуудыг устай (хөлдөөгүй) байх үед нь, үзэгдэх орчин сайн байх үеүдийг сонгон явуулсан. Судалгааны бүс дэхь янз бүрийн төрөл зүйлийн амьтдыг шууд ажиглах аргаар тодорхойлохоос гадна мөн гарсан мөр, нүх ичээ, араг яс, бусад нотлох баримтуудаар тодорхойлж байсан. Амьтны тархалтыг судалгааны талбай дахь ургамалжилт, газрын гадарга зэрэг дээр нь үндэслэн олж тогтоосон.

Мөн тухайн бүс нутагт амьтдын оршин байгаа байдал болон тоо толгойны талаар өргөн ойлголттой болохын тулд нутгийн малчид, хайгуулын геологичидтой (алс зайдуу газарт өрөмдлөгийн байршлуудад ажиллаж байгаа) ярилцлага хийсэн. Энэхүү аман ярианы нотолгоо нь хээрийн ажиглалт ба томоохон хөхтөн амьтдын нүүдэл, шилжилт хөдөлгөөний талаарх мэдээллийг боловсруулахад нэмэлт мэдээлэл болж байсан байна.

Усны цооногийн талбай ба ус дамжуулах шугам хоолой орчмын талбай

Гүний хоолойн орчмын талбайд хэд хэдэн удаа амьтны судалгаа (“Эко Трейд” компаний БОНБНҮ-үүдэд тусган оруулсан) явагдсан бөгөөд 2008 онд цуглуулсан шинэ мэдээллийг (Ж. Пунцагдулам, 2008) Оюу Толгой төслийн БОНБНҮ-ний 2-р Боть: Гүний хоолойн усан хангамжийн нэмэлт тодотголд оруулсан. Энэхүү судалгаанд ашигласан аргачлалыг өнөөгийн аль ч тайланд дурьдаагүй байна (JEMR, 2010). Гэвч тус аргачлалууд нь уурхайн лицензит талбай болон бусад дэд бүтцүүдийн талбайн ойр орчимд явуулсантай ижил буюу ойролцоо гэж үзэж байна.

Зам болон цахилгаан эрчим хүч дамжуулах шугам (Дэд бүтцийн зурвас)

Оюу Толгой - Гашуун сухайт чиглэлийн зам дагуух амьтны аймгийн судалгааг 2003 онд нүүрсний тээвэрлэлтийн замыг ашиглаж эхлэхээс өмнө хийсэн (“Эко Трейд”, 2004). Энэхүү судалгаанд ашигласан аргачлалыг судалгааны тайланд дурьдаагүй, гэвч Оюу Толгойн ажиллагсадтай хийсэн ярилцлагаас үзэхэд судалгааг явуулсан аргачлал нь уурхайн лицензит талбайнд хийсэнтэй ижил буюу ойролцоо гэж ойлгогдож байна. Судалгаа явуулсан талбайд тухайн бүс нутагт амьдарч байгаа нүүдэллэдэг том амьтдыг олж ажиглах магадлалыг ихэсгэх үүднээс зөвхөн тухайн замын маршрутын дагуу төдийгүй нилээд том газар нутгийг (жишээлбэл, Галбын говь болон ГБДЦГ-ын хэсгийг) хамарсан зурвас газрыг давхар (өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамын зурвасыг оруулаад) оруулсан. Уурхайн лицензит талбайд хийсэн судалгааны хувьд энэ бүс дэхь амьтдын төрөл зүйлүүдийг шууд ажиглах аргаар тодорхойлохоос гадна мөн гарсан мөр, нүх ичээ, араг яс, малчдаас амаар мэдээлэл авах зэрэг аргуудаар тодорхойлж байсан.

Нисэх буудал орчмын талбай

Төлөвлөж буй байнгын ажиллагаатай нисэх буудал орчмын газарт өнөөг хүртэл ямар ч амьтны судалгаа явагдаагүй. Иймд уг нисэх буудлын судалгааны талбайн орчмын амьтны аймгийн тухай мэдээг байнгын нисэх буудлын талбай орчмын амьдрах орчны мэдээн дээр тулгуурласан. Тус амьдрах орчин нь түгээмэл бөгөөд бусдаас онцгой ялгарах амьтны бүлгэмдэл байдаггүй байна.

2011 онд хийгдсэн жижиг хөхтөний судалгаа

2011 онд хийгдсэн Биологийн төрөл зүйлийн түргэвчилсэн үнэлгээний хүрээнд дотоодын хөхтөн судлаачид (Батсайхан, ба бусад 2011, Уганбадрах, ба бусад 2011) Оюу Толгой төслийн нөлөөллийн бүсэд жижиг хөхтөн амьтдын судалгааг хоёр удаа хийсэн. Өмнөговь аймгийн Ханбогд суманд жижиг хөхтөн амьтдын судалгааг явуулсан бөгөөд ГБДЦГ-ын “А” хэсгийн зүүн хэсэг, мөн “Б” хэсгийн баруун хэсгийг судалгаанд хамруулсан. Жижиг хөхтөн амьтдын түүврийг гаргахын тулд судалгаанд өгөөш бүхий хавх тависан ба “Sherman” төрлийн хайрцагт хавхыг 9 газар байрлуулсан. Нэмэлт гурван байрлалд жижиг хөхтөн амьтдын судалгаа хийсэн бөгөөд эдгээр нь Оюу Толгой-Гашуун Сухайт чиглэлийн замыг хөндлөн огтлож, замын зурваст перпендикуляр өнцгөөр чиглэсэн 5 км урт шугаман трансект зурвас байв.

7.2.3 Мэдээллийн хязгаарлагдмал байдал

Төслийн нөлөөллийн бүсийн хувьд цуглуулсан биологийн мэдээлэл нь байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээнд ерөнхийдөө нийтлэг тохиолдож байдаг хэд хэдэн хүндрэлүүдээс хамааралтай байв. Үүнд:

- Цаг хугацааны хязгаарлалтууд
- Орон зайн хязгаарлалтууд:
    - Дээжлэлт хийх цэгүүд болон шугаман трансектийн талбай нь амьдрах орчин болон тухайн зүйл амьтны тархах орон зайг мөн нүүдлийн амьтдын шилжилт хөдөлгөөний замнал, төслийн нөлөөллийн бүс болон өргөн уудам газарт энд тэнд тархсан амьдрах орны өөр өөр хэлбэрүүдийг хангалттай хамрахгүй байх,
- Ангилал зүйн хязгаарлалтууд:
    - Мэдээлэл бага цуглуулах, орон нутагт музей байхгүй байх, гадаадын ном зохиол ашиглах боломж хязгаарлагдмал, улсын хэмжээн дэх зарим төрөл зүйл амьтад жишээлбэл, сээр нуруутан амьтад, *Phrynocephalus* гүрвэл зэргийн талаар мэдлэг муу байгаа зэрэг нь энэхүү БОННБҮ болон холбогдох судалгаануудад амьтны төрөл зүйлүүдийг тодорхойлох үйл явцад тодорхойгүй байдлыг үүсгэж байна,
- Ажиглалтын хязгаарлалтууд:
    - Мэдээ цуглуулсан цэгийн тоо нь тухайн бүс нутагт ажиллаж буй судлаачид харьцангуй цөөн байгаа, орон нутгийн цаг агаарын нөхцөл байдал мөн бусад хүчин зүйлүүдтэй холбоотойгоор амьтдын төрөл зүйлүүдийн тархац, элбэгшилзэрэг нь орон зай- цаг хугацааны хувьд ялгаатай байв,

- Ихэнхи ургамлын төрөл зүйлүүдийн тархац, элбэгшлийг муу баримтжуулсны улмаас тэдгээрийн хамгаалах статусын талаар зөвхөн таамаглалын шинжтэй үнэлгээг хийх боломж олгож байна.

Эдгээр хязгаарлалтууд нь мэдээллийг тайлбарлах тал дээр урьдаас сэрэмжтэй хандаж ажиллах, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар шийдвэр гаргах үйл явцад анхааралтай байх шаардлагыг бий болгож байгаа юм. Суурь судалгааг хангалттай хийгээгүй мөн зарим нэн тэргүүнд хамгаалах шаардлагатай чухал зүйлүүдийг тодорхойлоогүй үлдсэн байж болох боловч Биологийн төрөл зүйлийн түргэвчилсэн үнэлгээний ажлын хүрээнд хийсэн Чухал Амьдрах Орчны Үнэлгээг ургамлын ихэнхи төрөл зүйлүүдийн тархацын тухай хийгдсэн буюу хийгдэж буй зураг дээр үндэслэн боловсруулсан. Нэн тэргүүнд хамгаалах шаардлагатай зүйлүүдийг бүрэн багтаах явдлыг хангахын тулд дотоодын болон гадаадын судлаачдын саналыг мөн авч үзсэн. 2012 онд боловсруулагдах хяналт шинжилгээ болон үнэлгээний протокол нь илүү сайжруулсан суурь судалгааны шаардлагыг мөн тусгах болно.

7.3 СУДАЛГААНЫ ҮР ДҮН – УРГАМАЛЖИЛТ БА УРГАМЛЫН АЙМАГ

7.3.1 Фитогазарзүйн болон эко бүсийн тогтолцоо

Дэлхийн байгаль хамгаалах сангийн (*ДБХС*) эх газрын эко бүсийн тухай ангиллын дагуу (Олсон, 2001), Оюу Толгойн уурхайн лицензит талбай нь Дорнод Говийн цөлөрхөг хээр (баруун хойд талаараа) болон Алшааны тэгш өндөрлөг Говь цөлийн экобүсүүдийг дамнан оршдог (С хавсралтын 21-р зургийг үзнэ үү). Чимэд-Очирын хийсэн судалгаагаар (2010), төслийн нөлөөллийн бүс нь Монгол орны өмнөд хэсэгт хагас сая хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрийг хамарсан Төв Азийн Говь цөлийн эко бүсийн Дорнод Говийн цөлөрхөг дэд бүсэд оршиж байгаа юм (Зураг 7.1).

Зураг 7.1: Төв Азийн Говь цөлийн эко бүсэд орших Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ, эко системүүд



7.3.2 Өмнө Говийн ургамлын бүлгэмдлүүд

Төслийн НБ дэхь ургамлан бүрхэвч нь голчлон намхан ургасан халуун болон хүйтэнд тэсвэртэй бутлаг ургамлууд, олон наст өвс, нэг наст ургамлуудын янз бүрийн бүлгэмдлүүдээс бүрддэг. Эдгээр ургамлын бүлгэмдлүүд нь хөрсний бүтэц, гүн, химийн найрлага, чийгшлийн түвшинд нөлөө үзүүлэх хүчин зүйлүүд болох геологи, геоморфологи, усны урсацын голдирол зэргээс ихээхэн хамааралтай байдаг. Газар нутгийн ихэнх хэсэгт нь мод байхгүй, гэвч газрын доод давхаргын бүтэц нь хөрсний чийгшлээр элбэг буюу бага гүний усны нөөцтэй газруудад мод бут элбэг байдаг. Ургамлан бүрхэвч ерөнхийдөө бага бөгөөд (циано бактер болон хаг өвснөөс голчлон бүрдэх) криптобиотик давхарга нь хөрсний органик бодисыг хадгалах, элэгдэл эвдрэлээс сэргийлэх ач холбогдолтой байдаг. Зэрлэг болон гэрийн тэжээмэл томоохон сүүн тэжээлтэн амьтдын сүргийг

тэжээж тэтгэж байдаг ургамлын бүрхэвчийг энэхүү Бүлэг болон Бүлэг B7b: Экосистемийн үйлчилгээ гэсэн хэсэгт авч үзэх болно.

Өмнө Говийн ургамлын аймаг, ургамлан бүрхэвчийг Германы ургамал судлаачид, геоэкологичид ялангуяа В. Хилбиг. Х. вон Вехрден, К. Веще болон тэдгээрийн хамтрагчид сүүлийн арваад жил сайтар судалсан байдаг. Мөн түүнчлэн Ж. Санжид зэрэг Монголын мэргэжилтнүүд, Оюу Толгой төслийн биологичид 2004 оноос хойш төслийн НБ-д явуулсан байнгын судалгаа, хяналт шинжилгээний ажлаараа ихээхэн хувь нэмэр оруулсан юм.

Хилбиг, Тунгалаг нар (2006) төслийн НБ-ээр дайрах зурвасыг хамруулсан Өмнө Говийн ургамлын бүлгэмдлүүдийн хээрийн судалгааны тайлан илтгэлийг боловсруулсан. Тэд ургамлын 20 бүлгэмдлийг тогтоосон бөгөөд үүнийг 1-р Хавсралтанд үзүүлсэн болно.

Вон Вехрден (2009) Говийн бага дархан цаазат газрын (ГБДЦГ) баруун (“А”) болон зүүн (“Б”) хэсгүүдийг оруулаад тус бүс нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт 10 х 10 м-ийн хэмжээтэй 1400 гаруй судалгааны талбайнуудад хээрийн судалгаа (1996-аас 2005 он хүртэл) явуулсны үндсэн дээр өмнөд Монголын Говийн ургамлын бүрлгэмдлүүдийн тухайд хамгийн сүүлийн үеийн үнэлгээг явуулсан байна. Тэд ургамлын аймгийг “ерөнхийдөө ядмаг” (өөрөөр хэлбэл, харьцангуй бага тооны төрөл зүйлтэй), “цөөхөн тооны” нутгийн унаган ургамалтай хэмээн тодорхойлсон. Өмнө Говийн ургамлын төрөл зүйлийн хамгийн их олон янз байдал уулархаг газруудад байдаг байна. Эдгээр зохиогчид ургамлын 28 бүлгэмдлүүд, 18 дэд бүлгэмдлүүд буюу хувилбаруудыг тодорхойлсон бөгөөд эндээс 11 нь тал хээр, хөндийг бодвол арай илүү хур тунадастай уулархаг газруудад зөвхөн ургаж байна. Уулархаг газраас өөр бусад газруудад орших ургамлын бүлгэмдлүүдийг 1-р Хавсралтанд үзүүлсэн.

Вон Вехрден (2009)-ий тодорхойлсон ургамлын тэдгээр бүлгэмдлүүдийн дотор хамгаалах шаардлагатай төрөл зүйл байгаагүй боловч, түлшний зориулалтаар байнга түүж ашигладаг заг модонд (модыг тээвэрлэх машины тоо ихэссэний улмаас) аюул нүүрлэж байгааг тогтоосон. Х. вон Вехрден (Чухал амьдрах орчны тухай TBC/FFI Техникийн тайланд дурдсанчлан) төслийн НБ-ийн дотор болон ойр орчмын ургамалжилт болон ургамлын ургах орчны хамгааллын статусын талаар дараахь нэмэлт тайлбаруудыг оруулсан:

- *“Хуурай уур амьсгалтай газрын түр урсацын голдирол сайр дагуу ургадаг хайлаас модны бүлгэмдэл нь ихэвчлэн энэ газар л төвлөрсөн байв. Тэдгээрийн өрнө зүг дэхь тархац (зөвхөн Говь Гурван Сайханы орчим хүрч) нь үргэлж хязгаарлагдмал байсан бөгөөд одоо дорно болон өмнөд зүг рүү тархах тархац нь хүний хүчин зүйлийн улмаас ихээхэн буурах болсон (Веше, 2011-г үз). Иймээс энэхүү судалгааны нэгж нь дэлхийн хэмжээнд маш чухал энэ төрлийн амьдрах орчныг илэрхийлж байна.”*

- *“Уст цэгүүд нь Монгол орны хуурай уур амьсгалтай өмнөд хэсэгт туйлын ховор байдаг бөгөөд энэхүү анализ хийсэн газарт: (i) хэд хэдэн том хэмжээтэй бөгөөд чухалд тооцогдох түр тогтсон нуур, тойром; (ii) олон тооны булаг шандууд (Ундайн голын сайрд орших гэх мэт). Түр зуурын нуур, тойрмын талаарх мэдээлэл хомс байгаа ч бага гүний уст давхарга газрын гадаргад ойрхон байгаа тодорхой хонхор хотгор газруудад тэдгээр нь төвлөрөх буюу эсвэл ойр орчмын уул толгодоос хурын усны сайр садаргаар ус хотгор газруудад урсан орж ирдэг газар оршдог байна. Энэхүү үзэгдэл Говийн Бага ДЦГ-ын “Б” хэсэгт ихэвчлэн тохиолдох ба мөн “А” хэсэгт (газрын хотгор гүдгэр харьцангуй бага Галбын Говьд арай бага)тохиолдоно. Энэхүү уст давхаргаас үүсэлтэй баян бүрдүүд тогтмол байршлуудад бий болж байдаг ч, жил болгон (таамгаар 2-4 жил тутамд) үүсдэггүй. Хэдий тийм боловч тэдгээрийн орчимд маш өөр өөр төрлийн ургамлын бүлгэмдлүүд ургадаг. Энэхүү ургамлын бүлгүүд нь үүсч бүрэлдэхдээ олон мянган нүүдлийн шувуудыг (эргийн шувууд, тогоруу гэх мэт) тэтгэж байдаг. Тэгэхээр энэхүү баян бүрдүүд нь судалгааны нэгжийн маш чухал өвөрмөц онцлог болдог бөгөөд Монгол орны хувьд чухал хэсэг юм."*

- *“ ... судалгааны нэгжид байгаа зарим заган ой ихээхэн сонирхолтойамьдрах орчны хэлбэрийг харуулж байна тухайлбал эндер бусын өндөр (>2 м), өргөн мод тохиолддог байна.”*

- *“Судалгааны нэгжид хэд хэдэн боржин чулууны гаршууд илэрдэг. Энэ усгүй хуурай газар эдгээрийн бий болгож байгаа энгийн бус нөхцөл нь энэхүү гаршууд дээр ургаж байгаа ургамлууд нийлээд өвөрмөц юм. Энэхүү гаршууд нь Монгол орны өмнөд хэсэгт тийм ч*

түгээмэл бус байдаг ба энэхүү судалгааны нэгж нь эдгээр амьдрах орчны бүрдэлийн хувьд чухал газрыг багтааж байна."

Гүний Хоолойн цооногийн талбай/ус дамжуулах шугам хоолойн зурвас, уурхайн лицензит талбай, дэд бүтцийн зурвас зэргийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд "Эко-Трейд" компаний тодорхойлсон, доор өгүүлж буй ургамлын бүлгэмдлүүд нь ерөнхийдөө Хилбиг, Тунгалаг (2006), Вон Вехрден (2009) нарын тус бүст тодорхойлсон ургамлын хэвшлүүдтэй нийцэж байна.

Янз бүрийн БОНБНҮ-үүдэд дурьдсан төрөл зүйлүүд, тэдгээрийннэмэлт тодотгол тайлангууд болон Оюу Толгой компаниас хэрэгжүүлдэг хяналт шинжилгээний ажлууд дээр тулгуурлан Оюу Толгойн НБ-д бүртгэгдсэн ургамлын 211 зүйлийн жагсаалтыг 2-р хавсралтанд үзүүлсэн ба үүнийг Миссури мужийн ургамал судлалын цэцэрлэгт хүрээлэнгийн мэдээллийн сан, Монгол улсын ургамлын аймгийн Виртуаль танилцуулга, "Flora of China" болон Олон улсын ургамлын нэрийн индексээс гаргасан өнөөгийн ангилал зүйн шаардлагыг тусгаж шинэчилсэн. Төслийн НБ-ийн ургамлын аймаг нь гол төлөв хагас хуурай болон хуурай говь цөлийн мөн цөлөрхөг хээрийн экосистемийн хэв шинжтэй бөгөөд энд зүйлийн олон янз байдлын хувьд баялаг овгууд болох Гагадайн овог (*Amaranthaceae*), Гэсэртний овог (*Asteracaeae,* үүнд мөн *Chenopodeceae*- луультан багтана), Буурцагтны овгийн (*Fabaceae*) ургамлууд ургадаг.

7.3.3 Гүний хоолойн усны цооногийн талбай / ус дамжуулах шугам хоолойн талбай

Гүний хоолой цооногийн талбай болон ус дамжуулах шугам хоолойн талбайд хийсэн судалгаанаас ургамалжилтийн гурван өөр ангиллыг тодорхойлсон. Энэхүү ангиллын нэр, ургалт нь өөр өөр боловч, тодорхойлсон төрөл зүйлүүд нь төстэй байв.

Ж. Санжидийн 2004 онд явуулж, Оюу Толгой төслийн Гүний хоолой, Галбын Говийн Бүсийн Гүний Усны Нөөцийн Ашиглалтын судалгаанд ("Эко Трейд", 2005) дараахь ургамлын бүлгэмдлүүдийг тодорхойлсон:

- ***Уулсын ургамалжилт:*** Энэхүү ургамлын хэвшил нь далайн түвшнээс дээш 904-1012 м-ийн өндөрт өргөгдсөн /далайн түвшнээс дээш дунджаар 877 м-ийн өндөрт өргөгдсөн байдаг хөндийтэй харьцуулбал/ Гүний Хоолойн зүүн, хойд талын нам уулсаар тохиолдоно. Говь цөлийн уулын ургамлын хэвшинжийг Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*),Төлөгчдүү боролз (*Ajania achilloides*), Алтан харгана (*Caragana leucophloea*), Бариулт бүйлэс (*Amygdalus pedunculata*) зэрэг намхан бутнууд бүрдүүлж байв. (Зураг 7.2). Энд ургамлан бүрхэвчийн нягтшил 14% орчим буюу судалгаанд хамрагдсан 1х1м хэмжээтэй ургамалжилтын торонддунджаар 1.5-2 ургамал ногдож байв.
- ***Нам уулс, аараг, толгодын ургамалжилт:*** Гүний Хоолойн баруун, төв, зүүн өмнөд хэсгүүд дэхь дов толгод, нам уулс нь тал хөндийн түвшинээс 30-50 м-ийн өндөрт оршдог бөгөөд үүнд Ар цавчир, Хүнхэр заг, Талын бор овоо орно. Энэхүү амьдрах орчинд ургах ургамал ихэнхдээ намхан (10 – 20 см) бөгөөд сийрэг бөгөөд ургамлан бүрхэвч нь 15% орчим байв. Судалгаанд хамрагдсан дов толгодод голлох ургамлууд нь Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*) (Зураг 7.3), Бор бударгана (*Salsola passerina*), Шарилж (*Artemisia xerophytica*) ба Регелийн шар мод (*Sympegma regelii*) зэрэг юм. *Kraschennikovia ceratoides* мөн зарим газар зонхилох ургамал байв.
- ***Дэнж, тэгш өндөр газрын ургамалжилт*:** Дэнж, тэгш өндөрлөг газар нь эргэн тойрон оршиж буй газраас 30-50 м-ийн өндөр гадарга дээр оршдог. Энэхүү ургамалжилтын хэвшинж нь Ханбогдын ойролцоо орших Их, Бага булаг, Ухаа заг, Баян заг, Хонгор шанд, Улаан овоо, Хил усны овоо зэрэг газруудад оршдог. Дэнж, тэгш өндөрлөг газарт Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*) зонхилсон мөн Зүүнгарын хазаар өвс (*Cleistogenes songorica*), Ортууз (*Oxytropis aciphylla*), Говийн хялгана (*Stipa gobica*) [6]зэрэг төлөөлөлтэй цөлөрхөг хээрийн бүсийн сийрэг ургамал бүрхдэг (~10% орчмыг бүрхдэг) бүхий ургамалжилт байна.
- ***Цөлөрхөг хээрийн ургамалжилт*:** Энэхүү ургамалжилтийн хэвшинж нь Гүний Хоолойн бүсийн 60 орчим хувийг бүрхдэг бөгөөд Гүний Хоолойн төвд Бүлтгэр хонгор овооны зүүн хөндий, Зүүн Баятын худаг, Амтгайн тойром, түүний эргэн тойрны тэгш говь цөлийн бус нутгуудад тохиолдож байв. Цөлөрхөг хээрийн ургамалжилтанд шарилж (*Artemisia*

[6] *Stipa tianschanica* хэмээх нэрээр бүртгэгдсэн. П.С.Куо ба И.Х. Сан

arenaria)[7], Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*) зонхилж байв. Бусад голлох төрөл төрөл зүйлүүдэд Монгол хулан хойрго (*Brachanthemum mongolicum*), түжгэр баглуур (*Potanina mongolica*), бор бударгана (*Salsola passerina*), сибирь хармаг (*Nitraria sibirica*), Монгол сонгино (*Allium mongolicum*), Толгодын бударгана (*Salsola collina*) зэрэг багтана. Цөлөрхөг хээрийн ургамалжилтад давссаг зүйлүүд ордог ба өндрөөрөө дөнгөж 10-20 см хүрдэг. Ургамлан бүрхэвч нь сийрэг (газрын гадаргын ойролцоогоор 10% нь) бөгөөд 25х25 м хэмжээтэй ургамалжилтын судалгааны торонд 190 ургамлын дундаж нягтралтай байна.

- ***Гуу жалга, голын хуурай сайр орчмын ургамалжилт*:** Гуу жалга, түр зуурын усны урсгал бүхий сайрууд олон байдаг бөгөөд томоохон нь Ухаа загийн гол, Баян загийн гол, Их, Бага булаг, Булаг баян зэрэг юм. Эдгээр говь цөлийн нугын орчин нь Бунгийн цахилдаг (*Iris bungei*), Гялгар дэрс (*Achnatherum splendens*), хялгана (*Stipa glareosa*)[8], Монгол сонгино (*Allium mongolicum*), Таана (*Allium polyrhizum*) Ширэг улалж (*Carex duriuscula*) зэрэг ургадаг. Цөөн тооны хайлаас мод (*Ulmus pumila*) Гүний хоолойн сайруудад тохиолддог. Бор бударгана (*Salsola passerina*), ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*), зүүнгарын бутаргана (*Reamuria soongorica*), сибирь хармаг (*Nitraria sibirica*) бүхий ургамлын бүлгэмдлүүд сайруудаас зайтай газарт бүртгэгдсэн байдаг. Ургамлан бүрхэвч нь ихэнхдээ сийрэг (газрын гадаргын ойролцоогоор 12 орчим хувь), 1х1м ургамалжилтын тор бүрд 1.1-1.8 ургамал ногдож байв.
- ***Элсэн манхан*:** Хэд хэдэн цуварсан элсэн манханы тогтоц Гүний Хоолойн цооногийн талбайн төв болон зүүн хойд чигт бүртгэгдсэн байна. Томоохон манхануудь нь Хэмгийн, Гүний, Улаан эргийн, Хүнхэр загийн манхануудь зэрэг ба элсэн манханы ургамалжилтийн бүлгэмдэл судалгааны бүс нутгийн 20 орчим хувийг эзэлж байсан. *Agriophyllum squarrosum* ба *Thymus* sp. зэрэг ургамлууд нь элсэн манханы хөрсөнд зонхилон тохиолддог ба зүүнгарын хазаар (*Cleistogenes songorica*) хааяа тохиолдож байв. Сухай болон модлог ургамлууд томоохон элсэн манхануудад хааяахан тохиолддог.

Зураг 7.2: Бариулт бүйлэс (Amygdalus pedunculata), Оюу Толгой төслийн Нөлөөллийн Бүс, 2011 оны 5 сар

[7] *Arenaria tscherneviana* хэмээх нэрээр бүртгэгдсэн. Бесер

[8] *Stipa caucasica* subsp. *glareosa* (P.Smirn.) хэмээх нэрээр бүртгэгдсэн. Цвелев.

Зураг 7.3: Ахар навчит баглуур (Anabasis brevifolia), Оюу Толгой төслийн Нөлөөлийн Бүсд түгээмэл тохиолддог жижиг бутлаг ургамал

Улмаар Оюу Толгой төслийн Гүний хоолойн цооногийн талбай, Ус дамжуулах хоолойн БОНБНҮ-ний тайланд (“Эко Трейд”, 2009) дараах геоморфологийн нэгжүүд, ургамлын бүлгэмдлүүдийг дурьдсан байна:

Цөлөрхөг хээр (**Нам дов толгод хоорондын тал хөндийн ургамалжилт**) – зонхилогч төрөл зүйлүүдэд баглуур (*Anabasis brevifolia*), зүүнгарын бутаргана (*Reamuria soongorica*), Бор бударгана (*Salsola passerina*), хармаг (*Nitraria sibirica*) зэрэг орно. Ургамлын гол бүлгэмдлүүд нь:

- Бор бударгана (*Salsola passerina*) - хармаг (*Nitraria sibirica*)
- Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*) - Бор бударгана (*Salsola passerina*) зэрэг юм.

Говь цөл – Зонхилогч зүйлүүдэд Регелийн шар мод (*Sympegma regellii*), баглуур (*Anabasis brevifolia*), бор бударгана (*Salsola passerina*), зүүнгарын бутаргана (*Reamuria soongorica*), хулан хойрго (*Potaninia mongolia*), хотир (*Zygophyllum xanthoxylon*) зэрэг ургамлууд багтана. Ургамлын гол бүлгэмдлүүд нь:

- Зүүнгарын бударгана (*Reamuria soongorica*) – н дэд бүлгэмдэл
- Хялгана (Stipa) – ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*)
- Хулан хойрго (*Potaninia mongolia*) – сибирь хармаг (Nitraria sibirica) зэрэг юм.

Нам дов толгод – Зонхилогч төрөл зүйлүүдэд бариулт бүйлс (*Amygdalus pedunculata*), Монгол сонгино (*Allium mongolica*), хотир (*Zygophyllum xanthoxylon*), баглуур (*Anabasis brevofolia*), шинэсэрхүү бударгана (*Salsola laricifolia*), бор бударгана (*Salsola passerina*), модлиг бударгана (*Salsola arbuscula*), зүүнгарын бударгана (*Reamuria soongorica*), регелийн шар мод (Sympegma regelii), Пеллетийн шивэлз (*Ptilagrostis pelliotii*) ба Преживальскийн зээргэнэ (*Ephedra przewalskii*) зэрэг орно.

Түр урсацын сайр садарга, шал тойром - Давссаг болон чийгсэг ургамлууд голчлон ургадаг бөгөөд үүнд гялгар дэрс (*Achnatherum splendens*), навчирхаг бадаргана (*Kalidium foliatum*), гоолиг бадаргана (*Kalidium gracile*), зүүнгарын бутаргана (*Reamuria soongorica*), сибирь хармаг (*Nitraria sibirica*) зэрэг ордог. Голын хуурай сайр, гуу жалгын дагуу сибирийн хайлаас (*Ulmus pumila*) ургасан байдаг.

Элсэн хунгартай хотгор, хөндийн ургамалжилт (заган шугуй) – Энэ нэгжид заг (*Haloxylon ammodendron*), сибирь хармаг (Nitraria sibirica), шар хотир (*Zygophyllum xanthoxylon*) зэрэг ургамлууд зонхилдог.

Эцэст нь Гүний хоолойн БОНБНҮ (JEMR, 2010)-д оруулсан нэмэлт тодотголд дараахи ургамлын бүлгэмдлүүдийг тодорхойлсон байдаг (Зураг 7.4):

1. Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia)* - бор бударганат (*Salsola passerina*) бүлгэмдэл бүхий нам дов толгод
2. Хулан хойрго (*Potaninia mongolica*) -регелийн шар мод (*Sympegma regelii*) –бор бударганат (*Salsola passerina*) бүлгэмдэл бүхий дов толгодын хоорондох хөндий
3. Говийн хялгана (*Stipa gobica*) - ахар навчит баглуурт (*Anabasis brevifolia)* бүлгэмдэл бүхий дов толгодын хоорондох тэгш тал
4. Тэсэг (*Eurotia ceratoides*[9]) - ахар навчит баглуурт (*Anabasis brevifolia)* бүлгэмдэл бүхий намхавтар уулс ба дов толгодын хоорондох тэгш тал
5. Шинэсэрхүү бударгана (*Salsola laricifolia*)– бариулт бүйлэст (*Amygdalus pedunculata*) бүлгэмдэл бүхий нам дов толгод
6. Хулан хойрго (*Potaninia mongolica*) - ахар навчит баглуур (*Anabasis brevifolia)* – сибирь хармагт (*Nitraria sibirica*) бүлгэмдэл бүхий нам уулс хоорондох тэгш тал, жижиг дов толгод
7. Сибирь хармаг (*Nitraria sibirica*) - зүүнгарын бутаргана (*Reamuria soongorica*), бүхий нам дов толгодын хоорондох хөндий
8. Бор бударгана (*Salsola passerina*) - зүүнгарын бутаргана (*Reamuria soongorica*) - сибирь хармаг (*Nitraria sibirica*) - шар хотир (*Zygophyllum xanthoxylon*) бүхий нам дов толгод
9. Зүүнгарын бутаргана (*Reamuria soongorica*)- сибирь хармаг (*Nitraria sibirica*) - загт (*Haloxylon ammodendron*) бүлгэмдэл бүхий элст хөндий
10. Говийн хялгана (*Stipa gobica*) - хазаар өвс (*Cleistogenes songorica*) - ахар навчит баглуурт (*Anabasis brevifolia)* бүлгэмдэл бүхий голын хуурай сайр

[9] Krascheninnikovia ceratoides (L.) Gueldenst. Нэрээр бүртгэгдсэн.

Зураг 7.4: Гүний Хоолойн цооногийн талбай ба ус дамжуулах хоолойн орчмын ургамлын бүлгэмдлүүд (ЖЭМР, 2010)



7.3.4 Байнгын нисэх буудлын талбай

OSMT-н судалгаагаар бол (2011), төлөвлөж буй байнгын нисэх буудлын талбай нь сийрэг ургамалтай, говь цөлийн болон цөлөрхөг хээрийн завсрын ургамлын бүлгэмдлүүдтэй байх бөгөөд гуу жалга ихтэй газраа ургамал илүү нягт ургасан, чулуу хайрга бүхий дов толгодод ургамал бага нягтралтай ургасан байдаг. OSMT-н судалгаагаар байнгын нисэх онгоцны буудлын талбайд тал хөндийн ургамалжилт, голын хуурай сайр нугын ургамалжилт гэсэн хоёр томоохон ургамалжилтийн хэвшлийг тодорхойлсон байна (2011). Энэхүү ургамалжилтын хэвшлүүдийг доор илүү дэлгэрэнгүй авч үзэв.

- ***Тал хөндийн ургамалжилт:*** Энэхүү ургамалжилтын хэвшилд бутлаг ургамал болох ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*) ба өвслөг ургамал болох Говийн хялгана (*Stipa glareosa*) зонхилдог бөгөөд бусад бор бударгана (*Salsola passerina*), амманы сэдэргэнэ (*Convolvulus ammanii*), (*Dondostemon senilis*) ба толбот бэрээмэг (*Arnebia guttata*) гэх зэрэг бусад ургамлын зүйлүүд толгодорхог газруудаар ургаж байв. Нам доор хотгор газруудад шинэсэрхүү бударгана (*Salsola laricifolia*), амманы сэдэргэнэ (*Convolvulus ammanii*), регелийн шар мод (*Sympegma regelii*), өргөст ортууз (*Oxytropus aciphylla*), төлөгчдүү боролз (*Ajania achileoides*), Зүүнгарын бутаргана (*Reamuria soongorica*), сайрын хялгана (*Stipa glareosa*), хазаар өвс (*Cleistogeners soongorica*), өтлүү багдай (*Dontostemon senilis*), хунчир (*Astragalus* sp.), толбот бэрээмэг (*Arnebia gutata*) зэрэг төрөл зүйлүүд мөн бүртгэгдсэн. Тал хөндийн ургамалжилтын хэвшлийн ургамлан бүрхэвч нь бүхэлдээ сийрэг (ойролцоогоор 5-10%) байсан бөгөөд хөрсний гадаргуу нь чулуулаг хайргаар бүрхэгдсэн байв. Жижиг дов толгодод ургамалжилт (1-5%-ийн бүрхэвч) нь хотгор/хөндий газруудыг (7-10%) бодвол илүү сийрэг хэв шинжтэй байна.
- ***Голын хуурай сайр/ нугын ургамалжилт*:** Энэхүү ургамалжилтын хэвшил нь байнгын нисэх буудлын судалгааны бүсийн түр урсацтай сайр сайдаргаар ургадаг бөгөөд хармаг (*Nitraria sp.*) ба дэрс (*Achnatherum sp*) голчлон ургадаг. Бусад бүртгэгдсэн төрөл зүйлүүдэд бор бударгана (*Salsola passerina*), амманы сэдэргэнэ (*Convolvulus ammanii*), завсрын ноцоргоно (*Lappula intermedia*), толбот бэрээмэг (*Arnebia gutata*), ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*), регелийн шар мод (*Sympegma regelii*), *Pxytropus aciphylla*, төлөгчдүү боролз (*Ajania achileoides*), зүүнгарын бутаргана (*Reamuria soongorica*), сайрын хялгана (Stipa glareosa), хазаар өвс (*Cleistogeners soongorica*), өтлүү багдай (*Dontostemon senilis*) ба хунчир (*Astragalus* sp.) зэрэг орно. Ургамлан бүрхэвч нь ерөнхийдөө сийрэг (5-10%), унаж хатсан навч ургамал элбэг байв.

7.3.5 Уурхайн лицензит талбай

Уурхайн лицензит талбайд нарийвчилсан судалгаа, ургамалжилтийн хяналт шинжилгээг (“Эко Трейд”, 2006; Оюу Толгойн ургамлын хяналт шинжилгээний тайлан) явуулсан бөгөөд энд ургамалжилт нь ерөнхийдөө сийрэг (газрын гадаргын <5%) бөгөөд ганд тэсвэртэй намхан (>0.5 м) олон наст бутлаг ургамлуудаас бүрддэг. Нэг наст ургамал, бусад өвслөг ургамлын төрөл зүйлүүд улирлын чанартай хур тунадас орсны дараагаар гарч ирдэг. “Эко Трейд” (2006) компани лицензит талбай дахь газрын хэв шинжүүд дээр тулгуурлан хамгийн түгээмэл 4 ургамалжилтын хэлбэрүүдийг тодорхойлсон:

- ***Дэнжийн бүлгэмдэл*** нь Оюу Толгойн лицензит талбайн 80%-ийг эзлэх бөгөөд бор бударгана (*Salsola passerina*), зүүнгарын бутарга на (*Reamuria soongorica*), ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*), регелийн шар мод (*Sympegma regelii*) зэрэг цөл хээрийн нийтлэг ургамлууд зонхилдог. Дэнжийн ургамалжилтийн бүлгэмдэлд онцгой нэг жижиг газар ажиглагдсан нь сайрын хялгана (*Stipa glareosa*), таана (*Allium polyrhizum*) зэрэг цөлөрхөг бүсийн ургамлууд гол төрөл зүйлүүд болж байв. Төслийн талбайн дотор болон ойр орчмын Дэнжийн бүлгэмдэлд Алтай Говь, Зүүнгарын Говь зэрэг бусад цөлийн хээрийн бүсүүдийн дэнжийн бүлгэмдлүүдийг бодвол илүү олон төрөл зүйлүүд ажиглагдаж байв.
- ***Толгодын бүлгэмдэл*** нь өндөр өргөгдсөн хад чулуурхаг, нимгэн хөрстэй газруудад тохиолддог. Энэхүү амьдрах орчин нь лицензит талбайн 5 орчим %-д тохиолддог. Толгодын ургамалжилтийн бүлгэмдлийн зонхилогч ургамлуудад ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*), регелийн шар мод (*Sympegma regelii*), буурцгана (*Chesneya macrantha*),

бор бударгана (*Salsola passerina*), зүүнгарын бутаргана (*Reamuria songoorica*), хулан хойрго (*Potaninia mongolica*) зэрэг багтдаг (Зураг 7.5).

- ***Хуурай сайрын бүлгэмдэл*** нь лицензит талбайн 1 орчим хувийг эзэлдэг бөгөөд хамтдаа Ундайн голыг бүрэлдүүлж байгаа хэд хэдэн түр урсацын сайр садарга орчимд илэрдэг. Энэхүү бүлгэмдэлд бор бударгана (*Salsola passerina*), ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*), зүүнгарын бутаргана (*Reamuria soongorica*), сибирь хармаг (*Nitraria sibirica*) зэрэг намхан бутлаг ургамлууд зонхилж байсны дээр Сибирийн хайлаас мод (*Ulmus pumila*) тохиолдож байв. Сибирийн хайлаас нь өмнө Говийн бүсийн хуурай орчинд амьдрах хэд хэдэн зохилдлоготой байдаг. Хэвтээ тэнхлэгт өргөн тархсан үндэсний систем нь аллювийн гүехэн утс давхаргад байгаа хөрсний усыг татах, голын хурдсан дахь хөрсний чийгт хүрэх боломжийг бүрдүүлдэг. Мөн хайлаас нь зуны цагт ган гачгийн үед навчны ургалтаа хязгаарлах замаар усны хэрэглээгээ бууруулах чадвартай байдаг. Түүнчлэн энэхүү мод нь 5-7 см-ийн маш зузаан холтостой байдаг нь ус чийгийг барих, зун болон өвлийн эрс тэс температурыг тусгаарлах үүрэгтэй байдаг. Хайлаас мод нь өмнө Говийн бүсийн модлог ургамлын цөөхөн төрөл зүйлийн нэг болохынхоо хувьд тухайн бүс нутгийн экосистемд голлох үүргийг гүйцэтгэдэг. Энэхүү мод нь шувууны үүрээ засах хамгийн тохиромжтой газар болж өгдөг ба олон жижиг сүүн тэжээлтэн амьтан, хэвлээр явагч, шавьжийн төрөл зүйлүүдийн оршин амьдрах, үүрлэх газар болдог. Мөн хайлаас мод нь орон нутгийн малчдын хувьд соёлын болоод ахуйн ач холбогдолтой байдаг бөгөөд бага гүний усныг байршлыг заагч болдог тул түлш, мод бэлтгэх үүднээс огтлохоос сэргийлдэг (албан бусаар) байна.
- ***Булаг шандны бүлгэмдэл*** нь байнгын урсацтай Бор овоогийн булгийн орчимд тохиолдох ба булаг шандны ойролцоох эргийн чийглэг хөрсөнд ургадаг ширэг улалж (*Carex duriuscula*), зурман сүүл (*Puccinellia tenuifolia*), цэгээлж (*Glaux maritima*) зэрэг төрөл зүйлүүд ордог. Цахилдаг (*Iris lactea*), эгэл нишингэ (*Phragmites communis*), гялгар дэрс (*Achnatherum splendens*) нь тогтоол уст цэг, усаар ханасан хөрсөнд ургадаг. Бадаргана (*Kalidium gracile*), гялгар дэрс (*Achnatherum splendens*), сибирь хармаг (*Nitraria sibirica*) зэрэг нь булгын захдуу газар тохиолддог бол, бадаргана (*Kalidium gracile*), бор бударгана (*Salsola passerina*), зүүнгарын бутаргана (*Reamuria soongorica*), ширэг улалж (*Carex duriuscula*) зэрэг нь хуурай үед булаг татарч хуурайшсан хөрсөнд тохиолддог.

Зураг 7.5: Оюу Толгойн ургамлын хяналт шинжилгээний 1-р цэг, 2011 оны 5 сар, хулан хойргот (Potaninia mongolica) хэвшил

Дээр дурьдсан ургамалжилтын 4 ерөнхий бүлгэмдлүүд нь тус бүрдээ зонхилох ургамлын төрөл зүйлүүд болон ургамалжилтын бүтцийн шинж байдлаасаа (голчлон бүрхэвчийн %) хамаараад хэд хэдэн ургамлын хэвшлүүдэд дахин хуваагддаг (“Эко Трейд”, 2006). Энэхүү ургамалжилтын хэвшлүүдийг Хүснэгт 7.1 болон Зураг 7.6-д үзүүлэв.

Хүснэгт 7.1: Уурхайн лицензит талбайн ургамлын бүлгэмдлүүд, хэвшлүүд (Зураг 7.6-ийг үзнэ үү)

Ургамлын бүлгэмдлийн нэр	Бүрхэх хувь	Дундаж өндөр (см)	Нэгж талбайд ногдох төрөл зүйлийн тоо	Зонхилох зүйлүүд	Нэгж талбайд ногдох бодгалийн нийт тоо	БОНБНҮ-ний хүрээнд судалгаа явуулсан байршлууд болон Оюу Толгойн хяналт шинжилгээний цэгүүд
Дэнжийн ургамалжилтын бүлгэмдлийн хэвшлүүд						
Бор бударгана (*Salsola passerina*) + зүүнгарын бутаргана (*Reamuria soongorica*) +таана (*Allium polyrhizum*) (цөлийн бүлгэмдэл)	18-23	10-14	9-28	Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*) Бор бударгана (*Salsola passerina*) Регелийн шар мод (*Sympegma regelii*) Зүүнгарын бутаргана (*Reamuria soongorica*)	20 441 15 65	Цэг # 4: 4768000 / 654000 Цэг # 15: 4759818/ 655651 Цэг # 17 хаягдлын цэгийн зүүн жигүүрт оршино
Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*) + регелийн шар мод (*Sympegma regelii*)	15-27	8-12	23-27	Регелийн шар мод (*Sympegma regelii*) Хармаг (*Nitraria sphaerocarpa*)	5 1	Цэг # 2: 4765500 / 654000 - ил уурхайн хаягдлын овоолгын зэргэлдээ : 4759940 / 653100

Ургамлын бүлгэмдлийн нэр	Бүрхэх хувь	Дундаж өндөр (см)	Нэгж талбайд ногдох төрөл зүйлийн тоо	Зонхилох зүйлүүд	Нэгж талбайд ногдох бодгалийн нийт тоо	БОНБНҮ-ний хүрээнд судалгаа явуулсан байршлууд болон Оюу Толгойн хяналт шинжилгээний цэгүүд
+ таана (*Allium polyrhizum*) (цөлийн бүлгэмдэл)				Хулан хойрго (*Potaninia mongolica*) Зүүнгарын бутаргана (*Reamuria songoorica*) Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*) Таана (*Allium polyrhizum*) Сайрын хялгана (*Stipa glareosa*)	1 35 237 75 14	
Хулан хойрго (*Potaninia mongolica*) + бор бударгана (*Salsola passerina*) + регелийн шар мод (*Sympegma regelii*) (цөлийн бүлгэмдэл)	25-30	15-18	22-28	Регелийн шар мод (*Sympegma regelii* Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*) Бор бударгана (*Salsola passerina*) Боролз (*Ajania achillouides*) Хулан хойрго (*Potaninia mongolica*)	137 179 49 136 37	Хойд Оюу ордын хойд захын цэг: 4765477 / 653318
Таана (*Allium polyrhizum*) + ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*) + сайрын хялгана (*Stipa glareosa*) (хээрийн бүлгэмдэл)	35-40	10-13	20-29	Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*) Сайрын хялгана (*Stipa glareosa*) Боролз (*Ajania achillouides*) Хулан хойрго (*Potaninia mongolica*) Таана (*Allium polyrhizum*)	32 20 128 15 33	Цэг # 3: 4765000 / 648000 Цэг # 5: 4766000 / 649000 Ундайн голын сайрын баруун тал
Регелийн шар мод (*Sympegma regelii)* + бор бударгана (*Salsola passerina*) + ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*) (цөлийн бүлгэмдэл)	15-20	15-20	8-12	Судлагдаагүй		Цэг # 15: 4759818 / 655651
Булаг шандны бүлгэмдлийн хэвшлүүд						
Ширэг улалж (*Carex duriuscula*) + зурман сүүл (*Puccinellia tenuiflora*) + цэгээлж (*Glaux maritima*) (нугын бүлгэмдэл)	99	5-10	15	Судлагдаагүй		Бор овоо булгийн ойролцоо: 4761727 / 650569
Дэрс (*Phragmites communis*) + цахилдаг (*Iris lactea*) + гялгар дэрс (*Achnatherum splendens*) (бага гүний ус)	45	15-20	13	Цахилдаг (*Iris lactea*) Гялгар дэрс (*Achnatherum*	368 196	Төв Оюу Ордын зүүн талд:

Ургамлын бүлгэмдлийн нэр	Бүрхэх хувь	Дундаж өндөр (см)	Нэгж талбайд ногдох төрөл зүйлийн тоо	Зонхилох зүйлүүд	Нэгж талбайд ногдох бодгалийн нийт тоо	БОНБНҮ-ний хүрээнд судалгаа явуулсан байршлууд болон Оюу Толгойн хяналт шинжилгээний цэгүүд
				splendens)		
Хармаг (*Nitraria sibirica*) + дэрс (*Achnatherum splendens*) + Бадаргана (*Kalidium gracile*) (давсархаг бага гүний ус)	35-40	25-30	15	Хармаг (*Nitraria sibirica*) Бадаргана (*Kalidium gracile*) Гялгар дэрс (*Achnatherum splendens*)	18 340 175	Бор овоо булгаас зүүн зүгт 200 метрт:
Бадаргана (*Kalidium gracile*) + зүүнгарын бутаргана (*Reamuria soongorica*) + бор бударгана (*Salsola passerina*) (Говийн)	15-20	25	17	Бадаргана (*Kalidium gracile*) Бор бударгана (*Salsola passerina*) Зүүнгарын бутаргана (*Reamuria soongorica*) Регелийн шар мод (*Sympegma regelii)*	631 125 78 25	Төв Оюугийн өмнө талд
Ширэг улалж (*Carex duriuscula*) (шал хөрс[10])	40	15-20	12	Судлагдаагүй		Цэг # 8: 476000 / 653000
Хуурай сайрын бүлгэмдлийн хэвшлүүд						
Зүүнгарын бутаргана (*Reamuria soongorica*) /хармаг (*Nitraria sibirica*)/ + ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*)- + бор бударгана (*Salsola passerina*) (голын хуурай сайр, жалга)	35-40	10-15	17-25	Хармаг (*Nitraria sibirica*) Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*) Бор бударгана (*Salsola passerina*) Зүүнгарын бутаргана (*Reamuria soongorica*) *Halogeton glomeratus* Таана (*Allium polyrhizum*) Манан хамхаг *(Bassia dasiphylla)* *Halogeton arachnoideus* Ямаан шарилж *(Artemisia scoparia)* Сормослог хайрст *шарилж (Artemisia blepharolepis)*	21 234 87 56 >20,000 250 5000 625 250 125	Төв Оюугийн зүүн талын хөндий Цэг # 7: 4765000 / 652000 Цэг # 12: 4767000 / 648000
Толгодын бүлгэмдлийн хэвшлүүд						

[10] Шал хөрс бол тогтоол ус тойромын ёроолд бүрэлдсэн их хэмжээний давсны агууламж бүхий шаварлаг хөрс юм.

Ургамлын бүлгэмдлийн нэр	Бүрхэх хувь	Дундаж өндөр (см)	Нэгж талбайд ногдох төрөл зүйлийн тоо	Зонхилох зүйлүүд	Нэгж талбайд ногдох бодгалийн нийт тоо	БОНБНҮ-ний хүрээнд судалгаа явуулсан байршлууд болон Оюу Толгойн хяналт шинжилгээний цэгүүд
Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*) + Регелийн шар мод (*Sympegma regelii*) + *Chesneya macrantha* (цөлийн бүлгэмдэл)	37	12-15	23-25	Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*) Регелийн шар мод (Sympegma regelii) *Chesneya macrantha* Хулан хойрго (*Potaninia mongolica*)	126 17 35 11	Ундайн голын баруун талаар байх жижиг дов толгод
Бор бударгана (*Salsola passerina*) + зүүнгарын бутаргана (*Reamuria soongorica*) + регелийн шар мод (*Sympegma regelii*) хулан хойрго (+ Potaninia mongolica) /цөлийн бүлгэмдэл/	18-20	10-15	20-30	Бор бударгана (*Salsola passerina*) Зүүнгарын бутаргана (*Reamuria soongorica*) Регелийн шар мод (*Sympegma regelii*) Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*) Хулан хойрго (*Potaninia mongolica*) Halogeton glomeratus Манан хамхаг *(Bassia dasiphylla)*	509 415 59 50 81 >20,000 >20,000	Цэг # 10 /Хаягдал чулуулгийн овоолгын төв хэсэг: 4761990 / 652603 Төв Оюугийн дээд талд

Эх сурвалж: Эко-Трэйд ХХК (2006)

Зураг 7.6: Оюу Толгой уурхайн лицензит талбай дахь ургамлын бүлгэмдлүүд (7.1-р хүснэгтийг үзнэ үү)



Эх сурвалж: Эко-Трейд (2006)

7.3.6 Дэд бүтцийн зурвас дагуух газар

Дэд бүтцийн зурвас нь хойд зүгт лицензит талбай хүртэл мөн өмнө зүгтээ Хятадын хил хүртэл үргэлжилсэн ба үүнд 220 кВт-н цахилгаан дамжуулах шугам ба Оюу Толгой-Гашуун Сухайтийн чиглэлийн зам багтана. Тус зурвас нь Галбын Говийн өргөн нам дор хөндийгөөр дайрч өнгөрнө. Бунгийн харгана (*Caragana bungei*),, алтан харгана (*Caragana leucophloea*), бор бударгана (*Salsola passerina*), хуурайсаг (*Artemisia xerophytica)*, хулан хойрго (*Potaninia mongolica*), сибирийн хармаг (*Nitraria sibirica*) гэх мэт сөөглөг болон говийн хялгана (*Stipa gobica*), сайрын хялгана (*Stipa glareosa*), зүүнгарын хазаар өвс (*Cleistogenes soongorica*) зэрэг өвслөг ургамлууд нь говь, цөлийн бүсийн тал газарт болон нам толгодоор зонхилно.

2010 оны “Эко-Трейд” компани нь судалгааны явцдаа дэд бүтцийн зурвасын ургамлан бүрхэвч нь газрын төрх байдал, топографтайгаа ихээхэн хамааралтай болохыг олж тогтоосон ба дов толгод, өндөрлөг газар болон хотгор хонхор газар зэрэг нь өөр өөрийн гэсэн ургамлын төрөл зүйлүүдийн

бүрдэлтэй байжээ. Цөл болон цөлөрхөг хээрийн бүсийн дов толгод болон тал хөндий нь ганд тэсвэртэй сөөглөг ургамал болон олон наст буяд ургамлаар бүрхэгдсэн байдаг. Төслийн талбайн хэмжээнд, баянбүрд болон ус хуралдах газруудад зөвхөн өтгөн нягшилтай ургамал ургасан байв. Зарим заг, хайлаас гэх мэт ургамлууд мөн давсархаг нуга зэрэг бага гүний хөрсний устай газруудад буюу гуу жалга, сайрууд даган ургаж байв.

Дэд бүтцийн зурваст нийт таван ургамлын хэвшинжийг тодорхойлжээ (2010 Эко-Трэйд ХХК). Эдгээр нь: цөлөрхөг хээрийн тэгш талын, цөлийн тэгш талын, нам толгодын, түр зуурын урсгалтай голын гольролуудын ургамалжилт болон баян бүрд тойромын ургамалжилт болно. Эдгээр таван хэвшинжид хамаарагдах 8 ургамлан бүлгэмдлийг (зонхилох зүйл дээр тулгуурлан) ялган тогтоолоо (Эко Трейд ХХК, 2010):

- ***Цөлөрхөг хээрийн тэгш талын ургамалжилт***: Оюу Толгойгоос Дөрвөлжин овоо орох замын зурвасын хэсэгт цөлөрхөг хээрийн тэгш талын ургамалжилтын хэвшинж зонхилдог. Энэ хэвшинжид тухайн бүс нутагт тохиолдох дараах хоёр сөөг зонхилсон ургамлан бүлгэмдэл ялгаран хөгжсөн байна .
    - Ахар навчит баглуур-бор-улаан бударганат бүлгэмдэл (*Anabasis brevifolia-Reaumurea soongarica-Salsola passerina*)
    - Сибирь хармаг-гоолиг бадарганат бүлгэмдэл (*Nitraria sibirica-Kalidium gracile*).
- ***Цөлийн тэгш талын ургамалжилт*:** Галбын говийн өргөн тэгш тал эхлэн цааш үргэлжилнэ. Энэ хуурай тэгш тал нутагт 10 м х 10 м талбайд 20-25 ширхэг бодгаль тоологдохоор сөөг ургамлууд сийрэг тархацтай тохиолддог. Энэ ургамалжилтын хэвшинжийг төлөөлөх бүлгэмдлүүдэд доорхи бүлгэмдлүүд орно. Үүнд:
    - Регелийн шар мод-ахар навчит баглуур-Монгол хулан хойргот бүлгэмдэл (*Sympegma regelii-Anabasis brevifolia-Potaninia mongolica*),
    - Шар хотир-Горчаковийн сэдэргэнэт бүлгэмдэл (*Zygophyllum xanthoxylon-Convolvulus groschakovii*).

  Бусад бүртгэгдсэн төрөл зүйлүүд нь шивэлз (*Ptilagrostis*), Заг (*Haloxylon ammodendron*), Сөөгөн сэдэргэнэ (*Convolvulus fruticosus*), Таана (*Allium polyrrhizum*), Хөмөл (*Allium mongolicum*), Зүүнгарын хазаар өвс (*Cleistogenes songorica*), Алтайн согсоот (*Heteropappus altaicus*), Төлөгчдүү боролзой (*Ajania achilleoides*), Сайрын хялгана (*Stipa glareosa*) зэрэг юм.
- ***Нам толгодын ургамалжилт*:** судалгааны талбайд цөл болон цөлөрхөг хээрийн нам толгодын ургамлан бүлгэмдлүүд нилээд хувийг эзлэн тархсан байдаг. Энэ бүлгэмдлийн тархацын зүй тогтол нь рельеф болон гадаргын морфологиос ихээхэн хамааралтай байгаа хэдий ч цөл, цөлөрхөг хээрийн тэгш талын ургамлан бүлгэмлүүдээс зүйлийн бүрдлийн хувьд тодийлөн ялгараад байдаггүй. Нам толгодын ургамлын хэвшлийг тодорхойлох бүлгэмдлүүдэд дараах орно:
    - Ахар навчит баглуур-Говийн хялганат бүлгэмдэл (*Anabasis brevifolia-Stipa gobica*),
    - Алтан харгана-шар хотир -бариулт бүйлэст бүлгэмдэл (*Caragana leucophloa-Zygophyllum xanthoxylon-Amygdalus pedunculata*).

  Уулын орой хэсэгт ургамлын бүрхэц маш сийрэг бөгөөд 1м^2 талбайд 3-4 зүйлийн сөөг болон олон наст өвслөг ургамал тохиолдоно. Үүн дээр нэмж судалгааны талбайд тэмдэглэгдсэн зүйлүүдэд Пеллитын шивэлж *(Ptilagrostis pelliotii)*, ногоон хоногбудаа (*Setaria viridis), улаанбударгана (Reaumuria soongorica),* Алтайн согсоолж *(Heteropappus altaicus)* болон төлөгчдүү боролзой сөөгөнцөр (*Ajania achilleoides)* зэрэг ургамлууд орно.
- ***Түр зуурын урсацтай голын гольдролуудын ургамалжилт***: дэд бүтцийн зурвасын дагуух түр зуурын урсацтай газрууд нь нам толгодын болон тэгш тал газрыг бодвол ургамлын нягтшил болон төрөл зүйл харьцангуй ихтэй. Түр зуурын урсац бүхий газруудад ургамлан бүрхэвч нь 50%-аас дээш хувьтай байдаг гэж тооцоолсон. Энэ хэвшилд зөвхөн ганц бүлгэмдлийн ургамал бүртгэгдсэн:
    - Сибирь хармаг-гялгар дэрст бүлгэмдэл (*Nitraria sibirica-Achnatherum splendens*)

- ***Баянбүрд тойрмын ургамалжилт*:** Галбийн Говийн урд хэсэгт дэд бүтцийн зурвасын урд үзүүрт Булан Сухайт хэмээх томоохон баянбүрд (булаг) бүртгэгдсэн. Энэ нутаг дэвсгэр нь Галбын говийн нам дор газруудын нэг бөгөөд гадаргын усны урсгалын нилээдгүй хэсэг нь энэ тойромд бороо орсны дараа хуримтлагдана. Тойром бүрд дэх гүехэн гүний усны нөлөө, сайн ургасан ургамалжилт нь хөрсийг тогтоон барьж бэхжүүлэх бөгөөд ялзмагт хөрс энд хуримтлагдах боломжийг бүрдүүлж өгдөг. Баянбүрдэд зөвхөн ганц л ургамлын бүлгэмдэл бүртгэгдсэн байна.
    - Улаан сухай-Бор бударгана-улаанбударганат бүлгэмдэл (*Tamarix ramossisima-Salsola passerina-Reaumurea songarica*)

Дэд бүтцийн зурвасын ургамлын бүлгэмдлүүдийг Зурагт 7.7-д үзүүлэв (Эко-Трейд ХХК, 2010 он).

Дэд бүтцийн зурваст Эко Трейд (2010)-ийн ажигласан ургамлын бүлгэмдлүүдээс гадна Ундайн голын урд талын садрааны (Дайчин гэж нэрлэгдэх) бүсэд, цахилгаан дамжуулах шугамын баруун талд томоохон хэмжээний заган ойн бүлгэмдэл тохиолддогийг бүртгэжээ. Энэ газар устаж болзошгүй хулан мөн ховордсон хар сүүлт зээр зэрэг нүүдлийн томоохон туурайтан амьтдын сүрэг олонтаа харагддаг.

Таван Толгой Нүүрсний ордын замын зүүн талд улиангар (*Populus euphratica*) түр зуурын урсацтай голын аллювийн хэсгийг даган ургасан байдаг. Энэхүү шугуйг Өмнөд Говийн хамгийн зүүн талын улиангарын төгөлийн нэг гэж үздэг, гэвч сүүлийн хоёр жилд усны урсгалын чиг өөрчлөгдсөн, мөн морин чичүүл (*Rhobomys opimus*) ихээр сүйтгэсэний улмаас энэ төгөл мөхсөн хэмээх мэдээлэл байна.

Одоо ашиглаж байгаа Таван Толгойн “нүүрсний зам”, Оюу Толгой - Гашуун Сухайтын зам зэрэг нь дэд бүтцийн зурвасын ургамлан бүрхэвчид орон нутгийн чанартай нөлөөллийг үзүүлж байна. Энэхүү нөлөөлөл нь албан ёсны төв замын хажуугаар (ачааны машин болон бусад тээврийн машинууд эвдэрсэн замыг тойрох болсноос үүдэн) олон тооны салаа замууд гарсан, мөн сайжруулаагүй замаас үүдэн ихээхэн хэмжээний тоос шороо үүсэх болсон болон Жавхлант багийн төв орчмын суурьшил зэргээс голчлон шалтгаалж байна. Үүний эсрэгээр, цахилгаан дамжуулах шугамын дайран өнгөрөх бүс нутаг нь одоо байгаа гол тээврийн замуудаас харьцангуй алслагдмал хол учир хүрээлэн буй орчинд нь сөрөг нөлөөлөл бараг байхгүй байна.

Зураг 7.7: Дэд бүтцийн зурвасын Ургамалжилтын хэвшлүүд



Rare & Very Rare Plant Locations

No	Easting	Northing	Scientific name
1	671751	4751965	**Very rare:** *Potaninia mongolica, Zygophyllum Potaninii, Tugarinovia mongolica*
2	667587	4754790	**Very rare:** *Potaninia mongolica,* **Listed in Mongolian Red Book:** *Potaninia mongolica,* **Endemic plants:** *Stipa glareosa, Phlegmatis Pelliotii, Allium mongolicum, Allium polyrhizum, Potaninia mongolica* **Relict plant:** *Sympegma Regelii, Reaumuria soongarica*
3	700754	4719640	**Very rare:** *Potaninia mongolica,* **Listed in Mongolian Red Book:** *Potaninia mongolica,* **Endemic plant:** *Allium mongolicum, Allium polyrhizum, Salsola passerina, Potaninia mongolica,* **Relict plant:** *Sympegma Regelii*
4	701700	4715808	**Very rare:** *Potaninia mongolica, Caragana brachypoda,* **Listed in Mongolian Red Book:** *Potaninia mongolica, Caragana brachypoda,* **Endemic plants:** *Stipa glareosa, Tragus mongolorum, Allium polyrhizum, Salsola passerina,* **Relict plant:** *Sympegma Regelii, Reaumuria soongarica*
5	702640	4713698	**Very rare:** *Potaninia mongolica, Tugarinovia mongolica, Asterothamnus centrali-asiaticus* **Listed in Mongolian Red Book:** *Potaninia mongolica, Tugarinovia mongolica, Caryopteris mongolica* **Endemic plant:** *Phlegmatis Pelliotii, Allium polyrhizum, Conspermum mongolicum, Astragalus Grubovii* **Relict plant:** *Sympegma Regelii*
6	655728	4759782	**Very rare:** *Arnebia guttata*
7	658417	4758558	**Endemic plants:** *Stipa glareosa, Allium mongolicum, Allium polyrhizum, Salsola passerina,* **Relict plant:** *Sympegma Regelii, Reaumuria soongarica*

7.3.7 Хамгаалах шаардлагатай ургамлууд

Заган ой

Заг (*Haloxylon ammodendron*) (Зураг 7.8) нь Каспийн тэнгисийн бүс нутгаас зүүн зүгт Хятад (баруун Ганьсу, Өвөр Монгол, баруун хойд Нинша, хойд Чинхай, Шинжаан) болон Монгол орны нутаг дэвсгэр хүртэл тархсан, элсэн манхан, хужир шүлт бүхий цөл, элсэрхэг газруудад болон голын эрэг орчмоор ургах бутлаг буюу жижиг модлог ургамал юм.

Заг нь гүний усны олдоцоос хамааран 30-40 м хүртэл гүн үндэсний системтэй байна (*Бүлэг С6. Биологийн төрөл зүйлийн олон янз байдал ба Экосистемийн үйлчилгээнд нөлөөлөх байдал*-н Хавсралт С-г үзнэ үү). Ийм гүнд ургасан заг модны үндэс нь хөрсний чийг бага үед бага гүнд орших хөрсний усыг хураах авах боломжийг олгодог. Чуанлиний болон бусад (2007) судлаачдын дүгнэснээс үзэхэд, заг нь факультатив фреатофит буюу газрын бага гүнд орших хөрсний усыг татан шингээх чадвартайгаас гадна бага гүний усгүй, хөрсний чийглэг нь улирлын чанартайгаар усны түр зуурын урсацууд болон бороoны ус шууд нэвчсэнээр нөхөгдөж байдаг газруудад тэсэж оршин байх чадвартай болохыг тогтоосон байна. Мөн навчны ургалтыг бууруулах мөн 5-6 жилийн туршид хэсэгчилсэн эсвэл бүрэн өсөлтөө зогсоож ичиж чаддаг явдал нь загийг урт хугацааны хур бороогүй үеийг тэсвэрлэх нөхцөл нь болдог. Чуанлин болон бусад судлаачид (2007), хэт их хэмжээний ус загийн ургалтанд хязгаарлагч хүчин зүйл болдог болохыг туршилтын явцад тогтоосон тиймээс заг модонд шаардлагатй ус чийгний тохиромжтой хязгаар нь харьцангуй бага юм. Газрын цардас усны нэвчилтийг хязгаарладаг бөгөөд энэ нь усны нэвчих чанар өндөр байдаг элсэн манханд заг ургадаг үзэгдлийг тодорхой хэмжээнд тайлбарлаж байж магадгүй.

Заг нь зэрлэг болон гэрийн томоохон өвсөн тэжээлтэн амьтдад олон наст ургамлын тэжээлийн эх үүсвэр болдгоороо ач холбогдолтой бөгөөд мөн олон төрлийн амьтад, ялангуяа загийн боршувуу (*Passer ammodendri*) зэрэг шувууд, жижиг хөхтөн амьтдын амьдрах үүр, амьдрах орчин тархац нутаг болдог зэргээр чухал үүрэг гүйцэтгэдэг.

Шмидтийн болон бусад судлаачдын (2011) үзэж байгаагаар Ханбогд сум нь Монгол орны заг ургаж байгаа нийт талбайн 6%-ийг эзэлдэг ажээ. Оюу Толгойн НБ-ийн дотор Гүний Хоолойн талбайн төв болон зүүн хойд хэсгээр, Ундайн Голын өмнөд хэсгийн Дайчин хэмээх газарт (“Дайчингийн заг” гэж яригддаг) заган ой байдаг байна.

Гүний Хоолойн усны цооногийн талбай дахь заг

Загийн төгөл нь Гүний Хоолойн хөндийн төв болон зүүн зүгт бүртгэгдсэн байдаг. Гүний Хоолойн төв хэсэгт нь намхан элсэн манханд ургаж буй 4-10 орчим настай нялх загийн төгөл байдаг. Эдгээр загууд түр урсацын сайр садаргын ойролцоох харьцангуй чийглэг газарт, мөн гадаргын усны урсгал урсан ордог нам дор байрлах, өргөн хотгор хонхорхой газар ургаж байдаг. Гүний Хоолой хөндий дэхь Ухаа Голын садраа орчмоор олон жижиг загууд ургасан байдаг нь гүний уснаас илүү гадаргын усаар тэжээгддэг улирлын чанартай хөрсний чийгээс хамааралтай болохыг харуулж байгаа юм. Гүний Хоолойн цооногийн талбайн (Амтгайн тойромын орчим) зүүн хэсэг дэхь заган ойг Гүний Хоолойн цооногийн төв хэсэгт байх загийг бодвол арай өндөр, арай хөгшивтөр гэж үзэх боловч, эдгээр нь мөн адил бага гүний уснаас илүүтэйгээр улирлын чанартай хөрсний чийглэгийн олдоцоос хамааралтай ургадаг гэж үзэж болох юм.

Заган ургамал нь дэнжийн ургамалжилтийн гадаргын ургамлан бүрхэвчийн ойролцоогоор 8%-ийг нь эзэлж байгаа бөгөөд 25 х 25 м талбайд судалгааны явцад 68 ургамал байх дундаж нягтшилтай байв (Эко Трейд 2009, JEMR 2010). Энэ бүс дэхь загийн ихэнх хувь нь хайрга болон чулуулаг хөрсөн дээр ургасан гол нуруу нь 50 см диаметртэй, дунджаар 80 см орчим өндөртэй бие гүйцээгүй бодгалиуд байсан байна.

Дайчин Загийн заг

Дайчин загийн загууд ихэвчлэн олон салаа бүхий намхан модод байдаг. Энэхүү ургалтын хэлбэр нь энэ ургах орчинд Ундайн голын олон салаануудаас өгч байгаа хөрсний ихээхэн чийглэгтэй холбоотой юм (Ж. Санжид, Эко Трейд, 2005). Гэвч олон салаалж ургах нь хэт ихээр түүж тасдаснаас хамаарч байж болно.

Зураг 7.8: Гүний Хоолойн сав газар дахь заган ой, 2011 оны 5-р сар

Хайлаасан шугуй

Сибирь хайлаас (*Ulmus pumila*, Зураг 7.9) нь Хятадын баруун хойт хэсэгт өргөн тархсан, зүүн-төв Азийн ургамал бөгөөд тархацийнх нь баруун хязгаар нь төв Монгол, өмнөд Орос, баруун Хятад хүрсэн байдаг (Веше болон бусад 2011). Эдгээр модод нь улирлын чанартай түр урсгац бүхий сайрын дагуу аллювийн хөрсөн дээр буюу Ханбогдын боржин чулуун массивын бэл орчмын аллювийн хурдас давхарга дээр сунаж тогтсон ой шугуй буюу модон төгөлийг үүсгэдэг.

Веше болон бусдын үзэж байгаагаар (2011), Сибирьийн хайлаас нь гүний усны найдвартай хангамжаас ихээхэн хамааралтай байдаг учир нь тэд нар хүчтэй шарах үеүдэд ус ууршуулалтаа төдий л бууруулдаггүйн дээр их хэмжээний тогтонги ус, давсны өндөр хэмжээг тэсвэрлэдэггүй. Энэхүү ажиглалтууд нь шаварлаг хотгоруудаас илүүтэйгээр ус сайн нэвчих элсэрхэг аллювийн хөрс нь хайлаас ургахад нэн тохиромжтой болохыг харуулж байна. Эдгээр судлаачид нь өмнө Говийн судалгааны талбай дахь хайлаас модод нь бага гүний устай, наад зах нь тодорхой хэмжээний түр гадаргын устай гуу жалга, сайрын сайдраа орших ус хураах хотгор газруудад ихэвчлэн ургаж байгааг тогтоосон байна. Үүнтэй адилаар, Дуламсүрэн болон бусад судлаачид (2009) Сибирь хайлаасны ус ууршуулалт зуны улирлын туршид өндөр байдгийг тогтоосон бөгөөд энэ нь зарим талаараа зуны халуун нарыг тэсэх хөргөлтийн механизм болж болох боловч энэ нь зохих усны нөөцтэй газар байх шаардлагатай байна. Мөн Сибирь хайлаасны үндэс нь түргэн ургадаг болохыг эдгээр судлаачид мөн тэмдэглэсэн байна. Оюу Толгой төслийн НБ-д Ж.Санжидийн хийсэн судалгаагаар хайлаас модод хөндлөн тэнхлэгт олон салаалсан үндэсний системээрээ 0.2-0.4 м-ийн гүний ус чийгэнд хүрдэг болохыг харуулж байна.

Сибирь хайлаас нь олон төрөл зүйлийн шувуудын амьдрах орчин, зээрд шонхор (*Falco naumanni*) идлэг шонхор (*Falco cherrug*) зэрэг махчин шувуудын үүрээ засах газар болж томоохон хөхтөн амьтдад ч мөн нөмөр сүүдрэвч болж өгдөг байна (Веше болон бусад, 2011). Веше болон бусад судлаачид (2011) Монгол орны Говьд энэхүү хайлаас шугуйнууд өсөж үржихгүй илэрхийгээр ховордож байгааг тэмдэглэсэн ч, саяхнаас одоогийн Оюу Толгой-Гашуун Сухайтын замын зүүн талд хайлаасан шугуй дахин сэргэж байгааг харж болно гэжээ (Зураг 7.10).

Дараахь шалтгаануудын улмаас төслийн НБ нь дэлхийн хэмжээнд Сибирь хайлаасыг хадгалж хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна (von Wehrden in litt., Хавсралт С): (i) төслийн НБ

нь Сибирь хайлаасын тархацын баруун захад (энэ зүйлийн тархац нь Говь Гурван Сайханы орчим баруун тийш тархсан гэж үздэг) оршиж байна, (ii) энэхүү зүйлийн зүүн болон өмнөд зүг дэх тархац нь хүний үйл ажиллагааны нөлөөгөөр ихээхэн багассан (Веше болон бусад, 2011-г үз).

Зураг 7.9: Ундай голын хөндий дэхь Сибирь хайлаас, 2011 оны 5-р сар

Зураг 7.10: Дэд бүтцийн зурвасын зүүн талд Хайлаас нутагшуулсан нь, 2011 оны 5-р сар

Улиангарын төгөл

Улиангар нь (*Populus euphratica*) Өмнөд Говьд жижиг шугуйнуудыг бүрдүүлэх ч хайлаасыг бодвол цөөхөн тохиолдох бөгөөд улиангар нь зүүн уртрагийн 101.5°-т аажмаар хайлаасаар солигддог (Веше ба бусад, 2011). Оюу Толгойн НБ-т зөвхөн ганц улиангарын шугуй тэмдэглэгдсэн нь Хятадын хилийн орчимд Гашуун Сухайтын хойно байх Цагаан хад сууринги йн ойрхон орших Их Гүн Усны Хоолой дахь улиангар шугуй юм. Энэхүү шугуйг гадаргуу дээрх тунадасны уналтын өөрчлөлт, усны

урсгал улирлын чанартай өөрчлөгдөх, морин чичүүлийн бүлгэмдэл ургамлын үндсийг ухаж сүйтгэх зэрэг хэд хэдэн шалтгааны улмаас сүйдэхэд хүрч байна гэж үздэг (Зураг 7.11). Энэ улиангарын шугуйг уг зүйлийнхээ Монгол орны Говийн хамгийн зүүн хэсэгт байгаа шугуйн нэг гэж үздэг байв (Ж.Санжид-тай хийсэн ярилцлага, , 2011).

Зураг 7.11: Гашуун Сухайтын замын орчим дахь Их Гүн Үсний Хоолойн дахь өгөршсөн улиангарын төгөл, 2011 оны 5-р сар

Сухай мод

Сухай мод (*Tamarix ramosissima*[11], Зураг 7.12) нь хурдас болон органик бодис хуримтлагдсан газар ихэвчлэн довцог үүсгэн ургадаг, Говь цөлд өргөн тархсан сөөг буюу модлог ургамал юм. Энэхүү зүйлийн үндэс болох гол иш нь маш гүнзгийд байдаг бөгөөд төслийн НБ-д 10 – 12 м гүнд хүрсэн байдаг (Ж.Санжид, Эко Трейд 2005). Оюу Толгой төслийн НБ-д сухай мод нь ус хуримтлагдаж, улирлын чанартай тойрмыг үүсгэдэг хотгор газруудад тохиолддог. Энэ модны үр жимсээр олон амьтад хооллодог. Оюу Толгой төслийн НБ дэхь сухай ургадаг хамгийн амьдрах орчин нь дэд бүтцийн зурваст орших Булан Сухайтын тойром юм.

[11] Tropicos.org. –д *T. chinensis* Lour. by нэрээр бүртгэгдсэн.

Зураг 7.12: Булан Сухайт дахь сухай моднууд

Боржин чулууны гарш

Төслийн НБ-ийн зүүн талд орших Ханбогд массивийн боржин чулууны үе гаршууд нь хөрсний онцгой бүтцийн улмаас ургамлын өвөрмөц бүлгэмдлүүд ургадаг гэж үздэг (Х. Вон Верхден ТВС & FFI-д дурьдсан, 2010:88). Ханбогд массив мэт боржин чулуу гаршууд нь Монгол орны өмнөд хэсэгт төдийлөн түгээмэл бус учраас Төслийн НБ нь энэхүү өвөрмөц ургамлын бүлгэмдлүүдийн хувьд чухал газар байх магадлалтай. Хэдийгээр Вон Верхден нь (ТВС & FFI-д дурьдсан, 2011) эдгээр бүлгэмдлүүдийг тэмдэглэсэн ч, өдийг хүртэл Ханбогд массивтай холбоотой ургамалжилт болон Монгол орны өмнөд нутгийн боржин чулууны бусад томоохон гаршуудтай холбоотой ургамалжилтийн талаар ботаникийн судалгааны хэвлэсэн бүтээл гараагүй байна.

Хармагт дов довцог

Гүний Хоолойн усны цооногийн талбай болон ус дамжуулах шугам хоолойн зарим хэсгүүдэд (Сибирь хармаг зонхилсон ургамалжилт бүхий) элсэрхэг дов довцог бүхий газрууд байдаг (Зураг 7.13 үзнэ үү). Гүний Хоолой болон Өмнө Говийн нутгаар өргөн тархсан хэдий ч, энэхүү дов довцог нь экологийн чухал үүрэгтэй байдаг. Тэдгээрийн өргөн үндэсний тогтолцоо нь салхиар туугдаж буй элсийг тогтоох, чийг болон тэжээлийг барих, ингэснээрээ говь цөлийн газрын гадаргыг тогтвортой байлгах үүрэг гүйцэтгэдэг. Хармаг мөн ихээхэн хэмжээний үр жимс өгдөг бөгөөд үүнийг олон зүйлийн зэрлэг амьтад, мөн орон нутгийн ард иргэд хүнсэндээ хэрэглэдэг.

Зураг 7.13: Гүний Хоолой дахь Сибирь хармаг (Nitraria sibirica) бүхий довцогууд, 2011 оны 5-р сар

Хуулиар хамгаалагдсан ховор болон нэн ховор төрөл зүйлүүд

Өнөөг хүртэл Олон Улсын Байгаль Хамгаалах Холбоо (ОУБХХ)-оос Монгол орны ургамлын аймагт ямар нэгэн үнэлгээг хийгээгүй бөгөөд иймд төслийн нөлөөллийн бүс дэхь ургамлуудаас аль нэг нь ОУБХХ-ны ховордсон ургамлуудын шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байгаа эсэх талаар тодорхойгүй байна. Байгалийн ургамлын тухай Монголын улсын хуулинд (1995; 2004, 2010 онд шинэчлэгдсэн) ургамлын төрөл зүйлүүдийн элбэг, ховор болон нэн ховор гэсэн гурван ангиллыг тогтоосон: Гэвч энэхүү ангилал нь ОУБХХ-ны бүсийн ангиллын арга зүйтэй нийцэхгүй байгаа юм.

Монгол улсын хуулинд заагдсан ховор болон нэн ховор ургамлын төрөл зүйлүүд нь ихэвчлэн эмийн болон эдийн засаг, соёлын ашиг тус бүхий төрөл зүйлүүд байдаг. Юлдэн ерөндгөнө *Cynanchum gobicum* (*Vincetoxicum lanceolatum* гэж тэмдэглэгдсэн) болон Говийн бэрмэг (*Limonium gobicum*)-с бусад бүх төрөл зүйлүүд нь Монголын уудам Говийн бүс болон Хятадад тархсан бөгөөд баруун тийшээ төв Азийн орнууд руу илүү өргөн тархсан байдаг.

Оюу Толгой төслийн НБ-д тодорхойлогдсон ховор болон нэн ховор төрөл зүйлүүдийн мэдээллийг Хүснэгт 7.2-д нэгтгэн харуулав.

Хүснэгт 7.2: Монгол Улсын хуулиар ховор болон нэн ховор гэж тодорхойлогдсон төслийн НБ дэхь ургамлын төрөл зүйлүүд

Шинжлэх ухааны нэр	Монгол нэр	Тархац	Төслийн талбай	Ангилал
Phragmites communis	Эгэл нишинг	Олон улсад	Лицензит талбай	Ховор
Amygdalus mongolica	Монгол бүйлэс	Хятад (Ганьсу,Өвөр Монгол, Нинша), Монгол	Дэд бүтцийн зурвас (660893 N 4757410 E)	Ховор
Arnebia guttata (*Зураг 7.14*)	Шар бэрмэг, Толбот бэрээмэг	Афганистан, Хятад, Энэтхэг, Казахстан, Киргизстан, Монгол, Пакистан, ОХУ, Таджикистан, Түркменистан, Узбекистан	Дэд бүтцийн зурвас (42059’24,9 N 106051’12,9 E), Лицензит талбай	Нэн ховор
Artemisia xanthochloa	Шар шарилж	Хятад (Өвөр Монгол, Жижикү), Монгол	Дэд бүтцийн зурвас (42037’50,1 N 107032’52,16 E)	Нэн ховор
Asterothamnus centrali-asiaticus	Төв Азийн Лавай	Хятад (Ганьсу,Өвөр Монгол, Нинша, Чинхай, зүүн өмнөд Шинжаан),, Монгол	Дэд бүтцийн зурвас (653892 N 4760589 E), Лицензит талбай	Нэн ховор
Brachanthemum gobicum	Говийн Тост	Хятад (Өвөр Монгол, Бай ба бусад., 2008), Монгол	Лицензит талбай	Нэн ховор
Calligonum gobicum	Монгол азар	Хятад (Ганьсу, Өвөр Монгол, Шинжаан), Монгол (Зүүнгарын Говь, Алтайн цаадах Говь, Алашаа Говь)	Дэд бүтцийн зурвас (42042’35,8 N 107006’19.9 E)	Ховор
Caragana brachypoda	Хойрго, Харгана,	Хятад (Ганьсу, Өвөр Монгол, Нинша, Шаанси), Монгол	Дэд бүтцийн зурвас (653892 N 4760589 E), Лицензит талбай	Нэн ховор
Caragana gobica	Говийн харгана	Монгол (Дорноговь,Говь-Алтай;Гүбанов, 1996). Хайргархаг энгэр, хад чулуу, барьцалдсан конгломератын гарш (Грубов 2001)	Гүний хоолой? (Баримтжуулаагүй)	Нэн ховор
Caragana tibetica	Төвд харгана	Хятад (Ганьсу, баруун Өвөр Монгол, Нинша, Чинхай, хойд Шаанси, баруун Сичуань, Шизан), Монгол (Дорно Говь, Говь-Алтай, Алашаа Говь)	Дэд бүтцийн зурвас (660893 N 4757410 E)	Нэн ховор
Chesneya macrantha (*Oxytropis grubovii* хэмээн тэмдэглэгдсэн)	Грүбовийн ортууз	Хятад (Өвөр Монгол, Жижикү, Шинжаан Уйгур), Монгол	Дэд бүтцийн зурвас (42059’24,9 N 106051’12,9 E), Лицензит талбай	Нэн ховор
Chesniella mongolica (*Chesneya mongolica* хэмээн бүртгэгдсэн)	Монгол буурцгана	Хятад (Өвөр Монгол), Монгол (Их нууруудын хотгор, Дорно Говь, Алашаа Говь, Гүбанов, 1996). Давсархаг элс, уулс, толгодын элсэн нуранги, цөлийн бүсийн элс хайргархаг сайрын хурдас (Грубов 2001).	Лицензит талбай	Нэн ховор
Cistanche salsa	Марцний аргамжийн цэцэг	Монгол, Хятад, Казахстан Таджикистан, Түркменистан, Узбекистан	Лицензит талбай	Нэн ховор

Шинжлэх ухааны нэр	Монгол нэр	Тархац	Төслийн талбай	Ангилал
Cynanchum gobicum (*Vincetoxicum lanceolatum* хэмээн тэмдэглэгдсэн)[12]	Юлдэн ерөндгөнө	Монгол (Дорно Говь, Говь-Алтай, Зүүнгарын Говь, Алашаа Говь)	Дэд бүтцийн зурвас (659858 N 4751765 E)	Rare Ховор
Cynanchum thesioides (*Vincetoxicum sibiricum* хэмээн тэмдэглэгдсэн)	Сибир тэмээн хөх	Монгол, БНАСУ, Хятад, Казахстан, ОХУ	Лицензит талбай	Нэн ховор
Ephedra equisetina	Шивлээрэй зээргэнэ	Ганьсу, Хебей, Өвөр Монгол, Нинша, Чинхай, Шанси, Шинжаан, Афганистан, Казахстан, Киргизстан, Монгол, ОХУ, Тажикистан, Түркменистан, Узбекистан	Дэд бүтцийн зурвас (654204 N 4760506 E)	Нэн ховор
Ephedra dahurica (*Ephedra sinica* хэмээн тэмдэглэгдсэн)	Ямаан Зээргэнэ	Хятад (Ганьсу, Хебей, Хейлонжиан, Жилин, Лиаонин, Өвөр Монгол, Нинша, Шаанси, Шанси), Монгол	Лицензит талбай	Нэн ховор
Glycyrrhiza uralensis	Уралын Чихэр өвс	Афганистан, Хятад (Ганьсу, Хебей,Хейлонжиан, Лиаонин, Өвөр Монгол, Нинша, Чинхай,Шаанси, Шадонг, Шанси, Шинжаан,), Казахстан, Киргизстан, Монгол, Пакистан, ОХУ, Таджикистан.	Лицензит талбай	Нэн ховор
Gueldenstaedtia monophylla	Ганц навчит салжир	Монгол, Хятад, ОХУ (Жу, 2004)	Дэд бүтцийн зурвас (653424 N 4761061 E), Лицензит талбай	Нэн ховор
Limonium aureum	Алтан бэрмэг	Хятад, Монгол, ОХУ	Лицензит талбай	Нэн ховор
Limonium gobicum[13]	Говийн бэрмэг	Дорно Говийн давсархаг хялганат довцогт газар, Дорно говийн цөлөрхөг хээр. Мөн Хятадын Өвөр Монголд бүртгэгдсэн[14].	Дэд бүтцийн зурвас (665439 N, 4755002 E)	Ховор

[12] *Vincetoxicum lanceolatum* –г Грубовын (2000) номонд *Cynanchum gobicum* хэмээх нэрээр тэмдэглэсэн. Грубовын (2000) үзсэнээр энэ ургамал нь Дорно Говь, Говь Алтай, Зүүнгарын Говь, Алтайн өвөр Говь ба Алашаа Говьд тархдаг ажээ. Грубовын үзсэнээр (2001), энэ нь хад чулуурхаг, сүүдэртэй ам хавцал мөн урсацын голдирол даган ургадаг.

[13]Ж. Санжидын хийсэн судалгаанд алдаа гарсан хэмээн үзэж байна учир нь энэ зүйл Дорно Говийн энэхүү дэд бүсэд бүртгэгдээгүй. . *Limonium gobicum* нь "Дорно Говь" (Губанов, 1996) in "давсархаг хялганат довцогт газар" (Грубов, 2001) ургана. Энэ зүйлийн нь Хятадын ургамлын аймгийн номонд тэмдэглэгдээгүй боловч Хятадын өвөр Монголын нутагт бүртгэгдсэн бөгөөд *Limonium*.-н 6 зүйлийн эволюцийн биологийн тухай хэвлэгдээгүй дипломын материалд тэмдэглэгдсэн байна. 2010 оны 5-р сард Дорноговь аймгийн Даланжаргалан сумаас энэ зүйлийн дээжийг цуглуулсан байна. Чимэддорж ба бусад судлаачид (2009) Өмнөговь аймгийн устаж болзошгүй зүйл хэмээн оруулсан бөгөөд Дорноговийн цөл хээрийн ургамал-газарзүйн мужид багтана гэжээ. Энэ мужид Мандал-Овоо, Цогт-Овоо, Ханхонгор, Цогтцэций, Манлай, Ханбогд Баян- Овоо сумд орно.

[14] http://mt.china-papers.com/?p=53476

Шинжлэх ухааны нэр	Монгол нэр	Тархац	Төслийн талбай	Ангилал
Olgaea leucophylla	Цагаан навчит хас зул	Хятад (7 муж), Монгол	Лицензит талбай	Нэн ховор
Olgaea lomonosowii	Ломоносовын хас зул	Хятад (Ганьсу, Хебей, Жилин, Өвөр Монгол, Жижикү, Нинша, Шанси), Монгол	Дэд бүтцийн зурвас (660893 N 4757410 E)	Ховор (Улаан ном 1997)
Orobanche cernua (*Cistanche feddeana* хэмээн тэмдэглэгдсэн)	Феддийн аргамжийн цэцэг	Афганистан, Хятад, Казахстан, Киргизстан, Монгол, Непал, Пакистан, ОХУ, Таджикистан, Түркменистан, Узбекистан.	Лицензит талбай	Нэн ховор
Peganum harmala	Эгэл үмхий өвс		Дэд бүтцийн зурвас (42038’42.5 N 107031’24,5 E)	Нэн ховор
Populus euphratica (*P. diversifolia* хэмээн тэмдэглэгдсэн)	Элдэв навчит улиас		Дэд бүтцийн зурвас	Нэн ховор
Potaninia mongolica	Хулан хойрго, Монгол хулан хойрго	Хятад (_Өвөр Монгол, Жижикү), Монгол (Нууруудын хөндий Дорноговь, Говь-Алтай, Алашаа Говь)	Дэд бүтцийн зурвас (665439 N 4755002 E), Лицензит талбай	Нэн ховор
Sophora alopecuroides	Үнэгэн сүүлхэй лидэр		Булан Сухайт	Ховор
Stellaria dichotoma	Аман ажигана	Хятад (Ганьсу, Хебей, Хейлонжиан, Лиаонин, Өвөр Монгол, Нинша, Чинхай, Шаанси, Шинжаан), Монгол, ОХУ	Лицензит талбай	Ховор (1997 Улаан ном)
Tugarinovia mongolica	Монгол шар далан	Хятад (Өвөр Монгол, Жижикү), Монгол	Дэд бүтцийн зурвас(659272 N 4757928), Лицензит талбай	Нэн ховор
Zygophyllum potaninii	Аргалын ундаа, Хулангийн ундаа	Хятад (3 муж), Казахстан, Монгол	Дэд бүтцийн зурвас (660893 N 4757410 E), Лицензит талбай	Нэн ховор

Эх сурвалжууд: Эко-Трейд ХХК-ний БОНБНУ-ий нэмэлт тодотголууд; TROPICOS (www.tropicos.org); *Хятадын ургамлын аймаг* (http://www.efloras.org/flora_page.aspx?flora_id=2); *Монгол орны ургамлын аймгийн цахим хөтөч* (http://greif.uni-greifswald.de/floragreif/).

Зураг 7.14: Толбот бэрээмэг (Arnebia guttata), Уурхайн лицензит талбай, 2011 оны 5 сар

7.4 СУДАЛГААНЫ ҮР ДҮН – АМЬТНЫ АЙМАГ

7.4.1 Амьтны аймаг тархах газарзүйн орчин

Монгол орны амьтны аймаг нь хойд болон дорно зүгт Евро-Азийн ойт хээрийн амьтны төрөл зүйлүүд, өмнө болон баруун зүгт Төв Азийн говь цөлийн төрөл зүйлүүдээс бүрдэнэ. Монгол орны төвийн бүслүүр нь ойт хээрийн болон цөл хээрийн элементийг оруулсан завсрын бүс юм. Говийн бүсийн амьтны аймаг олон янз бөгөөд Төв Азийн болон Ойрхи дорнодын говь цөлд нийтлэг түгээмэл тархсан олон төрөл зүйлүүд байдаг. Гэвч Монгол орны өмнөд Говийн бүсийн нутгийн эндемик төрөл зүйл бага байгаа нь 50,000 км^2 буюу түүнээс бага газар нутагт тархсан “хязгаарлагдмал тархацтай” төрөл зүйлүүд энд байхгүй байдгаар нотлогдож байна. Монгол орны өмнө Говийн бүсэд хүн амын нягтшил бага, алслагдмал байдлаас хамаарч хөрш орнуудад ховордсон олон төрөл зүйлүүд үлдэж чадсан ба энэ нь өмнө Говийн амьтны аймгийг хамгаалах өндөр ач холбогдол бүхий газар болгож байна. Ховордсон олон чухал төрөл зүйлүүдийн амьдрах орчин болдог учраас Говийн Бага Дархан Цаазат Газрыг (2 хэсэгтэй) байгуулсан ба эдгээр нь Оюу Толгойн уурхайн лицензит талбайн баруун өмнөд болон зүүн өмнөд зүгт Монгол-Хятадын хилийн зурвас орчим байрладаг. Мөн дээрхи шалтгааны улмаас Дэд бүтцийн зурвас хөндлөн огтлож өнгөрөх Галбын Говийн “Шувуудад Чухал Газар“ (“ШЧГ”)-г тодорхойлсон.

7.4.2 Сээр нуруугүй амьтан

Өмнө Говийн сээр нуруугүй амьтдын талаар бүс нутгийн болон дэд бүсийн хэмжээнд хийгдсэн болоод нийтлэгдсэн системтэй судалгаа байдаггүй бөгөөд ашиглах хэвлэмэл бүтээл хомс юм.

Наганава, Загас нар (2002) Говь хээрийн бүсийн түр зуурын тогтоол усан дахь амьтны зүйлийг (*Branchiopoda)* судалж үзээд ерөнхийдөө энэ бүсийн талаарх мэдлэг хомс байгааг тэмдэглэсэн. Монгол орны томоохон *branchiopoda* ангийн амьтны зүйлүүд нь амьтны газар зүйн дөрвөн бүлгээс бүрддэг. Үүнд: Палеоарктикт өргөн тархсан, Неоарктикт хэсэгчилэн тархсан төрөл зүйлүүд, Ази тивээс үүсэлтэй унаган байж болох төрөл зүйлүүд, зүүн Азид үүсэж байгаа төрөл зүйлүүд, болон төв Монголын тал хээрийн бүсэд голчлон тархсан эндемик төрөл зүйлүүд зэрэг юм. Эдгээр судлаачдын судалсан газруудын аль нь ч өмнө Говийн бүс нутагт байдаггүй байна. Дэд бүтцийн зурвасын өмнөд хэсэгт голчлон тохиолдох улирлын чанартай ус хуримтлагдаж, зуны хэдэн долоо хоногт устай байдаг хотгор газар, тойрмуудад *branchiopoda* ангийн амьтад байх боломж бий (Эко-Трейд, 2004:17-18).

Монгол орны Говийн шоргоолжнууд нььг М. Пфайфер болон түүний хамтрагчид (2003, 2006) судалж, Монгол орны хэмжээнд тархсан шоргоолж нь ердөө 68 зүйлээс бүрддэг болохыг тогтоожээ. Тэд дүгнэхдээ хүйтэн өвлийн улирал нь шоргоолжны зүйлийн олон янз байдлыг хязгаарладаг

хүчин зүйл байж болох бөгөөд халуун цөлийн 2 зүйл шоргоолж Говь нутагт өргөн тархсан байгаа нь амьтны аймгийн зүйлийн олон янз байдал ядмаг байгааг харуулж байгаа бөгөөд их нь багыгаа барьж иддэг зарчмын жишээ байж болох юм гэжээ.

Төслийн БОНБНҮ-ний хүрээнд явуулсан судалгаа болон Оюу Толгойн Байгаль Орчны Хэлтсийн хийсэн судалгаанууд 300 гаруй зүйлийн үет хөлтөн байдгийг харуулж байна. Улс орны хэмжээнд зарим шинэ зүйлүүд бүртгэгдэж байгаа ч, өнөөг хүртэл олж тодорхойлсон зүйлүүдийн дотор эндемик болон хамгаалах шаардлагатай зүйл байхгүй байна.

7.4.3 Загас

Төслийн Нөлөөллийн Бүс дэхь байнгын ундаргатай булаг шанд болон түр зуурын урсацтай уст цэгүүдийн алинаас нь ч загас олдоогүй. Монгол орны баруун хэсгийн нууруудын хөндийд хэд хэдэн эндемик загасны зүйлүүд байдаг тухай мэдээ байгаа боловч, одоо байгаа хэвлэмэл бүтээлүүдэд өмнө Говьд загасны популяци байдаг талаар дурьдаагүй байна (жишээ нь, Коттелат, 2006, Окок ба бусад 2006). Гэвч Коттелат (х.65) Говийн нууруудын хөндийн зарим булаг болон Монгол-Хятадын хил орчмын нутагт загас нутагшиж байсан талаар түүхэн мэдээлэл байгааг дурьдсан боловч сүүлд нь дээр үеийн Оросын экспедицийн аяллын маршрутыг судалж үзээд уг газрууд нь Монголд биш, Хятадад (Хөх нуур буюу Төвд) Шар мөрний эх орчим байсныг тогтоосон байна (Коттелат). Гэсэн хэдий ч, энэ тал дээр мнө Говийн байнгын ундаргатай булаг шандууд дээр судалгаа хийх нь зүйтэй боловч, БТЗТҮ-ний судалгааны ажлын явцад үүнийг хийх боломжгүй байв.

7.4.4 Газар усны амьтан

Монгол орны Говийн бүсээс болон төслийн талбайд оршдог цорын ганц хоёр нутагтан бол ОУБХХ-ны ангиллын дагуу Монголын Улаан дансанд (Тэрбиш ба бусад, 2006) анхааралд өртөхөөргүй гэж бүртгэсэн, Монгол бах (*Pseudepidalea raddei*) бөгөөд энэ зүйл амьтан нь Хятад, БНАСУ, ОХУ-д (Кузьмин ба бусад, 2004) мөн байдаг байна. Төслийн талбайд, энэ бах нь хавар эрт ичээнээс гарах үедээ Бор Овоо зэрэг тогтмол ундаргатай булаг шанд болон боржин массивын бэлээр орших булаг шандны орчимд үржилд ордог байна (Зураг 7.15).

Зураг 7.15: Ханбогд дахь Монгол бахын шанаган хорхой (Pseudepidalea raddei), 2011 оны 5-р сар

7.4.5 Хайрст амьтад (гүрвэл, могой)

Монгол орны өмнөд хэсгийн говь цөлд хатуу ширүүн улирлын нөхцөл болон хуурай болон хагас хуурай нөхцөлд дасан зохицсон хэдэн зүйлийн өргөн тархацтай гүрвэл болон могойны зүйлүүд тархсан байдаг. Төслийн НБ-д өнөөг хүртэл хийсэн судалгаанд (В хавсралтад үзүүлснээр) найман зүйлийн гүрвэл болон таван зүйлийн могой байдаг хэмээн тэмдэглэгдсэн байна (Зураг 7.16-аас Зураг 7.18 хүртэлх зургуудыг үз). Оюу Толгойн төслийн нөлөөллийн бүсд бүртгэгдсэн гүрвэл болон могойны зүйлүүдийн аль нь ч ОУБХХ-ны ангиллаар дэлхийн хэмжээнд ховордсон ангилалд буюу улсын хэмжээнд Монгол орны хэвлээр явагч болон хоёр нутагтны Улаан дансанд (Тэрбиш ба бусад, 2006) ховордсон хэмээх ангилалд багтаагүй байна. Ерөнхийдөө, өмнө Говь дахь гүрвэл болон могойн зүйлүүд тус бүсд явагдаж буй янз бүрийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааны нөлөөгөөр ховордох аюул бага байна.

Гүний Хоолойн ус ашиглах БОНБНҮ-ий тайлангийн (2005) нэмэлт тодотголын Англи хэл дээрхи хувилбарт дурьдсан *Cyrtopodion elongatum* зүйл гүрвэл нь эмзэг (Тэрбиш ба бусад, 2006) хэмээх ангилалд багтдаг бөгөөд үүнийг Монгол хэл дээрх хувилбартай тулгаж үзэхэд төмөр гүрвэл (*Alsophylax pipiens)* хэмээх зүйл байсныг тогтоосон ба энэ зүйл нь Оюу Толгой төслийн нөлөөллийн бүсд тодорхойлогдсон амьтны аймагт багтаагүй болно.

Зураг 7.16: Говийн гүрвэл (Eremias przewalskii), Бор Овоогийн булаг, 2011 оны 5 сар

Зураг 7.17: Хонин гүрвэл (Phrynocephalus cf. przewalskii), Уурхайн Лицензит талбай, 2011 оны 5 сар.

Зураг 7.18: Нарийн могой (Coluber spinalis), Ханбогд сумын нутаг, 2011 оны 5 сар

7.4.6 Шувуу

Төслийн НБ-д доод тал нь 137 зүйлийн шувуу бүртгэгдсэн бөгөөд Оюу Толгойн төслийн биологичид энэхүү жагсаалтанд байнга шинэ шинэ төрөл зүйлүүдийг нэмэн оруулсаар байгаа юм (Хавсралт В, Хүснэгт А-3). ОУБХХ-ны ангиллын дагуу эдгээрээс 1 зүйл нь дэлхийн хэмжээнд устаж болзошгүй, 6 зүйл нь дэлхийн хэмжээнд эмзэг, 1 зүйл нь ховордож болзошгүй, 2 зүйл нь анхааралд өртөхөөгүй хэмээх ангилалд багтдаг ажээ (**Error! Reference source not found.**). Монголын Улаан Дансан дахь шувуудын жагсаалтыг хянаж, хараахан хэвлээгүй байгаа ба одоогоор байгаа жагсаалтыг 7.3-р хүснэгтэд үзүүлэв (TBC/FFI Хавсралт С). Эдгээр ховордсон зүйлүүдийн хэд хэд нь Оюу Толгой

төслийн нөлөөллийн бүсэд үл ялиг тоотойгоор орших боловч урьдчилан сэргийлэх үүднээс оруулсан болно.

Хүснэгт 7.3: Оюу Толгой төслийн НБ дэхь дэлхийн хэмжээнд ховордсон шувуудын төрөл зүйл

Зүйлийн нэр	Ерөнхий нэр	Ангилал (ОУБХХ/МУД)	Дэлхийн хэмжээнд тулгарч байгаа аюул	Дэлхийн хэмжээн дэх популяцийн тоо, тархац нутаг
Neophron percnopterus	Дэлт ёлон	Устаж болзошгүй / Анхааралд өртөхөөргүй	Африк тивд тоо толгой буурсан шалтгаан нь зэрлэг туурайт амьтдын тоо толгой буурч, бэлчээр газар нь малын хөлөөр талхлагдсантай холбоотой. Амьдрах орчны доройтол, (бууны сумны) тугалгаар бохирдох, өндөр хүчдэлийн шугамтай мөргөлдөх зэрэг нь одоогоор Европ дахь популяцийн тоо толгойд нь нөлөөлж байна. Энэтхэгт Diclofenac гэдэг малын эм нь тоо толгойг эрс бууруулж байна. Мороккод энэхүү амьтны гаралтай бүтээгдэхүүнийг уламжлалт анагаах ухаанд хэрэглэдэг.	Популяцийн тоо толгойн хэмжээ: 30,000-42,000 нас бие гүйцсэн бодгаль. Морокко болон Баруун Африкийн зарим хэсгээр Кэйп Вердэ болон Канарийн арлуудад алслагдмал тусгаар популяцууд байдаг. Багахаан популяцууд Ангол, Намбид байдаг. Гол томоохон популяцууд нь Етиоп болон Зүүн Африк, Араб, Энэтхэгт байна. Нүүдлийн шувууд өмнөд Европт баруун талдаа Испаниас Газар дундын тэнгисээр дайран нүүдэллэдэг ба Кавказ, төв Азиас Пакистан, Хойд Энэтхэг болон Непал хүртэлх нутагт үрждэг.
Anser cygnoides	Хошуу галуу	Эмзэг / Ховордож болзошгүй	Орос улсад гол аюул нь ан агнуурыг замбараагүй ихээр хийж байгаа явдал, үржлийн болон гуужих газрыг бохирдуулах мөн газар хагалж тариаланд ашиглах зэрэг юм. Хятадад, шувуудын амьдрах орчинд хөдөө аж ахуйг хөгжүүлснээр ус намгархаг газруудыг сүйтгэж, газрын доройтлыг нэмэгдүүлж байна. Хятадад өндөгийг нь түүн авах, ан хийх явдал нь аюулд хүргэж байна. Уг амьтны өвөлждөг ус намгархаг газрууд бүтээн байгуулалт болон бохирдлын улмаас улам бүр хэцүү байдалд орж байна.	Популяцийн тоо толгойн тооцоо: 60,000-80,000 нас бие гүйцсэн бодгаль. 1,620,000 км^2 газар нутагт тархсан. Орос - Монголын хил болон Хятадад гол үржлийн газар байна. Бусад чухал үржлийн газруудад Амур мөрний адаг, Сахалины арлын баруун хойд тал, Ханх нуур, Орос, баруун Монгол болон Хятад зэрэг орно. Гол өвөлждөг газрууд нь Хятадын Жансу мужид далайн эргийн дагуу, Хөх мөрний сав газраас Поянг Ху болон Донгтинг Ху нууруудын орчим юм.
Otis tarda	Хонин тоодог	Эмзэг / Эмзэг	ХАА-н үйл ажиллагаа эрчимжсэний улмаас амьдрах орчин нь хэсэглэн хуваагдах буюу устах зэрэг нь гол аюулууд болно. Машин механикжуулалт, химийн бордоо, шавьж устгах хор, гал түймэр, махчин амьтад зэрэг бүгд өндөг, ангаахай болон өсөлт бойжилтын үедээ байгаа тоодогийг ихээр хорогдоход хүргэж байна. Агнуур хийх явдал Морокко, Сири, Турк, Украин болон Хятадад гол аюулыг бий болгодог бөгөөд өндөр хүчдэлийн шугамтай мөргөлдөх нь бас гол хүчин зүйл болж байна.	Популяцийн тоо толгойн тооцоо: 45,000 нас бие гүйцсэн бодгаль. Тархац нутаг : 2,350,000 км^2 газар. Морокко (150 шувуу), Португаль (1,435 шувуу), Испани (23,055-25,000 шувуу), Австри, Герман, Словак, Унгар (1,100-1,300 шувуу), Болгар, Румын (бараг устсан), Молдав, Турк (800-3,000 шувуу), Иран, Орос (8,000 шувуу), Украин, Казакстан, Киргикстан, Тажикстан, Узбекстан, Монгол (1,000 шувуу), Хятадад (2,250-3,300 шувуу) үрждэг.
Chlamydotis undulata (Зураг 7.22)	Жороо тоодог	Эмзэг / Эмзэг	Гол аюул нь энэхүү зүйлийн өвөлждөг газарт Ойрх Дорнодын шонхор шувууны анчид ихэвчлэн ирж ан хийдэг явдал юм. Амьдрах орчин устах мөн доройтсох зэрэг нь асуудлыг хүндрүүлж байна.	Популяцийн тоо толгой: 49,000 - 62,000 нас бие гүйцсэн бодгаль бий хэмээх тооцоо байна. Тархац нутгийн хэмжээ: 24,200,000 км^2. Тоодог нь Египетийн Нил мөрний зүүн эргээс Израйл, Иордан, Леван, Саудын Араб,

Зүйлийн нэр	Ерөнхий нэр	Ангилал (ОУБХХ/МУД)	Дэлхийн хэмжээнд тулгарч байгаа аюул	Дэлхийн хэмжээн дэх популяцийн тоо, тархац нутаг
				Емени, Оман, Арабын Нэгдсэн Эмират, Бахраин, Катар, Кувейт, Сийр, Ирак, Иран, Афганистан, Казахстан, Киргизстан, Пакистан, ОХУ, Тажикистан, Монголоос Хятад хүртэл тархсан. Азербайжан болон Туркэд бий гэсэн баталгаагүй мэдээ байна.
Falco cherrug	Идлэг шонхор	Эмзэг / Эмзэг	ХАА-н эрчимжилт, тариаланжуулалт , хонь бэлчээрлүүлэх нь буурсан зэргийн улмаас тал хээр, хуурай бэлчээр устаж доройтох нь гол идэш тэжээлийн зүйлүүдийн тоо толгой буурахад хүргэж байна. Шонхорыг наймаалахын тулд барих нь мөн асуудал үүсгэж, орон нутагт устаж үгүй болгоход хүргэж байна.	Популяцийн тоо толгойн тооцоо: 19,200 - 34,000 нас бие гүйцсэн бодгаль. Тархац нутгийн хэмжээ: 10,300,000 км^2 газар нутаг. Австри, Унгар, БНЧУ, Словак, Серби болон Монтенегро, Болгар, Румын, Молдав, Беларусь, Украин, Турк, Ирак, Армен, ОХУ, Узбекстан, Тажикстан, Киргизстан, Казахстан, Монгол, Хятад зэрэг орнуудад үрждэг.
Larus relictus	Реликт цахлай	Эмзэг / Устаж болзошгүй	Усны түвшинд өөрчлөлт орох нь үржил амжилттай явагдахад нөлөөлж, үржлийн газрын төлөөх өрсөлдөөн, бусад цахлай барьж идэх, мөндөр шуурга, үер зэргийн улмаас хорогдож байна. Орос, Хятадад хүний үйл ажиллагааны улмаас өндөг, ангаахайн хорогдол нэмэгдэж, цаг агаар муудах, махчин амьтны дайралт мөн үр төлөө голох зэрэгт өртөмтгий болгосон. Өмнөд Солонгост Накдун голын адагийн татамыг хүмүүс эзэлсэн бөгөөд бусад олон эргийн татмууд бүтээн байгуулалтын улмаас иймэрхүү нөлөөнд өртөж байна.	Популяцийн тоо толгойн тооцоо: 2,500-9,999 нас бие гүйцсэн бодгаль. Тархац нутаг: 1,380,000 км^2 газар нутаг. Казакстанд хоёр газар, Оросд нэг, Монголд хэд хэдэн газар үрждэг бол, томоохон сүрэг нутагшсан газар нь Хятад гэж үздэг. Үүнд Шаанси мужийн Хонжиан нуур, мөн өмнө нь Өвөр Монголын Ордосын тал газрын Таолимиао-Алашан нуурт байсан гэж үздэг боловч одоо энэ газрыг хассан. Үржлийн бус тархац нутагийн талаар мэдээ хомс боловч, Өмнөд Солонгос, Хятадын зүүн эргээр өвөлждөг болох нь тогтоогдсон. Мөн Хятадын Чинхай-Төвдийн тэгш өндөрлөг газрын хойд хэсэгт өвөлждөг тухай баримт байна. Үржлийн болон өвөлжих газар нь цаг агаараас шалтгаалан ихээхэн өөрчлөгдөж байдаг.
Emberiza aureola	Шар элэгт хөмрөг	Эмзэг / Ховордож болзошгүй	ОУБХХ энэхүү зүйлийг эмзэг ангилалд багтаан зэрэглэл нэмсэн. Гэвч энэ зүйл орон нутгаар элбэг байгаа боловч шувууд өвөлжиж буй нутагт шувуудыг олноор барьснаар тоо толгой нь эрчимтэй буурч байна хэмээх үнэмшихэд бэрх мэдээ байна. Монголд уур амьсгалын хуурайшил, үржлийн нутагт нөлөөлөх байдал зэргээс тус амьтны үржил буурч байна.	Популяцийн тоо толгойн тооцоо: 120,000-1,000,000 нас бие гүйцсэн бодгаль. 15,700,000 км^2 газар нутагт тархсан. Энэ зүйл нь Палеоарктик даяар Финляндаас хойд Япон хүртэл газарт /Монголын хойд хэсгийг оруулаад/ үрждэг. Өвөлдөө Индо-Бирма, Хятадын өмнөд хэсэг болон Өмнөд Азийн хойд хэсгээр байдаг. Оюу Толгойн НБ-ийг зөвхөн нүүдэллэх үедээ дайрч өнгөрдөг бөгөөдтөслийн талбайд тэмдэглэгдсэн мэдээ цөөн байдаг.
Circaetus gallicus	Могойч	Анхааралд	Дэлхийн хэмжээнд энэ зүйлийг ховордсон гэж үздэггүй.	Популяцийн тоо толгойн тооцоо: 51,000 - 156,000 нас бие

Зүйлийн нэр	Ерөнхий нэр	Ангилал (ОУБХХ/МУД)	Дэлхийн хэмжээнд тулгарч байгаа аюул	Дэлхийн хэмжээн дэх популяцийн тоо, тархац нутаг
	загалай	өртөхөөргүй / Устаж болзошгүй		гүйцсэн бодгаль. Тархац нутгийн хэмжээ: 13,000,000 км^2 . Европ, Ази болон Африкаар өргөн тархсан.
Aythya nyroca	Ундар шумбуур	Ховордож болзошгүй / Эмзэг	Жилээс жилд энэ зүйлийн тархац нутаг ялангуяа Азид усны түвшин өөрчлөгдөж байгаагаас шалтгаалан ихээхэн өөрчлөгдөж байж болно. Тйимээс дэлхий хэмжээнд популяцийн тоо толгойг тооцоолоход их бэрхшээлтэй байдаг. Европд тоо толгой нь огцом буурч байгаа ч, Ази дахь томоохон популяцуудад тоо толгой бууралтын шинж тэмдэг бага буюу заримдаа үүний эсрэг мэдээ ч байна. Иймд ОУБХХ одоогоор Ховордож болзошгүй гэсэн ангилалд багтаажээ. Хэрэв Ази тивд тоо толгой огцом буурч байгаа нь батлагдвал энэ зүйлийг Эмзэг хэмээх ангилалд багтаах боломж олгоно.	Популяцийн тоо толгойн тооцоо: 160,000 - 257,000 нас бие гүйцсэн бодгаль. Тархац нутгийн хэмжээ: 3,610,000 км^2 газар нутагт тархсан. Азийн баруун өмнөд хэсэг (Хятадын зүүн хэсэгт Энэтхэг Пакистаны өмнө зүгт), төв болон зүүн Европ, хойд Африкаар үрждэг. Өвөлжих нутаг нь үржлийн бүс нутагтай давхцдаг бөгөөд Ойрхи Дорнод, зүүн хойд болон баруун Африк (голчлон Мали болон Нигер) болон зүүн өмнөд Азид байна.
Podoces hendersoni	Хулан жороо	Анхааралд өртөхөөргүй / Эмзэг	Дэлхийн хэмжээнд энэ зүйлийг ховордсон гэж үздэггүй.	Дэлхийн хэмжээн дэ популяцийн тоо толгойн хэмжээг нь тодорхойлоогүй байгаа болно. Гэвч энэ зүйл амьтан Казакстанд нэн ховор, Монголд элбэг бус Хятадад харьцангуй элбэг бус гэж бүртгэгдсэн. Оросд мөн тохиолддог байна.

Эх сурвалж: Шувууд, Олон улсын мэдээллийн сан: www.birdlife.org/datazone *ба ОУБХХ-ны Улаан Дансны ховордсон төрөл зүйлүүд. 2011.1:* www.iucnredlist.org.

Зураг 7.19: Хайлаас модон дээр сууж буй бөвөөлжин өвөөлж, УЛТ-н орчимд, 2011 оны 5 сар

Зураг 7.20: Хонин гүрвэл зуусан Зээрд шонхор, 2011 оны 5 сар

Зураг 7.21: Дэд бүтцийн зурвасын орчимд байгаа Монгол ногтруу, 2011 оны 5 сар

Зураг 7.22: Жороо тоодог, Галбын Говийн ШЧГ

Эх сурвалж: Б. Нямбаяр

Уурхайн лицензит талбайд 2005 онд явуулсан БОНБНҮ-нд Ханбогд сумын Цагаан Булагийн орчим 1963 онд хийсэн судалгааны илтгэлээс үндэслэн дэлхийн хэмжээнд устаж болзошгүй Янковскийн хөмрөг (*Emberiza jankowskii*) дурьдсан. Энэхүү илтгэлийг Гүний Хоолойн БОНБНҮ-ний нэмэлт тодотголд мөн дурьдсан байна. Гэсэн ч, Мауерсбергер (1978) нь Пиечоки, Болод (1972) нарын Монголд хийсэн судалгааны үр дүнд алдаа гарсан гэж үзсэн бөгөөд энэ төрөл зүйл Монголд байдаггүй гэж үзсэн байна ("Бэрд Лайф Интэрнэшнл", 2011).

Монгол орон нь умард зүгт байрладаг, хатуу ширүүн өвлийн улиралтай байдгаас улбаалан өвөлждөг шувуудын төрөл зүйл цөөн байдаг. Чухал амьдрах орчныг тодорхойлох (7.5 хэсгийг үзнэ үү) зорилгоор хийгдсэн судалгааны нэгжээс тогтоогдсон бараг 200-гаад зүйлийн шувуунуудаас 174 нь нүүдлийн шувууд бөгөөд үүний зарим зүйл нь конгрегатив шувууд байсан байна. Гэвч, энэхүү нүүдлийн шувууд нь Оюу Толгойн НБ-д тохиолдож байдаг хэдий ч, Оюу Толгойн НБ нь нүүдлийн шувуудын популяцийн 1%-с илүү тоогоор тогтмол цуглардаг газар хэмээн батлах үзүүлэлт одоогоор байхгүй байна, гэвч энэ бүсийн түр зуурын уст цэг нуур тойрмуудад тохиолдлын байдлаар эргийн шувуудын томоохон цугларалт болдог нь тэмдэглэгдсэн байна (Н. Вон Вехрден, TBC/FFI-аас иш татав, 2011).

Өмнө Говьд эндемик шувууны төрөл зүйл байдаггүй, учир нь ихэнх төрөл зүйл нь Төв Азийн говь цөл, тал хээр нутгаар өргөн тархсан байдаг. Монголд цорын ганц эндемик шувуудын бүс нутаг бүртгэгдсэн нь "Монгол орны уул нурууд" юм. Энд козловын хайруулдай (*Prunella koslowi*) зүйлээр төлөөлөгдөж байгаа юм. Энэ зүйл нь тун бага зүйл судлагдсан бөгөөд арцны бут юмуу уулын хажуу энгэрийн хуурай өвсөн дунд үрждэг (2,000 м д.т.д) ("Бэрд Лайф Интэрнэшнл", 2011). Энэ бол Монгол оронд мэдэгдэж байгаа эндемик- хзгаарлагдмал тархацтай цорын ганц шувууны зүйл бөгөөд (Монгол улсын зэрлэг амьтдын Шинжлэх ухаан, Хамгаллын Төв, 2011) Оюу Толгойн НБ нь харьцангуй нам доор газарт байдаг тул Төслийн НБ-д байдаггүй боловч баруун тийш Баян-Овоо сумын уулсад үзэгддэг байна.

7.4.7 Хөхтөн

Оюу Толгойн НБ нь жижиг хөхтөн (жишээлбэл, алагдаахай, чичүүл, багваахай, зараа), махчин амьтад (жишээлбэл, суусар, зэрлэг муур, үнэг, чоно) болон өмнө Говийн бүс нутагт нийтлэг тохиолддог томоохон өвсөн тэжээлтэн амьтдаар баян юм. Энэхүү бүс нь хулан (*Equus hemionus*, Зураг 7.23, ЗурагЗураг 7.24) болон хар сүүлт зээр (*Gazella subgutturosa*) зэрэг түүхэн тархац нутгийнхаа ихэнхи хэсэгт устаж үгүй болсон дэлхийн хэмжээнд чухал популяцуудын гол амьдрах нутаг болж байна. Хад чулуу, уулархаг бүс нь янгир (*Capra sibirica*) болон аргалийн (*Ovis ammon*) амьдрах нутаг болж байдаг.

Оюу Толгой төслийн нөлөөллийн бүсд нэн тэргүүнд хамгаалах шаардлагатай зүйл амьтан бол хулан юм. Энэ зүйлийн ОУБХХ болон Монгол орны хөхтөн амьтны улаан дансанд (Кларк, ба бусад. 2006) устаж болзошгүй хэмээх ангилалд багтаасан. Өмнө Говийн бүсэд хулангийн дэлхийн хэмжээнд чухал популяцуудын талаар сайн судлагдсан боловч энэхүү нүүдлийн зүйл амьтны амьдрах орчин нь зам тээврийн дэд бүтэцүүдийг (Таван Толгой-Гашуун Сухайт чиглэлийн "нүүрсний зам" ба Улаанбаатар-Бээжин чиглэлийн төмөр зам) байгуулснаар мөн Монгол-Хятадын хилийн зурвас дагуух хашаа зэргээс үүдэн янз бүрийн хэмжээнд хэсэгчлэгдэн хуваагдсан байна (Каженский ба бусад, 2006, 2011). П. Каженский (TBC/FFI-аас иш татав, 2011) 400 авто машин өдөрт зорчих үед хулангийн шилжилт хөдөлгөөний хувьд ноцтой экологийн саад болно харин 1000 авто машин өдөрт зорчих үед экологийн хувьд бүрэн тусгаарлалт болно хэмээн үзжээ. Оюу Толгойн төслөөс саяхан явуулсан тээврийн хэрэгслийн хөдөлгөөний тооллогоор (Бүлэг 11: Тээвэр-т авч үзсэн) нүүрсний замаар өдөрт 800 авто машин зорчдог бол Оюу Толгой – Гашуун Сухайт замд өдөрт 250 авто машин зорчдог болохыг тогтоожээ. Үүнээс үзэхэд Оюу Толгой-Гашуун Сухайтын замын тээврийн хөдөлгөөн нь хулангийн шилжилт хөдөлгөөнд ноцтой тусгаарлалт үүсгэхээр хэмжээнд байхгүй байгаа боловч нүүрсний зам дагуух хөдөлгөөн нь экологийн бүрэн тусгаарлалт үүсгэхэд ойрхон түвшинд хүрсэн байна. Дэлхийн Банкнаас хэвлүүлэн гаргасан "Өмнө Говийн бүсийн байгаль орчны үнэлгээ" тайланд (Валтон 2010, xy vx xy 94) дурьдсанчлан Говийн Бага Дархан Цаазат Газрын даргын 2008 онд өгсөн ярилцлагын дагуу бол "Говийн Бага Дархан Цаазат Газрын А болон Б хэсгийн хооронд хулан болон хар сүүлт зээрийн хөдөлгөөн хилийн зурвас хүртэл үргэлжлэх замын хөдөлгөөнөөс үүдэн явагдах боломжгүй болсон" гэжээ. Гэсэн хэдий ч хулангийн сүрэг замын баруун болон зүүн аль аль талаар ажиглагдаж байна (Зураг 7.23 ба Зураг 7.24).

Оюу Толгойн НБ-д бүртгэгдсэн бүх хөхтөн амьтдын төрөл зүйлүүдийн жагсаалтыг Хавсралт В-н Хүснэгт А-4-т үзүүлсэн. Дэлхийн хэмжээнд болон үндэсний хэмжээнд устаж болзошгүй гэж тооцогдож байгаа (ө.х, ОУБХХ-ний Улаан Дансны Ховордсон төрөл зүйлүүдийн жагсаалтын 2011.1 сард хэвлэгдсэн тайлан болон Монгол орны хөхтөн амьтды улаан данс 2006-д Эмзэг буюу Устаж болзошгүй гэж ангилагдсан) төрөл зүйлүүдийг доорхи Хүснэгт 7.4-д үзүүлэв.

Хүснэгт 7.4: Оюу Толгой төслийн НБ дэхь ховордсон хөхтөн амьтад

Зүйлүүд	ОУБХХ-ны ангилал[15]	Үндэсний ангилал	Тохиолдож буй аюул	Дэлхийн хэмжээн дэх популяцийн тоо толгой, тархац нутаг
Соотон алагдаага (*Euchoreutes naso*)	Анхааралд өртөхөөргүй	Эмзэг	Малын тоо толгой ихээр өсч бэлчээрлэх явдлаас үүдэн амьдрах орчин доройтох (нэмэлт нотлох баримт шаардлагатай). Хүний үйл ажиллагааны оролцоо мөн толорхой хэмжээнд аюул учруулж байж болно. Уст цэгүүд хатах, ган гачиг зэрэг нь мөн энэ зүйлд аюул учруулж байна. Гэвч энэ нь байгаль цаг уурын өөрчлөлтийн илрэл үү эсвэл хүний үйл ажиллагааны оролцоо эсэх тодорхойгүй байна.	Хятад, Монгол. Монголд Алтайн өвөр Говьд болон Алашаны Говийн амьдрах орчинд тархсан. Монгол улс нь энэхүү зүйлийн дэлхий нийтээрх тархац нутгийн хойд хязгаар болдог. Хятадад Шинжаан, Ганьсу, Чинхай, Өвөр Монгол, Нинсиа мужуудын хуурай бүсүүдэд мөн бүртгэгдсэн. 2011 БТЗТҮ-ий судалгаагаар Дайчин загийн заган ойгоос эхлээд ” хайргархаг тэгш тал ” газар байрлах Булш хуурай сайрын дагуу буюу Оюу Толгой- Гашуун Сухайт чиглэлийн цахилгаан дамжуулах шугамын баруун тийш нутагт тархсан. Энэ нь соотон алагдааганы популяцийн одоо мэдэгдэж байгаа тархац нутгийн хамгийн зүүн зах юм.
Ирвэс (*Panthera uncia*)	Устаж болзошгүй	Устаж болзошгүй	Хойд мужуудаар (Орос, Монгол, Алтай, Хятадын Тяньшаний нуруу орчмоор) тулгарч байгаа аюул нь арьс үс, ясыг нь наймаалахын тулд хулгайгаар агнах, зохих бодлого байхгүй, хуулийг хэрэгжүүлдэггүй, боловсон хүчин ба байгууллагын дутагдалтай байдал, орон нутгийн хүмүүс, бодлого боловсруулагчдын дунд мэдлэг бага, хүн амын өсөлт, ядуурал зэрэг нөлөөлж байна.	Төв Азийн өндөр уул нуруудаар тархац нь хязгаарлагдсан, гол тархац нутгууд нь Алтай, Тяньшиний нуруу, Кун Лун, Памир, Хинду Куш, Хархорум, Гималайн нуруу зэрэг болно. Дэлхий нийтээр байгаа тоо толгой нь 4,080-6,590-д тоологдсон. Оюу Толгойн Шууд нөлөөллийн бүсэд бүртгэгдээгүй, боловч бүс нутгийн хэмжээнд тохиолддог.
Эрээн хүрнэ (*Vormela peregusna*)	Эмзэг	Мэдээлэл дутмаг	Энэ зүйлд тулгарч байгаа гол аюул нь тал хээр болон говь цөлийн амьдрах орчин алдах явдал юм. Европт тал хээрийн амьдрах орчныг тариалангийн газар болгон хувиргаснаас багасч байгаа. Мэрэгчдийг устгах хор хэрэглэх нь дам хордуулах мөн гол хоол тэжээл болох зүйлүүдийн тоо буурах явдал мөн орно. Хятадад цөлжилт энэ зүйлд хамгийн гол аюулыг учруулж байна.	Афганистан, Армени, Азербайжан, Болгар, Хятад, Гүрж, Грек, Иран, Ирак, Израйл, Казакстан, Ливан, Македон, Монгол, Монтенегро, Пакистан, Румын, ОХУ, Серб, Арабын Серийн БНУ, Турк, Туркменстан, Украйн, Узбекстан.
Хулан (*Equus hemionus*)	Устаж болзошгүй	Устаж болзошгүй	Монгол дахь тоо толгой нь хууль бус агнуурын улмаас эрсдэлд учирч байгаа бөгөөд 1997 онд тооцсон тоо болох 43165-аас үлэмж ихээр буурсан. Жилд 3000	Түүхэн тархац нутгийнхаа ихэнхид устаж алга болсон бөгөөд гол томоохон популяцууд нь зөвхөн Хятад, Энэтхэг, Иран, Монгол, Туркменстанд үлдсэн байна.

[15] DD= Мэдээлэл дутмаг, EN= Устаж болзошгүй, LC= Анхааралд өртөхөөргүй, NT= Ховордож болзошгүй, VU= Эмзэг

Зүйлүүд	ОУБХХ-ны ангилал[15]	Үндэсний ангилал	Тохиолдож буй аюул	Дэлхийн хэмжээн дэх популяцийн тоо толгой, тархац нутаг
			орчим толгой хуланг махыг нь худалдахын тулд хууль бусаар агнаж байна гэсэн тооцоо байна. Хэрэв энэ хууль бус ан Монголд үрэлжилсэн хэвээр байвал энэхүү чухал популяци жилд 5-10%-аар буурах болно. Үржил өсөлт (үр зулзагын тоо) нь 3-23%-д хэлбэлзэж байдаг. Тэгэхээр боломжит цэвэр хорогдол нь жилд 5-10% байхаар байна. Иймд 21 жил буюу 3 үе өнгөрөхөд энэхүү популяцийн хорогдол 50-иас дээш хувь байхаар байна. Монголын хувьд бусад аюулууд нь хүн ам шинээр суурьших болсон (уст цэгүүд амьтдад хүртээмжгүй болсон), ашигт малтмал олборлох (уул уурхай), бэлчээрлэх малын тоо толгой өссөн (цаашид нотлох баримт шаардлагатай) зэргийн улмаас амьдрах орчин доройтож /алдагдаж байгаа явдал юм. Хашаажуулалт хийсний улмаас амьдрах орчныг хэсэгчилэн хуваах, өргөн орон зайд шилжилт хөдөлгөөн хийхийг хязгаарлах зэрэг нь Улаанбаатар-Бээжин чиглэлийн төмөр зам, Хятад-Монголын хилийн дагуу хамгийн гол бэрхшээлийг үүсгэж байна. Мөн энэ нь байгалийн баялгийг олборлохтой холбоотойгоор зам тавих, төмөр зам тавих зэргээс үүдэж байна.	Үлдэж хоцорсон хамгийн том дэд зүйлийн популяци бол Монгол Хулан бөгөөд 2003 онд дөрвөн газар 18,411 +/- 898 гэж тоологдож байсан. Монголын өмнөд хэсэгт хулангийн хамгийн том популяци байгаа бөгөөд дэлхийн нийтээрх тоо толгойн бараг 80%-ийг төлөөлдөг. Хятадын Каламейлийн нөөц газарт Хулан 4,800-аас 6,000 орчим толгой байж болох боловч энэ нь Монголоос улирлын чанартай нүүдэллэн очижбуй пропуляци байж болох юм. Сүүлийн үеийн баримтаас үзэхэд Монгол дахь популяцийн тархац нутаг нь өргөжсөн буюу сүүлийн 20-25 жилд хойд болон зүүн зүг рүү шилжин Улаанбаатар-Бээжингийн төмөр замыг хөндлөн гарах нь ховор болсныг харуулж байна. Зүүн гарын говьд орших Говийн Их Дархан цаазат газрын Б хэсэгт , мөн Алтайн өвөр говьд орших Говийн Их Дархан цаазат газрын А хэсэгт чухал популяцууд байдаг. Нас бие гүйцсэн хулангийн дэлхий нийтээрх тоо толгой сүүлийн 16 жилд 52%-иар буурсан байна. *Equus hemionus*-ийн нэг үе нь долоон жил байдаг, эмэгчний үржлийн нас нь 5 нас, гурван жил тутамд нэг амьд унага төрүүлдэг бөгөөд төрөлтийн хүйсийн харьцаа 50/50, эхний жилийн амьд байх магадлалын хувь 50%, хоёр дахь жилийнх ойролцоогоор 50%, азаргын зөвхөн тал орчим нь үржилд ордог гэж үзвэл популяцийн ойролцоогоор гуравны нэг нь “нас бие гүйцсэн” байна. Одоогийн тооцсон нас бие гүйцсэн тоо толгой нь 8358 байна. Хууль бус агнуурын улмаас цаашид дэлхий даяарх тоо толгой нь >50% буурна гэж тооцоологдсон.
Хар сүүлт зээр (*Gazella subgutturosa*)	Эмзэг	Эмзэг	Гол аюул нь (махных нь төлөө, мөн бага хэмжээнд ангийн зорилгоор) хууль бусаар агнах, (эдийн засгийн хөгжил, газар тариаланд хувиргах, бэлчээрлэх малын тоо өссөн) амьдрах орчиноо алдах явдал юм. Төв Азид энэхүү зүйл нь хатуу ширүүн өвлийн цаг агаарын нөлөөнд өртөмтгий байдаг. Арабын буланд заримыг нь хувийн цуглуулгын зорилгоор амьдаар нь барьдаг. Монголд махыг нь ашиглах болон спортын зорилгоор	Афганистан, Азербайжан, Бахрейн, Хятад, Иран, Ирак, Йордан, Казакстан, Киргизстан, Монгол, Оман, Пакистан, Саудын Араб, Арабын Серийн БНУ, Тажикистан, Турк, Туркменстан, Арабын Нэгдсэн Эмират улс, Узбекстан, Йэмен. Тоо толгой нь 2001 онд 120,000-140,000 байсан, тэр

Зүйлүүд	ОУБХХ-ны ангилал[15]	Үндэсний ангилал	Тохиолдож буй аюул	Дэлхийн хэмжээн дэх популяцийн тоо толгой, тархац нутаг
			хууль бусаар агнах явдал гол аюулыг дагуулж байна. Хэдийгээр энэ зүйл маш бага усыг шаарддаг ч, малын тоо толгой өсч байгаа нь баянбүрд уст цэг ашиглах өрсөлдөөнийг бий болгож, бэлчээрийг доройтуулах магадлалтай (цаашид нэмэлт судалгаа баримт шаардлагатай). Байгалийн нөөц баялгийг олборлох явдал (уул уурхай) ихэссэн нь одоогоор амьдрах орчны алдагдалд төдий л хүргэхгүй байгаа боловч, үүнтэй холбоотой хүний үйл ажиллагаа зарим газруудад аюулыг дагуулж байна.	цагаас хойш тархац нутгийнхаа хэмжээнд популяцийн тоо толгой маш ихээр буурсан. Монгол дахь популяци нь энэхүү зүйлийн үлдэж байгаа хамгийн том популяцийг (1990-ээд оны эхээр 60000 гэж тооцсон) бүрдүүлдэг гэж үздэг бөгөөд дэлхийд байгаа популяцийн 40-50%-ийг эзэлж байна гэж тооцоолсон. Гэвч сүүлийн 2-3 жилүүдэд агнуурын улмаас энэ популяци маш ихээр хорогдож, тоо толгойн бууралт үргэлжилсээр байна.
Цагаан зээр (*Procapra gutturosa*)	Анхааралд өртөхөөргүй	Устаж болзошгүй	(Хуулийн дагуу агнахын зэрэгцээ) хууль бусаар агнах нь өсөн нэмэгдэж байгаа аюул болж байна. Энэхүү зүйлийн мах, арьсыг нь ашиглахын тулд агнадаг. Монгол улсад өмнө нь хэрэгжиж байсан чанга хатуу хяналт сүүлийн арван жилийн хугацаанд суларсан бөгөөд албан ёсны ан агнуураас гадна хэд арван мянгаар нь хууль бусаар агнасан байна. Улаанбаатар-Бээжингийн чиглэлийн төмөр замд давхар тор татсан нь дорнод Монголд байдаг жижиг популяцуудийг үндсэн популяцаас нь шууд тусгаарласан. Үе үе дэгддэг өвчин, хатуу ширүүн өвөл зэрэг нь зарим үед их хэмжээгээр хорогдоход хүргэж байна.	Популяцийн тоо толгойн тооцоо сүүлийн 10 жилийн хугацаанд 400,000-аас 2,700,000-ийн хооронд хэлбэлзэж байна. Энэ зүйлийн популяцийн тоо толгой нь өвчин эмгэг болон хатуу ширүүн өвлийн нөхцлийн улмаас хэлбэлзэж байдаг. Дорнод Монгол, Оросын зэргэлдээх газар нутгууд болон зүүн хойд Хятадын ойролцоох нутгуудаар тохиолддог. Төв болон баруун Монголын нутгуудаар жижиг популяцууд тохиолдсоор байна. Баруун- төв Монголд Завхан аймгийн Хомын талын нутагт шилжин нутагшсан хэсэг популяци байдаг.
Аргаль (*Ovis ammon*)	Ховордож болзошгүй	Устаж болзошгүй	Монгол орны аргальд тулгарч байгаа гол аюул нь амьжиргааны хэрэгцээнд (мах) зориулж агнах, мөн сүүлийн үед эврийг нь авахын төлөө агнах явдал ихэсч байна. Ялангуяа Хятадын уламжлалт анагаах ухаанд эврийг нь э улам өргөн ашиглах болсон. Бас нэг чухал нөлөө нь нутгийн малчдын мал аргалийн бэлчээрлэх нутаг бэлчээрт бэлчээрлэж орчныг булаах, нохой нь аргалыг хөөж, бүр барих зэрэг явдал байдаг. Арай жижиг, орон нутгийн шинжтэй аюулын тоонд ан агнуурын зорилгоор тогтвортой бус ан хийх, ашигт малтмалыг олборлох явдал (ө.х, уул уурхай) ихэссэн зэрэг орно. Уурхайчид амьжиргаандаа зориулан агнах нь уурхайн бодит үйл ажиллагаанаасаа илүү их аюулыг	Энэхүү зүйл нь зүүн хойд Афганистан, Хятад, Энэтхэгийн хойд талаар, зүүн Казакстан, зүүн Киргизстан, Монгол, Непалийн хойд хэсэг, Пакистаны хамгийн хойд хэсэг, Орос, Узбекстаны зүүн хэсэг, Тажикистаны өмнөд хэсэгт одоогоор нутаглаж байна. Аргаль нь Монгол орны өргөн уудам газар нутагт тархсан байдаг боловч зайтай зайтай нутагладаг. Дээр үед аргаль нь Монгол орны дорнод Монголоос бусад бүхий л нутгаар даваа гүвээ, уул нурууд, хад чулуурхаг газар, хавцал, тэгш өндөрлөг газруудад нутаглаж байсан байна. Аргалийн тархац нутаг нь Монголын зүүн хэсэг рүү нилээд өргөжсөн боловч, үүний эсрэгээр Монголын баруун хэсэгт тархац нутаг нь хэсэгчлэн хуваагдаж

Зүйлүүд	ОУБХХ-ны ангилал[15]	Үндэсний ангилал	Тохиолдож буй аюул	Дэлхийн хэмжээн дэх популяцийн тоо толгой, тархац нутаг
			дагуулж байгаа боловч, уурхайн тоо ихсэхийн хэрээр энэ байдал түргэн өөрчлөгдөж болохоор байна. Энэхүү дурьдсан аюулууд нь Монгол оронд тухайн зүйл амьтны тархац нутгийн ихэнхи хэсэгт хуулийг сул хэрэгжүүлдэг буюу хэрэгжүүлдэггүй явдлаас үүдэн ноцтой хэвээр байна. Одоогоор агнуурын спортоос орсон орлогын тун бага мөнгийг Монголд амьтныг хамгаалах үйл ажиллагаанд зориулж байна.	жижгэрэх болсон. Баруун Монголд урьд нь ихээхэн бүс нутгийг хамран эзэлж байсан боловч одоо энэ зүйл бараг алга болсон. Одоогийн тархалт нь Алтайн нурууны хэсгүүд, Алтайн цаад, Говь-Алтай, Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уул нурууд, мөн говь цөлийн алслагдсан газрууд байна.Тухайлбал, тусгаарлагдмал популяцууд нь Монгол Алтайн нуруу, Говь-Алтайн нуруу, голчлон баруун болон зүүн Хангайн нуруу, Хөвсгөлийн уулан дахь Арсайн голын эх ундаргын орчимд мөн Хэнтийн уулсын өмнөд захад байна. Бусад популяцууд Зүүнгарын Их говь, Алтайн өвөр говь, Алашаны говь, дунд говь, дорно говьд хэсэг хэсгээр үлдсэн байдаг. Аргалын тоо толгой нь төв болон баруун Монголд буурч байгаа боловч дорнод Монгол популяцийн тархац нь тэлж байгаа нь ажиглагдаж байна. Монголын өмнөд хэсэгт аргалын тоо толгой харьцангуй тогтвортой байх төлөвтэй байна. Монгол оронд хэдхэн мянган Алтайн аргаль (*O. a. ammon*) үлдсэн хэдий ч, нилээн хэдэн мянган говийн аргаль (маргаантай байгаа *O. a. darwini*) нутгийн өмнө болон зүүн биед улам бүр хүрээгээ тэлэн нутаглаж байна.

Эх сурвалж: Кларк ба бусад (2006), ОУБХХ-ны Ховордсон амьтдын Улаан Данс. 2011 оны хэвлэл

Зураг 7.23: Дэд Бүтцийн Зурвасын зүүн талын ГБДЦГ-ын Б хэсэг дэхь хулан, 2011 оны 5-р сар

Зураг 7.24: Дэд Бүтцийн Зурвасын баруун талд Дайчин Загийн орчим дахь хулан, 2011 оны 5-р сар

7.4.8 Амьтны хөгжил хувьсал

Хэдийгээр Уурхайн лицензит талбайн дотор амьтны аймгийн олон төрөл зүйлүүд бүртгэгдсэн хэдий ч, олон төрөл зүйлүүдийн нягтшил бага, том төрөл зүйлүүдийн тархац нутаг өргөн уудам байна. Ялангуяа ус, сайн бэлчээр хайж өргөн уудам зайг туулан бэлчдэг төрөл зүйлүүдийн хувьд энэ нь бодитой юм. Суурь судалгаа болон нэмэлт хяналт шинжилгээний хөтөлбөрийн үр дүн нь өнөөгийн нөхцөл байдлыг ерөнхийд нь маш сайн төлөөлөн харуулж байгаа гэж үзэж байгаа ч, барилгын ажил явагдах талбай болон тавигдах зам дагуу газрасс амьтад дайжих буюу Уурхайн лицензит талбайг хашаажуулсаны улмаас нүүдэллэх чиглэл нь өөрчлөгдөх нь тодорхой юм. Уурхайн лицензит талбайг хашаажуулсанаар мал нэвтрэн орж чадахгүй болсон тул өвс тэжээлийн ургац сайтай тэрхүү хэсэгт хар сүүлт зээр нэвтрэхийг оролдож болзошгүй хэмээх таамаг байна.

Бүтээн байгуулалт явагдаж буй уурхайн лицензит талбайд Оюу Толгой төсөлтөй холбоотойгоор хүний үйл ажиллагаа нэмэгдсэнээр суурин газрыг дагаж амьдардаг төрөл зүйлүүд ихсэх, мөн хүний үйл ажиллагаанд эмзэг төрөл зүйлүүд алга болох зэргээр амьтны аймагт өөрчлөлтүүд орж байна.

Жишээ нь гэрийн бор шувуу (*Passer domesticus*) болон хэрээг (*Corvus corax*) хот суурин газрын төрөл зүйлүүд гэж үздэг ба Оюу Толгойн бүсэд тэдгээрийн тоо толгой нэмэгдсэн байна. Сохор элээ (*Milvus migrans*), нөмрөг тас (*Aegypius monachus*), дэлдэн зараа (*Hemiechinus auritus*), шар үнэг (*Vulpes vulpes*), хярс үнэг (*Vulpes corsac*) зэрэг сэг зэмээр хооллодог амьтдын тоо мөн нэмэгдэх хандлагатай болж байна.

УЛТ-д янз бүрийн усны цөөрмүүдийг байгуулсан нь, тухайлбал ахуйн хаягдал усны цөөрмийг байгуулсан нь ердийн үед бол тус газраар дайран өнгөрдөг олон зүйлийн эргийн болон усны шувуудыг татах болсон. Эдгээр цөөрмүүдэд тухайн бүс нутагт хамаарах олон шинэ төрөл зүйлүүдийг бүртгэсэн байна.

7.5 ЧУХАЛ АМЬДРАХ ОРЧНЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Энэхүү хэсэг нь Оюу Толгой төсөлд хамаарах Чухал амьдрах орчны хэмжээ хүрээ, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох болно. Энэхүү тойм дүгнэлт нь техникийн үндсэн мэдээлэл болон үүнээс үүдэх гол гол дүгнэлтүүдийг авч үзэх болно. Биологийн төрөл зүйлийн Зөвлөх газар болон “Фауна энд Флора Интернэшнл”-ээс санхүүгийн болон техникийн зөвлөхүүд, шинжээчид, төслийн оролцогчдод зориулан гаргасан Техникийн иж бүрэн илтгэл (энэхүү БОННБҮ-ний 3-р хавсралт) нь ОУСК-ын Гүйцэтгэлийн 6-р стандартын (ГС6-2006 оны) 9-р Бүлэг болон ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн 6-р Шаардлагын (ГШ6) 13-р Бүлэгийн шаардлагууд, ОУСК-ын 2009 оны Оюу Толгойн төслийн Чухал амьдрах орчны талаарх удирдамжийн тайлбарын талраахи дэлгэрэнгүйг тусгасан байдаг. Тус хэсэгт мөн Энэхүү удирдамжийг баримтлан хэрэгжүүлэх чиглэлийн зохих аргуудыг боловсруулсан ба судалгаа хийсэн судалгааны орон зайн нэгжүүдийн газрын зургуудыг үнэлсэн, ГС6-ийн 9-р Бүлэг болон ГШ6-ийн 13-р Бүлэгийн шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулан бүх гарсан үр дүнгүүд, төслийн хувьд эдгээр үр дүнгүүд ямар утга илэрхийлэх тухай, цаашид шаардагдах алхамууд зэргийг авч үзсэн болно. Энэхүү баримт бичигт Оюу Толгой төслийн дэд бүтцийн бүх элементүүдийн Биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөлөл ба Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг мөн Нөхөн хамгааллын стратеги, Цэвэр Эерэг Нөлөөллийн урьдчилсан таамаг (Хүснэгт 1-ийг үз) зэргийг багтаасан. Энэ нэмэлт баримт бичгүүд нь төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөллүүд болон боломжит бууруулах арга хэмжээнүүдийг багтаасан ГС6-ийн 10-р Бүлэг болон ГШ6-ийн 14-р Бүлэгийг дагаж мөрдөх явдлыг хангах мэдээллүүдийг агуулж байгаа болно.

7.5.1 Чухал Амьдрах Орчин гэж юуг хэлэх вэ?

Чухал амьдрах орчин гэдэг нь Биологийн төрөл зүйлийн хувьд өндөр ач холбогдол бүхий бүс нутгуудыг тодорхойлох талаар Олон улсын Санхүүгийн Корпорацийн Гүйцэтгэлийн 6-р стандарт болон Европын Сэргээн босголт, Хөгжлийн Банкны Гүйцэтгэлийн 6-р Шаардлага зэрэгт тодорхойлогдсон ухагдахуун юм. Гол амьдрах орчныг тодорхойлох явдал нь бүтээн байгуулалтын үйл ажиллагаа нь онцгой эмзэг тусах мөн цаашид бүтээн байгуулалтын ажиллагаандаа онцгой анхаарал шаардсан газар нутгуудыг тодорхойлох явдал байдаг. Энэхүү Чухал амьдрах орчны үнэлгээ нь “*Чухал амьдрах орчин гэдэг нь ГС6-ийн 9-р Бүлэгд тодорхойлсон долоон шалгуурын доод тал нь нэгийг нь хангасан биологийн төрөл зүйлийн хувьд өндөр ач холбогдол бүхий газар нутаг юм*” гэж тодорхойлсон чухал амьдрах орчны тухай ОУСК-ын Оюу Толгой төслийн удирдамжийн тайлбарыг баримталсан. Эдгээр долоон шалгуурууд нь:

1. Устаж байгаа болон устаж болзошгүй төрөл зүйлүүд (дэлгэрэнгүйг Хүснэгт 7.5 –с үзнэ үү)
2. Орон нутгийн шинжтэй болон хязгаарлагдмал нутаг дэвсгэрт тархацтай төрөл зүйлүүд (дэлгэрэнгүйг Хүснэгт 7.5 –с үзнэ үү)
3. Нүүдлийн болон бөөнөөрөө амьдардаг төрөл зүйлүүд
4. Төрөл зүйлүүдийн онцгой хуран цугларалтууд
5. Хувьслын гол үйл явц
6. Экосистемийн гол үйлчилгээнүүд
7. Орон нутгийн ард иргэдэд нийгэм, эдийн засаг, соёлын чухал ач холбогдол бүхий биологийн төрөл зүйлүүд

Хэрэв эдгээр долоон шалгууруудын аль нэгэнд нь тохирч байвал чухал амьдрах орчин мөн гэж үздэг. Тоо шалгуур үзүүлэлтүүд нь 1-3-р (зүйлүүдийн) Шалгууруудын хувьд, чанарын шалгуур үзүүлэлтүүд 4-7-р Шалгууруудын (амьдрах орчин, үүрэг, үйл явц болон экосистемийн үйлчилгээ) хувьд зориулагдан гарсан ч, тоон үнэлгээ болон мэргэжилтнүүд, оролцогчдын дүгнэлтээс давхар хамааралтай байна. Чухал амьдрах орчны тухай ойлголтоос урган гарч ирж байгаа гол асуудлуудад доорх зүйлс багтана:

- Төслийг хүрээлэн буй бүс нутгийн орчин нь төслийн талбайн экологийн нөхцөл байдлыг илэрхийлэхүйц сайн судлагдсан байх ёстой: төслийн талбай ба хүрээлэн буй орчны хооронд ямар харилцан хамаарал байна вэ?
- Анализ хийх орон зайн судалгааны хүлээн зөвшөөрөгдсөн нэгж нь чухал амьдрах орчны хил хязгаарыг тогтоож өгдөг. Анализ судалгаа хийхнэгжийн хил хязгаарыг төслийн талбайд оршин байгаа экологийн хувьд чухал (усны хагалбар) болон менежментийн (жишээлбэл, тусгай хамгаалалттай газар нутаг) нэгжээр тодорхойлдог. Чухал амьдрах орчны жижиг полигонуудыг төслийн талбайд болон талбайн орчимд тодорхойлох боломжгүй болсон. Хэдийгээр үнэ цэнэ бүхий биологийн төрөл зүйлүүд нь төлөвлөж буй төсөл хэрэгжих талбайн гадна талд байгаа боловч төслийг “Чухал амьдрах орчныдотор” байна гэж үзэж болно. Иймд чухал амьдрах орчин нь өмнө нь ойлгож байснаас илүү өргөн ойлголт болж байна.
- Чухал амьдрах орчинд бүтээн байгуулалтын ажлыг “ огт хийж болохгүй” гэж үзэхээ болисон. ГС6-ийн Бүлэг 10-т (2006 оны) байгаа Чухал амьдрах орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хувилбаруудыг тодорхойлоод байна. Жишээлбэл, а) “тухайн зүйлүүдийн популяцийн тоо толгойг бууруулахгүй байх” гэдэг нь тухайн зүйлийн дэлхийн хэмжээний болон улсын хэмжээний тоо толгойд хамаарч байгаа юм мөн б) зарим нөхцөлд биологийн төрөл зүйлүүдийн нөхөн хамгаалах арга хэмжээг авахыг зөвшөөрдөг.
- Чухал амьдрах орчны зэрэглэлүүд: Одоо үед чухал амьдрах орчныг ач холбогдлоор нь зэрэглэх болсон – Зарим чухал амьдрах орчин нь бусдаасаа илүү чухал байдаг. Эдгээр зэрэглэлүүдээс хамгийн чухал нь 9-р Бүлэгийн 1-3-р Шалгуурт тодорхойлсон Чухал амьдрах орчны хоёр зэрэглэл юм. Чухал амьдрах орчны 1-р зэрэглэлд багтах орчин нь өндөр ач холбогдолтой бөгөөд нөхөн хамгаалллын арга хэмжээ авах боломж бага. Чухал амьдрах орчны 2-р зэрэглэлд багтах орчин нь харьцангуй бага ач холбогдолтой бөгөөд нөхөн хамгаалах арга хэмжээ авах илүү боломжтой байдаг.
- ГС6-ын 9-р Бүлэгийн (2006 оны) зүйлүүдийн тухай 1-3-р Шалгуурт тоон үзүүлэлтийн шалгуур байдаг бөгөөд энэ нь Чухал амьдрах орчинд тухайн газар хамрагдах эсэх мөн аль зэрэглэлийнх гэдгийг тодорхойлж өгдөг. Шалгуур 4-7-ийн хувьд чанарын үзүүлэлтүүдтэй байдаг. Шалгуур 1-2-ийн хувьд эдгээр шалгуур үзүүлэлтүүдийг Хүснэгт 7-5-д нэгтгэн үзүүлсэн болно.

Хүснэгт 7.5: Устаж байгаа/ орон нутгийн шинж чанартай/хязгаарлагдмал тархацтай төрөл зүйлүүдийн чухал амьдрах орчин, 1 ба 2 дугаар зэрэглэлийг тодорхойлох тоон шалгуур / ГС6-ийн 9 дүгээр Бүлэгийн 1 ба 2-р шалгуурууд (2006 оны)/ ТВС (2010)

Шалгуур	**Зэрэглэл 1**	**Зэрэглэл 2**
1. Устаж байгаа/ устаж болзошгүй	a) Амьдрах орчин нь ОУБХХ-ны Улаан дансанд орсон устаж байгаа болон устаж болзошгүй зүйл /тухайн дэд зүйл мэдэгдэж байгаа тохиолдолд мөн тухайн зүйл амьтан тухайн газарт байнга тохиолддог байх / дэд зүйлийн дэлхийн хэмжээний нийт популяцийн тоо толгойн 10-аас доошгүй хувь нь амьдардаг байх шаардлагатай. Мөн уг амьдрах орчныг тухайн зүйл/дэд зүйлд зориулсан тусгай менежменттэй нэгж гэж үзэж болно. b) Тухайн амьдрах орчинд устаж байгаа ба устаж болзошгүй зүйл/дэд зүйлүүд байнга тохиолддог байх буюу тухайн амьдрах орчин нь тухайн зүйл/дэд зүйлийн хувьд дэлхийн хэмжээнд 10 буюу түүнээс цөөн байдаг менежментийн талбайн нэг байх.	c) ОУБХХ-ны улаан дансад орсон устаж байгаа зүйл/ зүйлийн ганц бодгаль амьтан байнга тохиолддог амьдрах орчин эсвэл ОУБХХ-ны улаан дансанд орсон устаж болзошгүй зүйл/дэд зүйлүүдийн тухайн бүс нутгийн хувьд чухал төвлөрлийг агуулсан амьдрах орчин байх ёстой ба ийм амьдрах орчныг тухайн зүйл/дэд зүйлд зориулсан тусгай менежменттэй нэгж гэж үзэж болох явдал. d) Өргөн уудам тархац нутагтай буюу популяцийн тархац нь тодорхойгүй устаж байгаа ба устаж болзошгүй зүйл/дэд зүйлүүдийн хувьд ач холбогдолтой амьдрах орчин байх бөгөөд ийм амьдрах орчин хэрвээ устаж үгүй болвол тухайн зүйл/дэд зүйлүүдийн урт хугацаанд оршин амьдрах чадварт нь нөлөөлж болзошгүй байх. e) Тухайн амьдрах орчин нь улсын (эсвэл бүсийн) хэмжээнд устаж байгаа болон устаж болзошгүй хэмээн бүртгэгдсэн зүйл/дэд зүйлүүдийн / жишээлбэл тухайн амьдрах орчин нь улсын хэмжээний эсвэл бүс нутгийн 10 буюу түүнээс цөөн тоотой байдаг менежментийн нэгж талбайн нэг байх/ улсын хэмжээний популяцийн нийт тоо толгойн 10-аас доошгүй хувийг агуулж байх шаардлагатай ба ийм амьдрах орчныг бие даасан менежментийн нэгж болгон авч үзэж болох явдал.
2.Орон нутгийн шинж чанартай/хязгаарлагдмал тархацтай	a) Тухайн амьдрах орчин нь эндемик/хязгаарлагдмал тархацтай зүйл/дэд зүйлийн дэлхийн хэмжээний популяцийн нийт тоо толгойн ≥ 95-аас доошгүй хувийг нь агуулсан байх шаардлагатай. Мөн уг амьдрах орчныг тухайн зүйл/дэд зүйлд зориулсан тусгай менежментийн нэгж гэж үзэж болох явдал зэрэг юм.	b) Тухайн амьдрах орчин нь эндемик/хязгаарлагдмал тархацтай зүйл/дэд зүйлийн дэлхийн хэмжээний популяцийн нийт тоо толгойн 1%-ээс их, 95%-аас доош хувийг нь агуулсан байх шаардлагатай. Уг амьдрах орчныг тухайн зүйл/дэд зүйлд зориулсан тусгай менежментийн нэгж гэж үзэж болох явдал. c) Тухайн амьдрах орчин нь эндемик/хязгаарлагдмал тархацтай зүйл/дэд зүйлүүдийг агуулж байдаг байх ба дэлхийн хэмжээний 2-100 тусгай менежментийн талбайн нэг нь байх.

7.5.2 Чухал амьдрах орчныг тодорхойлох аргачлал

Чухал амьдрах орчныг тодорхойлох 3 алхам байдаг. Техникийн тайлангийн аргачлалын хэсэгт үүнийг дэлгэрэнгүй тусгаж өгсөн (Хавсралт С-г үзнэ үү).

- ***Алхам-1:*** Үнэлгээний цар хүрээ, төслийн нөлөөллийн бүс, анализ судалгааны орон зайн нэгжийг тодорхойлох
- ***Алхам 2:*** Биологийн болон нийгмийн хээрийн судалгаа, ном хэвлэл ашиглах, шинжээчдийн зөвлөгөө, дүн шинжилгээг ашиглан биологийн төрөл зүйл болон экосистемийн үйлчлэлүүдийн талаарх мэдээлэл цуглуулж, баталгаажуулах
- ***Алхам 3:*** 9 дүгээр Бүлэгийн шалгуурт нийцэж болох биологийн төрөл зүйлийн бүрэлдэхүүн хэсгийг шалгах, сонгох /төрөл зүйл, амьдрах орчин, экосистемийн үйл явц, үйлчилгээ/, тоон шалгуур үзүүлэлтүүд /Шалгуур 1-3/, эсвэл тохирох шалгуур үзүүлэлтүүдийг /Шалгуур 4-7/ ашиглан аль бүрэлдэхүүн хэсэг нь чухал амьдрах орчны шаардлагыг хангаж буй талаар нарийвчилсан үнэлгээ хийх явдал юм.

7.5.3 Чухал амьдрах орчныг тодорхойлох ажлын үр дүн

- **Орон зайн цар хүрээ ба дүн шижилгээний нэгж**. Оюу Толгой Төслийн Чухал амьдрах орчны Зааварчилгааны дагуу, экологи ба биологийн төрөл зүйлийн бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх нөлөөлөлтэй холбогдуулан хоёр төрлийн анализ судалгааны хэсгийг тодорхойлсон. **Нэгдүгээрт:** Туурайтан[16] амьтны зарим төрөл зүйлийн нүүдлийн шилжилт хөдөлгөөнийг хамрах үүднээс мөн энэ газрыг бүхэлд нь хамарсан хоёрдогч нөлөөлөл үүсч болох магадлал тухайлбал шилжин суурьшигчид олширч, амьдралын боломж бололцоо дээшилсний улмаас /энэ нь машин тэрэг, галт зэвсэг эзэмших явдлыг нэмэгдүүлэх/ амьтдыг агнах нь ихсэх зэрэг шалтгааны улмаас Ханбогд, Манлай, Баян-Овоо сум, Говийн Бага Дархан Цаазат Газрын А ба Б хэсгийг хамарсан бүс нутгийг томоохон хөхтөн амьтны дүн шинжилгээний орон зайн нэгж болгон тодорхойлсон. . Энэхүү дүн шинжилгээний нэгж нь 51,415 км^2 газар нутгийг хамарсан. **Хоёрдугаарт:** Ханбогд, Манлай сумдаас бүрдэх арай жижиг хэмжээний газар нутгийг бусад бүх төрөл зүйл, төрөл зүйлийн дахин давтагдашгүй бүрдэл, хувьслын гол үйл явцууд, экосистемийн гол үйлчилгээнүүд, орон нутгийн иргэдийн хувьд нийгэм, эдийн засаг, соёлын ач холбогдол бүхий биологийн төрөл зүйлүүдийг судлахад зориулсан орон зайн нэгж болгон тодорхойлсон. Энэхүү шинжилгээний орон зайн нэгж нь зөвхөн уурхай, холбогдох дэд бүтцийн гол нөлөөллүүд үүсэх Ханбогд сум төдийгүй, Гүний Хоолойн уст давхарга сунаж орших Манлай сумыг багтаадаг /Уурхайн үйл ажиллагаатай холбоотой гүний ус ашигласнаас хоёрдогч нөлөөлөл үүсч болох юм[17]/. Энэ дүн шинжилгээний нэгж нь 27,375 км^2 талбайг эзэлнэ.
- **Шалгуур 1: Устаж байгаа болон Устаж болзошгүй төрөл зүйлүүд:** Энэхүү дүн шинжилгээний хэсэгт устаж байгаа зүйл бүртгэгдээгүй буюу ирээдүйд бүртгэгдэх төлөвгүй байна. МУ-ын хуульд зааснаар нэн ховор ургамлын жагсаалтанд багтсан 18 зүйлийн ургамал байдаг ба ОУ-ын хэмжээнд устаж болзошгүй 3 зүйлийн амьтан, улсын хэмжээнд устаж болзошгүй 4 зүйлийн амьтан судалгаа үнэлгээний талбайд байдаг буюу байж болзошгүй гэж үзэж байна. Эдгээр зүйлүүдээс нэг зүйл нь (Хулан- *Equus hemionus*) 1-р зэрэглэлийн чухал амьдрах орчны Шалгуур 1-д, бусад 3 зүйл нь / Монгол буурцгана - *Chesniella mongolica*, аргаль- *Ovis ammon* ба Могойч загалай-*Circaetus gallicus*/ 2-р зэрэглэлийн чухал амьдрах орчны Шалгуур 1-д тэнцэж байна. Зүйлийн талаарх нэгдсэн дүгнэлтийг *Хүснэгт* 7.6- д үзүүлэв.
- **Шалгуур 2: хязгаарлагдмал тархацтай буюу орон нутгийн шинж чанартай төрөл зүйл:** Хязгаарлагдмал тархацтай нэг зүйл нь / Козловын хайруулдай - *Prunella koslowi*/ шинжилгээний нэгжид тохиолддог гэж үздэг боловч Шалгуур 2-ийн дагуу Чухал амьдрах орчны шалгуурт тэнцээгүй байна.

[16] Ялангуяа хулан нь дүн шинжилгээний нэгж талбайн хамгийн хойд захаас бусад бүх газар нутагладаг бай энэ зүйл амьтан нь Говийн Бага Дархан Цаазат Газрын хоёр хэсгийг байгуулах үндсэн шалтгаан болсон.

[17] Эдгээр боломжит нөлөөллүүд тохиолдох магадлал бага боловч тохиолдсон үед үр дагавар нь нөлөөллийн талбай дахь бүх биологийн төрөл зүйлүүдийн хувьд ноцтой юм.

- **Шалгуур 3: Нүүдлийн болон бөөнөөрөө амьдрах шинж чанартай төрөл зүйл:** Шинжилгээний нэгж хэсэгт 174 зүйлийн нүүдлийн шувууд, нүүдлийн туурайтан амьтны нэг зүйл, нүүдлийн нэг мэрэгч зүйл , нүүдлийн сарьсан багваахайн хоёр зүйл тохиолддог гэж тэмдэглэгдсэн байна. Сарьсан багваахайн хоёр зүйл болон өөр хоёр зүйлүүд сүрэглэн үүрлэдэг бөгөөд эдгээрийг конгрегатив зүйл гэж үзэж болно. Хар сүүлт зээр (*Gazella subgutturosa*) нь 1%-ийн шалгуур босгыг давсан учир Шалгуур 3-ийн дагуу Чухал амьдрах орчны 2 дугаар зэрэглэлд багтана.
- **Шалгуур 4: Төрөл зүйлүүдийн онцгой хуран цугларалтууд:** Судалгаа шинжилгээний холбогдох нэгж хэсгийн ургамал, амьтны аймгийн бүрдэл нь ойр хавийн бүс нутгийн төрөл зүйлүүдтэй бүрэлдэхүүний хувьд ижил төстэй. Хэдийгээр зарим нэг онцлог шинж чанартай газрууд чухалд тооцогдож байсан ч /томоохон туурайтан амьтны бүлгэмдэл, улирлын шинж чанартай урсац бүхий сайр дагуух хайлаас мод, түр зуурын устай нуур/тойром, шигүү заган төгөлүүд/ тэдгээр нь онцгой бүрдэл гэж тооцогдоход хэтэрхий том газар нутагт байсан. Шалгуур 1-4-ийн дагуу хайлаас/заг модны төгөлүүд нь Чухал амьдрах орчин хэмээн хүлээн зөвшөөрөх шалгуур болж чадахгүй боловч заг мод нь Шалгуур 7-д дурьдсанчлан биомассын түлш ангилалд багтаж байгаа тул Оюу Толгой төсөл нь эдгээр амьдрах орчны талаархи оролцогч талуудын саналыг авч үзсэний үндсэн дээр хайлаас болон заг модны төгөлүүдийг “нэн тэргүүнд хамгаалах шаардлагатай биологийн төрөл зүйлийн бүрэлдэхүүн хэсэг” хэмээн үзсэн. Иймээс эдгээрийг сөрөг нөлөөллийг бууруулах болон нөхөн хамгааллын арга хэмжээний төлөвлөгөөнд авч үзсэн ба Оюу Толгой төсөл нь эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдэд цэвэр эерэг нөлөөлөл үзүүлэхийг зорьж байна (энэ талаар Цэвэр Эерэг Нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд дурьдсан). Үүний эсрэгээр, судалгаа шинжилгээний энэ нэгж хэсэгт боржин чулуу гаршууд тохиолддог бөгөөд эргэн тойрны бүс нутгийн хуурайшлаас хамааран онцгой ургамлын бүлгэмдлийн бүрдэлтэй байдаг. Иймд Шалгуур 4 –ийг дагуу боржин чулуун гаршууд дээр ургасан онцгой ургамлын бүлгэмдэлтэй учраас судалгаа шинжилгээний энэ нэгж хэсгийг Чухал амьдрах орчин гэж үзэж болно.
- **Шалгуур 5: Хувьслийн гол үйл явц:** Судалгаа шинжилгээний холбогдох нэгж хэсэгт энэ шалгуурт тохирох ач холбогдол бүхий хувьслын үйл явц илрээгүй. Энэ нь the Дорнод говийн цөлөрхөг хээр ба Алшаагийн тэгш тал цөлөрхөг бүс гэсэн хоёр эко бүс нутгийн төлөөлөл юм. Иймд энэ судалгаа шинжилгээний энэ нэгж хэсэг нь Шалгуур 5-ийн дагуу Чухал амьдрах орчин гэж тооцогдохгүй.
- **Шалгуур 6: Экосистемийн гол үйл ажиллагаа:** Энэ ангилалд усны зохицуулалт нь Чухал амьдрах орчныг тодорхойлдог. Энэ шалгуур нь экосистемийн үйлчлэлүүдийг зохицуулах, дэмжих зорилготой (Мянганы Экосистемийн Үнэлгээ 2005). Зохицуулалтын үйл ажиллагаа гэдэг нь үер усны хяналт зохицуулалт гэх мэт экосистемийн үйл явцын зохицуулалтын үр дүн юм. Зохицуулалтын нэг үйл ажиллагаа илэрвэл Чухал амьдрах орчны шалгуурыг хангаж байв. Дэмжих үйл ажиллагаа нь экосистемийг дэмжих үндсийг бий болгодог хөрс үүсгэх гэх мэт үйл ажиллагааг багтаана. Үнэлгээгээр Чухал амьдрах орчинд тэнцэхүйц хангалттай ач холбогдол бүхий дэмжих үйлчлэл тогтоогдоогүй байна. Уг судалгаанд агаарын чанарын зохицуулалт, цаг уурын зохицуулалт, усны зохицуулалт, элэгдлийн зохицуулалт, ус цэвэршүүлэлт, хог хаягдлыг цэвэршүүлэх, өвчин эмгэгийн зохицуулалт, хортон шавьжны зохицуулалт, байгалийн гамшгийн зохицуулалт зэрэг экосистемийн бүх үйлчлэлд үнэлгээ хийсэн. Уг шалгуурт зориулсан судалгаа шинжилгээний орон зайн нэгж хэсэг нь Ханбогд, Манлай сумуудын нутгаас бүрдсэн жижгэвтэр нэгж байсан.
- **Шалгуур 7: Орон нутгийн ард иргэдийн хувьд нийгэм, эдийн засаг, соёлын ач холбогдол бүхий биологийн төрөл зүйл.** Энэ ангилалд экосистемийн 3 төрлийн үйлчилгээний шалгуурт (мал сүрэг, биомассын түлш, цэвэр ус) тэнцэж буй Биологийн төрөл зүйлүүд Чухал амьдрах орчныг бий болгож байна. Чухал амьдрах орчны шалгуурт тэнцэхээр ямар нэгэн соёлын үйлчилгээ үнэлэгдээгүй. Энэ шалгуур нь экосистемийн соёлын болон хангамжийн үйлчилгээнд голчлон хамаатай гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Хангамжийн үйлчилгээ гэдэг нь хоол хүнс, цэвэр ус, модон материал, утас болон бусад төрлийн бараа бүтээгдэхүүн зэрэг экосистемээс гаргаж авсан бараа бүтээгдэхүүнүүд юм (Мянганы Экосистемийн Үнэлгээ 2005). Соёлын үйлчилгээ гэдэг нь оюун санаагаа баяжуулах, оюуны хөгжил, шашны ёс заншил, амралт цэнгэл гэх мэт материаллаг бус ач холбогдол юм (Мянганы Экосистемийн Үнэлгээ 2005). Уг шалгуурт зориулсан судалгаа шинжилгээний орон зайн нэгж хэсэг нь Ханбогд, Манлай сумуудын нутгаас бүрдсэн жижгэвтэр нэгж байсан.

Зураг 7.25: (TBC & FFI 2011 –н 2а ба 2б зургийг ашиглав)Том хөхтөн амьтан /а/ болон бусад бүх төрөл зүйл /б/, төрөл зүйлүүдийн өвөрмөц бүрдэл, хувьслын гол үйл явц, экосистемийн гол үйлчлэлүүд, орон нутгийн ард иргэдийн хувьд нийгэм, эдийн засаг, соёлын ач холбогдол бүхий биологийн төрөл зүйлд зориулсан судалгааны орон зайн нэгж

Бүлэг 9-ийн Чухал амьдрах орчны үнэлгээнд ашиглагдсан судалгааны орон зайн нэгж хэсгийн хил хязгааруудыг улаанаар тэмдэглэв.

(a)



(b)



Хүснэгт 7.6: Шалгуур 1, 2 ба 3-т тохирох төрөл зүйл ба Бүлэг 9-тэй харьцуулсан харьцуулалт (Чухал амьдрах орчныг илэрхийлэгч төрөл зүйлүүдийг тод хараар тэмдэглэв)

Тэмдэглэл: Шалгуур 1-ийн дагуу 4 төрөл зүйл нь устаж болзошгүй төрөл зүйлд хамаарна. Шалгуур 2-т тохирох хязгаарлагдмал тархацтай, эндемик төрөл зүйлийн амьтан бүртгэгдээгүй байна. Шалгуур 3-т тохирох Нүүдлийн болон конгрегатив төрөл зүйлийн 1 зүйл тохиолдсон байна. Эндээс 1 төрөл зүйл Чухал амьдрах орчны 1 дүгээр зэрэглэл, 4 төрөл зүйл Чухал амьдрах орчныг 2-р зэрэглэлийг илэрхийлдэг байна.

No.	Зүйл	Нийтлэг нэр [18]	ШАЛГУУР 1 Устаж байгаа ба Устаж болзошгүй төрөл зүйл	ШАЛГУУР 2 Хязгаарлагдмал тархацтай ба орон нутгийн төрөл зүйл	ШАЛГУУР 3 Нүүдлийн ба бөөнөөрөө амьдрах төрөл зүйл	Зэрэглэл 1 Чухал амьдрах орчин	Зэрэглэл 2 Чухал амьдрах орчин	Шалтгаан (Чухал амьдрах орчныг илэрхийлэгч төрөл зүйлийн хувьд тухайн судалгааны талбайн ач холбогдол)
	УРГАМАЛ							
1	*Cistanche deserticola*	Цагаан гоёо	Улсын хэмжээнд устаж болзошгүй	-	-	-	-	Шалгуур 1-ийн шаардлагыг хангаагүй
2	*Iljinia regelii*	Регелийн Будраа	Улсын хэмжээнд устаж болзошгүй	-	-	-	-	Шалгуур 1-ийн шаардлагыг хангаагүй
3	***Chesneyal Chesniella mongolica***	**Монгол буурцгана**	**Улсын хэмжээнд устаж болзошгүй**	**-**	**-**	**-**	**Тийм**	**Шалгуур 1. Улаан дансанд устаж болзошгүй хэмээн тэмдэглэгдсэн улсын хэмжээнд чухал зүйлийн төвлөрөл /судалгаа хийгдэж буй нэгж талбайд тухайн зүйл амьтны улсын хэмжээн дэх популяцийн нийт тоо толгойн >10% /**
4	*Limonium aureum*	Алтан бэрмэг	Улсын хэмжээнд	-	-	-	-	Шалгуур 1-ийн шаардлагыг хангаагүй

[18] Ургамлын түгээмэл нэрийг Байгалийн ургамлын тухай Монгол улсын хуулиас авсан бөгөөд өөр газарт ховорхон хэрэглэгддэг (эдгээр зүйлийн ихэнхи нь шинжлэх ухааны нэрээрээ ихэвчлэн нэрлэгддэг)

No.	Зүйл	Нийтлэг нэр [18]	ШАЛГУУР 1 Устаж байгаа ба Устаж болзошгүй төрөл зүйл	ШАЛГУУР 2 Хязгаарлагд мал тархацтай ба орон нутгийн төрөл зүйл	ШАЛГУУР 3 Нүүдлийн ба бөөнөөрөө амьдрах төрөл зүйл	Зэрэгл эл 1 Чухал амьдр ах орчин	Зэрэгл эл 2 Чухал амьдр ах орчин	Шалтгаан (Чухал амьдрах орчныг илэрхийлэгч төрөл зүйлийн хувьд тухайн судалгааны талбайн ач холбогдол)
			устаж болзошгүй					
5	*Arnebia guttata*	Толбот бэрээмэг	Улсын хэмжээнд устаж болзошгүй	-	-	-	-	Шалгуур 1-ийн шаардлагыг хангаагүй
6	*Asterothamnus centrali-asiaticus*	Төв Азийн лавай	Улсын хэмжээнд устаж болзошгүй	-	-	-	-	Шалгуур 1-ийн шаардлагыг хангаагүй
7	*Gymnocarpus przewalskii*	Пржевальскийн нүцгэнүүр	Улсын хэмжээнд устаж болзошгүй	-	-	-	-	Шалгуур 1-ийн шаардлагыг хангаагүй
8	*Oxytropis grubovii*[19]	Грубовын ортууз	Улсын хэмжээнд устаж болзошгүй	-	-	-	-	Шалгуур 1-ийн шаардлагыг хангаагүй
9	*Brachanthemum gobicum*	Говийн тост	Улсын хэмжээнд устаж болзошгүй	-	-	-	-	Шалгуур 1-ийн шаардлагыг хангаагүй
10	*Incarvillea potaninii*	Потанины улаантулам	Улсын хэмжээнд устаж болзошгүй	-	-	-	-	Шалгуур 1-ийн шаардлагыг хангаагүй
11	*Caragana gobica*	Говийн харгана	Улсын	-	-	-	-	Шалгуур 1-ийн шаардлагыг хангаагүй

[19] Бусад хэвлэлүүдэд Chesneya macrantha буюу Chesneya grubovii хэмээн тэмдэглэгдсэн.

No.	Зүйл	Нийтлэг нэр [18]	ШАЛГУУР 1 Устаж байгаа ба Устаж болзошгүй төрөл зүйл	ШАЛГУУР 2 Хязгаарлагд мал тархацтай ба орон нутгийн төрөл зүйл	ШАЛГУУР 3 Нүүдлийн ба бөөнөөрөө амьдрах төрөл зүйл	Зэрэгл эл 1 Чухал амьдр ах орчин	Зэрэгл эл 2 Чухал амьдр ах орчин	Шалтгаан (Чухал амьдрах орчныг илэрхийлэгч төрөл зүйлийн хувьд тухайн судалгааны талбайн ач холбогдол)
			хэмжээнд устаж болзошгүй					
12	*Caragana brachypoda*	Хойрог харгана	Улсын хэмжээнд устаж болзошгүй	-	-	-	-	Шалгуур 1-ийн шаардлагыг хангаагүй
13	*Olgaea leucophylla*	Цагаан навчит хасзул	Улсын хэмжээнд устаж болзошгүй	-	-	-	-	Шалгуур 1-ийн шаардлагыг хангаагүй
14	*Potaninia mongolica*	Хулан хойрго	Улсын хэмжээнд устаж болзошгүй	-	-	-	-	Шалгуур 1-ийн шаардлагыг хангаагүй
15	*Zygophyllum potaninii*	Потанины хотир	Улсын хэмжээнд устаж болзошгүй	-	-	-	-	Шалгуур 1-ийн шаардлагыг хангаагүй
16	*Jurinea mongolica*	*Монгол чоногоно*	Улсын хэмжээнд устаж болзошгүй	-	-	-	-	Шалгуур 1-ийн шаардлагыг хангаагүй
17	*Tugarinovia mongolica*	Монгол шар далан	Улсын хэмжээнд устаж болзошгүй	-	-	-	-	Шалгуур 1-ийн шаардлагыг хангаагүй
18	*Artemisia xanthochroa*	Алтаншар шарилж	Улсын хэмжээнд устаж	-	-	-	-	Шалгуур 1-ийн шаардлагыг хангаагүй

No.	Зүйл	Нийтлэг нэр [18]	ШАЛГУУР 1 Устаж байгаа ба Устаж болзошгүй төрөл зүйл	ШАЛГУУР 2 Хязгаарлагд мал тархацтай ба орон нутгийн төрөл зүйл	ШАЛГУУР 3 Нүүдлийн ба бөөнөөрөө амьдрах төрөл зүйл	Зэрэгл эл 1 Чухал амьдр ах орчин	Зэрэгл эл 2 Чухал амьдр ах орчин	Шалтгаан (Чухал амьдрах орчныг илэрхийлэгч төрөл зүйлийн хувьд тухайн судалгааны талбайн ач холбогдол)
			болзошгүй					
	ХӨХТӨН АМЬТАН							
19	*Panthera uncia*	Ирвэс	Устаж болзошгүй	-	-	-	-	Шалгуур 1-ийн шаардлагыг хангаагүй
20	***Equus hemionus***	**Хулан**	**Устаж болзошгүй**	**-**	-	**Тийм**	**-**	**Шалгуур 1. ОУБХХ-ны Улаан дансанд устаж болзошгүй ангилалд багтсан дэлхийн хэмжээнд чухал зүйлийн төвлөрөл (тухайн судалгааны талбайд дэлхийн нийт популяцийн >10 %)**
21	***Ovis ammon***	**Аргаль**	**Улсын хэмжээнд устаж болзошгүй**	**-**	-	**-**	**Тийм**	**Шалгуур 1. ОУБХХ-ны Улаан дансанд устаж болзошгүй ангилалд багтсан дэлхийн хэмжээнд чухал зүйлийн төвлөрөл (тухайн судалгааны талбайд дэлхийн нийт популяцийн >10 %)**
22	***Gazella subgutturosa***	**Хар сүүлт зээр**	**-**	**-**	**нүүдлийн**	**-**	**Тийм**	**Шалгуур 3: дэлхийн хэмжээнд чухал нүүдлийн зүйлүүдийн төвлөрөл (тухайн судалгааны талбайд дэлхийн нийт популяцийн >1%)**
23	*Procapra gutturosa*	Цагаан зээр	Улсын хэмжээнд устаж болзошгүй	-	-	-	-	Шалгуур 1-ийн шаардлагыг хангаагүй
	ШУВУУД							
24	***Circaetus gallicus***	**Могойч загалай**	**Улсын хэмжээнд устаж болзошгүй**	**-**	**нүүдлийн**	**-**	**Тийм**	**Шалгуур 1. Шалгуур 1. ОУБХХ-ны Улаан дансанд устаж болзошгүй ангилалд багтсан дэлхийн хэмжээнд чухал зүйлийн төвлөрөл (тухайн судалгааны талбайд дэлхийн нийт популяцийн >10 %)**

No.	Зүйл	Нийтлэг нэр [18]	ШАЛГУУР 1 Устаж байгаа ба Устаж болзошгүй төрөл зүйл	ШАЛГУУР 2 Хязгаарлагд мал тархацтай ба орон нутгийн төрөл зүйл	ШАЛГУУР 3 Нүүдлийн ба бөөнөөрөө амьдрах төрөл зүйл	Зэрэгл эл 1 Чухал амьдр ах орчин	Зэрэгл эл 2 Чухал амьдр ах орчин	Шалтгаан (Чухал амьдрах орчныг илэрхийлэгч төрөл зүйлийн хувьд тухайн судалгааны талбайн ач холбогдол)
								Шалгуур 3-ийн шаардлагыг хангаагүй
25	*Neophron percnopterus*	*Дэлт ёлон*	Устаж болзошгүй	-	-	-	-	Шалгуур 1-ийн шаардлагыг хангаагүй
26	*Larus relictus*	Реликт цахлай	Улсын хэмжээнд устаж болзошгүй	-	нүүдлийн	-	-	Шалгуур 1 ба 3-ын шаардлагыг хангаагүй
27	*Prunella koslowi*	Козловын хайруулдай	-	Хязгаарлагдмал тархацтай	нүүдлийн	-	-	Шалгуур 2 ба 3-ын шаардлагыг хангаагүй
	БУСАД НҮҮДЛИЙН БОЛОН КОНГРЕГАТИВ ЗҮЙЛҮҮД							
	3 нүүдлийн хөхтөн амьтан, 2 бөөнөөрөө амьдардаг хөхтөн амьтан /сарьсан багваахай/, 171 төрөл зүйлийн нүүдлийн шувууд		-	-	нүүдлийн	-	-	Шалгуур 3-ын шаардлагыг хангаагүй
Шалгуур тус бүртэй харьцуулан үнэлсэн зүйлийн нийт тоо, Зэрэглэл бүрт торхирч буй зүйлийн тоо.			**25**	**1**	**180**	**1**	**4**	**Зэрэглэл 1-т хамаарах нэг төрөл зүйл тохиолдсон.** **Зэрэглэл 2-т хамаарах 4 төрөл зүйл тохиолдсон.**

7.5.4 Чухал амьдрах орчны тодорхойлоход өгөх дүгнэлт

Олон улсын Санхүүгийн Корпорацийн Гүйцэтгэлийн стандарт 6-ийн, 2006 оны хувилбар, (Биологийн төрөл зүйлийн хамгаалал ба Тогтвортой Байгалийн Нөөцийн Менежмент) Бүлэг 9-т заасан шалгуур, ОУСК болон Оюу Толгой Төслийн Чухал амьдрах орчны тухай удирдамж тэмдэглэл, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны Гүйцэтгэлийн шаардлага 6-н 13 дахь Бүлэгт заасныг баримтлан авч үзвэл, энэ тайланд дурьдсан Оюу Толгойн судалгаа шинжилгээний нэгж хэсгүүдийн аль аль нь Чухал амьдрах орчинд хамаарна.

Судалгаа шинжилгээний томоохон нэгж хэсэг (том хөхтөн амьтны судалгаа шинжилгээнд зориулсан орон зайг тодорхойлсон) - Ханбогд, Манлай, Баян-Овоо сумд, Говийн Бага Дархан Цаазат газрын А ба Б хэсгийг хамран нийт 51,415 км^2 нутаг дэвсгэр – ГС6-ийн (2006 оны) Бүлэг 9-ийн шалгуур 1 ба 3-ийн дагуу Чухал амьдрах орчин гэж тодорхойлдог. Чухал амьдрах орчны хил хязгаар нь судалгаа шинжилгээний энэ нэгж хэсгийн хил хязгаар болох ба Ханбогд, Баян-Овоо, Манлай сумд, Говийн Бага Дархан Цаазат газрын А ба Б хэсгийг хамарсан нийт 51,000 км^2 нутаг дэвсгэрийг хамарна. Судалгаа шинжилгээний энэ хэсэг нь ГС6-ийн дагуу Бүлэг 9-ийн 2 шалгуурын дагуу Чухал амьдрах орчныг илэрхийлнэ: Шалгуур 1 – Дэлхийн хэмжээнд болон улсын хэмжээнд устаж болзошгүй төрөл зүйл оршдог ач холбогдол бүхий (хоёр зүйл) ба Шалгуур 3 – нүүдлийн болон конгрегатив төрөл зүйл оршдог ач холбогдол бүхий (нэг зүйл) газар. Тиймээс судалгаа шинжилгээний энэ нэгж хэсэг нь Чухал амьдрах орчны хязгаарлагдмал тархацтай буюу эндемик төрөл зүйлийн тухай Шалгуур 2-д тэнцэхгүй бөгөөд дахин давтагдашгүй бүрдэл - Шалгуур 4, Шалгуур 5-хувьслийн үйл явц, Шалгуур 6-экосистемийн үйлчилгээ, Шалгуур 7-нийгэм, эдийн засаг, соёлын ач холбогдол бүхий биологийн төрөл зүйлийн тухай шалгуурын дагуу үнэлхэд тохирох хэмжигдэхүүн гэж үзээгүй.

Судалгаа шинжилгээний энэхүү томоохон нэгж хэсгийн хүрээнд чухал амьдрах орчны хэд хэдэн зэрэглэл байдаг. Тэдгээрээс хамгийн чухал нь ОУСК-ийн Зэрэглэл 1 (нөхөн хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлэх боломжгүй, өндөр зэргийн ач холбогдолтой) болон Зэрэглэл 2 (ач холбогдлоор харьцангуй бага, нөхөн хамгааллын арга хэмжээ хэрэгжүүлэх боломжтой) -т тодорхойлогдсон амьдрах орчин юм. Судалгааны энэ нэгж хэсэгт тохиолдох Хулангийн (*Equus hemionus*) тархац нутгийг Зэрэглэл 1-т багтана гэж тодорхойлж байгаа бөгөөд судалгаа шинжилгээний энэ нэгж хэсгийн дийлэнхийг хамардаг. Шинжилгээний энэ нэгж хэсэгт дэлхийн хэмжээнд устаж болзошгүй тус зүйлийн тоо толгойн 10%-иас илүү тооны бодгаль байгаа нь энэ шалгуурт тэнцэх үндэслэл болдог. Шинжилгээний энэ хэсэг дэхь бусад бүх амьдрах орчныг холбогдох шалгууруудаас хамаарч Зэрэглэл 2-т оруулан ангилж байна. (Аргачлалыг Хавсралт С-с үзнэ үү).

Шинжилгээний жижиг нэгж хэсэг (том хөхтөн амьтдаас бусад бүх төрөл зүйл, өвөрмөц бүрдэл, хувьслийн үйл явц ба экосистемийн үйлчилгээний хувьд шинжилгээний орон зайн нэгж хэсэг) - Ханбогд, Манлай сумыг хамарсан нийт (27,375 км^2) – ГС6-ийн (2006 оны) Бүлэг 9-ийн 1,4,6 ба 7-р Шалгуурын дагуу Чухал амьдрах орчин гэж үзсэн. Энэ Чухал амьдрах орчны хил хязгаар нь Ханбогд, Манлай сумдуудыг хамарсан нийт 27,375 км^2 талбайтай судалгаа шинжилгээний хэсгийн талбай юм. Судалгаа шинжилгээний энэ хэсэг нь Чухал амьдрах орчны тухай ГС6-ийн Бүлэг 9-ийн дөрвөн шалгуурын болзлыг хангадаг. Эдгээр нь Шалгуур 1 – Дэлхийн хэмжээнд болон улсын хэмжээнд устаж болзошгүй төрөл зүйлийн хувьд чухал ач холбогдолтой (хоёр зүйл) байдал, Шалгуур 4 - зүйлийн өвөрмөц бүрдэл (нэг өвөрмөц бүрдэл), Шалгуур 6-экосистемийн чухал үйлчилгээнд чухал ач холбогдолтой байдал (экосистемийн нэг үйлчлэл), Шалгуур 7- орон нутгийн иргэдийн хувьд нийгэм, эдийн засаг, соёлын хувьд чухал биологийн төрөл зүйлд ач холбогдолтой байдал (экосистемийн 3 үйлчилгээ) зэрэг юм. Тиймээс судалгаа шинжилгээний энэ нэгж хэсэг нь Шалгуур 2- хязгаарлагдмал тархацтай ба эндемик төрөл зүйл болон Шалгуур 3 – нүүдлийн болон конгрегатив төрөл зүйл, Шалгуур 5 – хувьслийн үйл явцын тухай Чухал амьдрах орчны шалгуур шинжүүрт тохирдоггүй. Судалгаа шинжилгээний энэ жижиг нэгж хэсэг нь бүхэлдээ чухал амьдрах орчны Зэрэглэл 2-т багтана.

Эдгээр үр дүн нь Оюу Толгойн судалгаа шинжилгээний нэгж хэсэг дэхь бүтээн байгуулалт нь ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 6-ийн Бүлэг 14 / ОУСК-ийн Гүйцэтгэлийн Стандарт 6-ийн (2006 оны хэвлэл), Бүлэг 10-ийн шаардлага, түүнчлэн Оюу Толгой Төслийн Удирдамжийн тайлбарт /ОУСК 2009/ дурьдсан ГС6-ийн Бүлэг 10-ийн тайлбар зэргийг хэрэгжүүлэх ёстой гэсэн үг юм. Төслийн эдгээр шаардлага болон тэдгээрийн ойлголтыг Төслийн Удирдамжийн тайлбарт дурьдсанчлан дараах байдлаар дүгнэж болно:

ОУСК-ийн шаардлага 1: *“Чухал амьдрах орчин бүхий бүс нутагт, захиалагч нь Бүлэг 9-д тусгасан зүйлүүдийн **популяцийн тоо толгойг** тэтгэх Чухал амьдрах орчны чадамж буюу*

*Бүлэг 9-д тусгасан Чухал амьдрах орчны **функцуудэд хэмжигдэхүйц сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй**..... байхаас бусад тохилдолд ямар нэгэн төслийн үйл ажиллагаа явуулахгүй".*

Шаардлага 1-ийн төслийн хувьд авч үзэх ойлгогдохуун: ОУСК-ийн шаардлагад тод хараар тэмдэглэсэн нэр томъёо нь Оюу Толгой төслийн удирдамжийн тайлбарт маш тодорхой утгыг илэрхийлнэ (ОУСК 2009). Дэлгэрэнгүйг (TBC & FFI 2011) 6.2 дахь хэсгээс харна уу. Шаардлага 1 гэдэг нь өргөн уудам бүс нутгийн хэмжээнд Бүлэг 9-т заасан шаардлагыг хангахуйц үнэ цэнэ бүхий биологийн төрөл зүйлүүдэд урт хугацааны туршид хэмжигдэхүйц сөрөг нөлөөлөл үзүүлэх ёсгүй гэсэн үг юм. Төслийн талбайд хэмжигдэхүйц сөрөг нөлөөллүүд тодорхой хэмжээнд (ялангуяа богино хугацааны) гарч болно гэж үзэх боловч эдгээрийг шат дараалсан бууруулах арга хэмжээний хүрээнд зайлсхийх, багасгах, бууруулах арга хэмжээнүүдийг боломжийн хирээр хэрэгжүүлэх шаардлагатай. Урт хугацааны шууд бус нөлөөлийг (нэн ялангуяа амьдрах орчны хуваагдал, түрэмгий харь зүйлүүдийн тархац зэрэг) зохицуулах арга хэмжээ авахад онцгой анхаарал хандуулах ёстой (ОУСК 2009). Төслөөс чухал амьдрах орчинд үзүүлэх бүх нөлөөлөлд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх шаардлагатай.

ОУСК-ийн Шаардлага 2: *"..... Устаж байгаа буюу устаж болзошгүй төрөл зүйлийн **популяцийн тоо толгой буурахгүй байх явдлаас** бусад тохиолдолд үйлчлүүлэгч нь чухал амьдрах орчин бүхий бүс нутагт ямар нэгэн төслийн үйл ажиллагааг явуулахгүй".*

Шаардлага 2-ийн дагуух төслийн хувьд авч үзэх ойлгогдохуун: Төслийн талбай дээрх зүйлүүдийн популяцийн тоо толгой хорогдох нөлөөллийг дэлхийн хэмжээнд (шаардлагатай бол улсын ба бүсийн хэмжээнд) авч үзнэ. Хамгийн чухал нь " *'популяцийн тоо толгойн хүлээн зөвшөөрөгдөхүйц бууралт' гэдэг нь байгаль дээр устахад ойрхон байгаа устаж буй зүйлүүдээс бусад тохиолдолд тухайн популяцийн бодгаль бүр амьд үлдэнэ гэсэн үг бас биш юм"* (ОУСК 2009). Бүлэг 9-т заасан шаардлагыг хангаж буй устаж байгаа болон устаж болзошгүй төрөл зүйлүүдийг цаашид хадгалан хамгаалахын тулд талбайн хэмжээнд сөрөг нөлөөллийг бууруулах болон нөхөн хамгааллын арга хэмжээнүүдийг хамтад нь ашиглах шаардлагатай. Эдгээр төрөл зүйлүүдэд үзүүлэх төслийн бүх нөлөөлөлд хяналт шинжилгээ хийж, үнэлэх шаардлагатай.

ОУСК-ийн Шаардлага 3: *"**Арай бага хэмжээний нөлөөллүүдийг** Бүлэг 8-д заасны дагуу багасгахаас ... бусад тохиолдолд үйлчлүүлэгч нь чухал амьдрах орчин бүхий бүс нутагт ямар нэгэн төслийн үйл ажиллагааг явуулахгүй".*

Шаардлага 3-ийн төслийн хувьд авч үзэх ойлгогдохуун: Чухал амьдрах орчинд үлдэх үлдэгдэл нөлөөллийг (жишээ нь зайлсхийх, багасгах эсвэл нөхөн сэргээх замаар биологийн төрөл зүйлд нөлөөлөх нөлөөллийг бууруулах боломжгүй буюу хэт өндөр өртөгтэй байх гэх мэт) -ийг биологийн төрөл зүйлийн нөхөн хамгааллын арга хэмжээгээр бууруулдаг (ОУСК 2009). Зэрэглэл 1-д багтах чухал амьдрах орчинд нөхөн хамгааллын арга хэмжээ авах боломжгүй гэж ер нь үздэг боловч зарим тохиолдолд (жишээ нь: нөлөөллийн түвшин, үйлчлүүлэгчийн хүчин чадал, тэдний биологийн төрөл зүйлийн хөтөлбөрийн чанар зэргээс хамааран) ийм арга арга хэмжээг хүлээн зөвшөөрдөг. Харин эдгээрийг зохих шинжээч ба оролцогч талуудын оролцоотойгоор тухайн нөхцөл байдал бүрд тодорхойлох шаардлагатай. Шалгуур 4 ба 7-д (Зэрэглэл 1 ба зэрэглэл 2-н хувьд ижил) харгалзах зарим чухал амьдрах орчинг "*нөхөн хамгаалахад хүндрэлтэй буюу боломжгүй байдаг*" (ОУСК 2009).

Дээрх гурван шаардлагын дагуу хэрэглэгдэх хоёр чухал зүйлийг Оюу Толгой Төслийн Удирдамжийн тайлбарт авч үзсэн. Нэгдүгээрт, биологийн төрөл зүйлийн хяналт шинжилгээний хөтөлбөрийг 1-ээс 3 хүртэлх Шаардлагуудыг биелүүлэхийн тулд хэрэгжүүлэх нэн шаардлагатай. Талбайн хэмжээнд төрөл зүйл болон амьдрах орчны аль алинд нь үүсэх хохирлын хүлээн зөвшөөрөгдөх ба үл зөвшөөрөгдөх түвшнийг тодорхойлохуйц Биологийн төрөл зүйлийн багц шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах ёстой. Эдгээр үзүүлэлтүүдийг Нийгэм ба Байгаль орчны менежментийн системд тусган оруулах ёстой. Хоёрдугаарт, нөхөн хамгаалах үйл ажиллагаа нь бүх тохиолдолд тохиромжтой арга зам байдаггүй гэдгийг хүлээн зөвшөөрөхийн сацуу (Зарим биологийн төрөл зүйлийн үнэ цэнэт зүйлсийг нөхөн хамгаалах боломжгүй байдаг) эдгээр 3 шаардлага нь гурвуулаа биологийн төрөл зүйлийн хувьд үнэ цэнэ бүхий чухал амьдрах орчинд үзүүлэх үлдэгдэл нөлөөллийг бууруулах биологийн төрөл зүйлийн нөхөн хамгааллын арга хэмжээ авах боломжыг олгоно.

ОУСК болон ЕСБХБ-ны шаардлагууд Биологийн төрөл зүйлд Цэвэр Эерэг нөлөөлөл үзүүлэх зорилго бүхий Рио Тинтогийн Биологийн төрөл зүйлийн Стратегийн хүрээнд тусгасан шаардлагуудаас онцын ялгаа байхгүй (Рио Тинто 2004 Рио Тинто 2008). ОУСК ГС6 ба ЕСБХБ ГШ6-ийн бодлогуудыг Цэвэр эерэг нөлөөлөл үзүүлэх зорилготой Рио Тинтогийн Биологийн төрөл

зүйлийн Стратегитай саяхан нэгтгэснээр 2004 оноос хойш Рио Тинто компаний дотоод хэрэгцээндээ зориулан боловсруулж ирсэн арга хэрэгсэл, тогтолцоонуудыг ашиглан тэдгээр шаардлагуудыг хэрэгжүүлэх боломжийг олгож байгаа юм.

7.6 ОЮУ ТОЛГОЙ ТӨСЛИЙН НЭН ЧУХАЛ БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН БҮРДЭЛ ХЭСГҮҮД

Оюу Толгой төслийн нэн чухал биологийн төрөл зүйлийн бүрдэл нь ЕСБХБ ГШ6-ийн Бүлэг 13 ба ОУСК ГС6-ийн Бүлэг 9-т (2006 оны хэвлэл) заасны дагуу Оюу Толгой төслийн нөлөөллийн бүсийн Чухал амьдрах орчин хэмээн тооцогдож буй биологийн бүх төрөл зүйлүүдийн бүрэлдэхүүн хэсэг ба Рио Тинтогийн Биологийн төрөл зүйлийн арга хэмжээний төлөвлөгөөнд чухал гэж онцолсон биологийн төрөл зүйлүүдийг багтаадаг. Оюу Толгой Төслийн нөлөөллийн бүсийг төслийн дэд бүтцийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн нөлөөллийн талбайн нийлбэр гэж үзэж болно. Үүнд Ханбогд сум нь тэр аяараа хууль бус ан агнуураас үүсэх хоёрдогч нөлөөлөлд өртөөд буй тул мөн багтана. Гэвч Чухал амьдрах орчны Үнэлгээ ба Чухал амьдрах орчны талаарх Оюу Толгой Төслийн Удирдамжийн тайлбарт хууль бус агнуураас үүдэх хоёрдогч нөлөөлөл, Гүний Хоолой, Галбын Говь, Дөрөлж Уулын Урд хэсгийн уст давхаргуудын усны хүртээмж ба амьдрах орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллүүд зэрэг зарим нөлөөлөл нь энэ бүс нутгаас халин гарч болохыг тэмдэглэсэн. Нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөх зорилгоор нөлөөллийн бодит талбайг тогтоох шаардлагатай ба үүнийг Ханбогд сум хэмээн авч үзсэн. Хууль бус агнуурын хоёрдогч нөлөөлөл нь цаашид өргөжих төлөвтэй байгаа бөгөөд нөхөн хамгаллын эсвэл нэмэлт байгаль хамгаллын үйл ажиллагааг явуулах нь уг нэмэлт нөлөөлөлтэй холбоотой асуудлыг шийдэхэд тохиромжтой гэж үзсэн. Уст давхаргуудад үзүүлэх нөлөөллүүд нь тодорхой бус байгаа ба цаашид энэ талаар хяналт шижнилгээ ба судалгаа хийхийг зөвлөж байна.

Биологийн төрөл зүйлийн түргэвчилсэн үнэлгээний багийн Чухал амьдрах орчинд хийсэн үнэлгээгээр (TBC/FFI 2011; Хавсралт С) тодорхойлсон холбогдох судалгаа шинжилгээний нэгжүүд:

- Хулангийн 1-р зэрэглэлд багтах Чухал амьдрах орчин,
- Монгол буурцгана, аргаль, хар сүүлт зээр, могойч загалай зэрэг амьтдын 2-р зэрэглэлд багтах чухал амьдрах орчин болон боржин чулуун гаршуудын ургамлын бүлгэмдлүүд, усны зохицуулалт, мал сүргийн бэлчээр, био массын түлш, цэвэр ус гэх мэт экосистемийн 4 үйлчилгээнүүд.

Чухал амьдрах орчны шаардлагад тэнцэх үнэ цэнэ бүхий биологийн төрөл зүйлийн бүрдэл хэсгүүдийг Хүснэгт 7.7-д тоймлон үзүүлэв.

Хүснэгт 7.7: Чухал амьдрах орчны шаардлагад тэнцэх үнэ цэнэ бүхий биологийн төрөл зүйлийн бүрдэл хэсгүүд

Шалгуур	Үнэлгээнд хамрагдаж буй бүрэлдэхүүн хэсэг	Биологийн төрөл зүйл	Чухал амьдрах орчны ангилал
1. Устаж байгаа буюу Устаж болзошгүй төрөл зүйлүүд	Хулан	Хөхтөн амьтан	1-р зэрэглэл (Дэлхийн хэмжээнд устаж болзошгүй зүйлийн олон улсын хэмжээний ач холбогдолтой бөөгнөрөл: судалгаа шинжилгээний нэгж хэсэг дэхь тоо толгой нь дэлхий дээрх популяцийн нийт тоо толгойн >10%)
	Монгол буурцгана	Ургамал	2-р зэрэглэл (Улсын хэмжээнд устаж болзошгүй зүйлийн улсын хэмжээний ач холбогдолтой бөөгнөрөл: судалгаа шинжилгээний нэгж хэсэг дэхь тоо толгой нь улсын хэмжээний популяцийн нийт тоо толгойн >10%)
	Аргаль	Хөхтөн амьтан	2-р зэрэглэл (Улсын хэмжээнд устаж болзошгүй зүйлийн улсын хэмжээний ач холбогдолтой бөөгнөрөл: судалгаа шинжилгээний нэгж хэсэг дэхь тоо толгой нь улсын хэмжээний популяцийн нийт тоо толгойн >10%)
	Лусч загалай	Шувуу	2-р зэрэглэл (Улсын хэмжээнд устаж

Шалгуур	Үнэлгээнд хамрагдаж буй бүрэлдэхүүн хэсэг	Биологийн төрөл зүйл	Чухал амьдрах орчны ангилал
			болзошгүй зүйлийн үндэсний хэмжээний ач холбогдолтой бөөгнөрөл: судалгаа шинжилгээний нэгж хэсэг дэхь тоо толгой нь улсын хэмжээний популяцийн нийт тоо толгойн >10%)
2. Орон нутгийн буюу хязгаарлагдмал тархацтай төрөл зүйлүүд	Байхгүй		
3. Нүүдлийн болон бөөнөөрөө амьдардаг төрөл зүйл	Хар сүүлт зээр	Хөхтөн амьтан	2-р зэрэглэл (Улсын хэмжээнд чухал нүүдлийн шувуудын бөөгнөрөл: судалгаа шинжилгээний нэгжид дэлхийн хэмжээний популяцийн нийт тоо толгойн >1%)
4. Төрөл зүйлийн өвөрмөц бүрдэл	Боржин чулуун гаршны ургамлын бүлгэмдэл	Зүйлийн бүрдэл	-
5. Хувьслын гол үйл явцууд	Байхгүй		
6. Экосистемийн үндсэн үйлчилгээ	Усны зохицуулалт	Экосистемийн үйлчилгээ	-
7. Орон нутгийн ард иргэдийн хувьд нийгэм, эдийн засаг, соёлын ач холбогдол бүхий биологийн төрөл зүйлийн бүрдлүүд	Мал сүрэг /бэлчээр/	Экосистемийн үйлчилгээ	-
	Биомассын түлш	Экосистемийн үйлчилгээ	-
	Цэвэр ус	Экосистемийн үйлчилгээ	-

Экосистемийн үйлчилгээнүүдийг биологийн төрөл зүйлийн бүрэлдэхүүн хэсэг гэж үзэх боловч экосистемийн үйлчилгээнүүдэд үзүүлэх нөлөөлөл болон түүнийг бууруулах арга хэмжээний талаар Бүлэг B7б: Экосистемийн үйлчилгээ бүлэгт тусгайлан авч үзнэ. Учир нь эдгээрт биологийн төрөл зүйлийн бус харин нийгэм-эдийн засгийн үнэлгээ хийх шаардлагатай юм.

Рио Тинтогийн Биологийн төрөл зүйлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний удирдамжийн дагуу Чухал амьдрах орчны шаардлагад тэнцэх бүхий л биологийн төрөл зүйлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг ач холбогдолтой гэж үзнэ. Үүнээс гадна Рио Тинто нь Биологийн төрөл зүйлийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө бусад оролцогч талуудын хувьд чухал биологийн төрөл зүйлийн бүрдэл хэсгүүдийг (дэлхийн хэмжээнд гэхээсээ илүүтэйгээр орон нутгийн хувьд чухал байж болно) мөн авч үздэг. Оюу Толгойн төслийн нөлөөллийн бүсэд доорх зүйлсийг хамруулсан:

- Улсын болон дэлхийн хэмжээнд ховордсон зүйлүүд,
- Дэлхийн хэмжээнд хязгаарлагдмал тархацтай бүх зүйлүүд (< 50,000 км^2 –аас бага хэмжээтэй нутаг дэвсгэрт тархсан хуурай газрын ба усны амьтад; хязгаарлагдмал тархацтай ургамлыг тодорхойлоход мэргэжилтнүүдийн зөвлөгөө шаардлагатай),
- Хадгалан хамгаалах ач холбогдол бүхий бүх амьдрах орчин: Чухал амьдрах орчны үнэлгээний дагуу (TBC ба FFI 2011), эдгээр нь экосистемийн түвшинд тодорхойлогддог,
- Чухал амьдрах орчны үнэлгээнд (TBC ба FFI 2011) дурьдсанчлан оролцогч талуудын зөвлөсөн чухал амьдрах орчнууд (экосистемээс илүү нарийвчлалтай).

Хүснэгт 7.8 –д нэн чухал биологийн төрөл зүйлийн бүрдэл хэсгүүдийг бүрэн жагсаав. МУ-ын Байгалийн ургамлын тухай Хуульд заасан нэн ховор ангиллын ургамлын жагсаалтад багтах өөр бусад ургамлууд (TBC/FFI 2011-т 18 зүйлийн ургамлыг талбайд тохиолдох магадлалтай хэмээн тодорхойлсон) Оюу Толгой төслийн нөлөөллийн талбайд тохиолдож болох боловч одоогийн байдлаар зөвхөн Монгол буурцгана зөвхөн тохиолдоно гэж үзсэн.

Хүснэгт 7.8: Оюу Толгой төслийн Чухал амьдрах орчны үнэлгээний нэгж талбай дахь нэн чухал биологийн төрөл зүйлийн бүрдэл хэсгүүд

Ангилал зүйн нэгж	Биологийн төрөл зүйлийн бүрэлдэхүүн хэсэг	Шинжлэх ухааны нэр	Чухал амьдрах орчин	ОУБХХ-ны Улаан дансны статус	Монгол Улсын улаан дансны статус	Судалгааны нэгж хэсэг дэхь байдал
Хөхтөн (туурайтан амьтан)	Хулан	*Equus hemionus*	Зэрэглэл 1	Устаж болзошгүй (EN)	Устаж болзошгүй (EN)	Нүүдлийн “ суурин”
Хөхтөн (туурайтан амьтан)	Аргаль	*Ovis ammon*	Зэрэглэл 2	Ховордож болзошгүй (NT)	Устаж болзошгүй (EN)	Нутагшсан “суурин”
Хөхтөн (туурайтан амьтан)	Хар сүүлт зээр	*Gazella subgutturosa*	Зэрэглэл 2	Эмзэг (VU)	Эмзэг (VU)	Нүүдлийн “суурин”
Хөхтөн (туурайтан амьтан)	Цагаан зээр	*Procapra gutturosa*	-	Анхаарал өртөх өөргүй (LC)	Устаж болзошгүй (EN)	Дорно зүгээс ховорхойн ирдэг зүйл
Хөхтөн (мэрэгч)	Соотон алагдаага	*Euchoreutes naso*	-	Анхаарал өртөх өөргүй (LC)	Эмзэг (VU)	Ундайн голын алс өмнөд хэсэгт маш ховор
Хөхтөн (махчин амьтад)	Цасны ирвэс	*Panthera uncia*				Судалгаа шинжилгээний чухал амьдрах орчинд тохиолддог боловч БОННБҮ-ий нөлөөллийн бүсд байхгүй
Шувуу	Хошуу галуу	*Anser cygnoides*	-	Эмзэг (VU)	Ховордож болзошгүй (NT)	Тухайн бүс нутгаар байнга нүүдэллэн өнгөрдөг байж болзошгүй
Шувуу	Ундар нүдэн шумбуур	*Aythya nyroca*	-	Ховордож болзошгүй (NT)	Эмзэг (VU)	Тухайн бүс нутгаар байнга нүүдэллэн өнгөрдөг байж болзошгүй
Шувуу	Могойч загалай	*Circaetus gallicus*	Зэрэглэл 2	Анхаарал өртөх өөргүй (LC)	Устаж болзошгүй (EN)	Үрждэг
Шувуу	Идлэг шонхор	*Falco cherrug*	-	Эмзэг (VU)	Эмзэг (VU)	Үрждэг
Шувуу	Египтийн тас	*Neophron percnopterus*	-	Устаж болзошгүй (EN)	Анхаарал өртөхөөргүй (LC)	Үрждэг байж болзошгүй
Шувуу	Хонин тоодог	*Otis tarda*	-	Эмзэг (VU)	Эмзэг (VU)	Тухайн бүс нутгаар байнга нүүдэллэн өнгөрдөг (тус газарт буудалладаг)
Шувуу	Жороо тоодог	*Chlamydotis undulata*	-	Эмзэг (VU)	Эмзэг (VU)	Үрждэг

Ангилал зүйн нэгж	Биологийн төрөл зүйлийн бүрэлдэхүүн хэсэг	Шинжлэх ухааны нэр	Чухал амьдрах орчин	ОУБХХ-ны Улаан дансны статус	Монгол Улсын улаан дансны статус	Судалгааны нэгж хэсэг дэхь байдал
Шувуу	Хулан жороо	*Podoces hendersoni*	-	Анхаа ралд өртөх өөргүй (LC)	Эмзэг (VU)	Үрждэг
Шувуу	Реликт цахлай	*Larus relictus*				Судалгаа шинжилгээний чухал амьдрах орчинд мөн БОННБҮ-ий нөлөөллийн бүсд нүүдлийн байдлаар тохиолдоно (түгээмэл биш)
Шувуу	Монгол ногтруу	*Syrrhaptes paradoxus*				Судалгаа шинжилгээний чухал амьдрах орчинд мөн БОННБҮ-ий нөлөөллийн бүсд суурин байдлаар тохиолдоно, оролцогч талуудын санаачлагаар цахилгааны шугамтай мөргөлдөх эрсдэлтэй гэж үзсэн тул сайхан нэмсэн
Шувуу	Козловын хааруулдай	*Prunella koslowi*				Судалгаа шинжилгээний чухал амьдрах орчинд тохиолдох боловч БОННБҮ-ий нөлөөллийн бүсд тохиолдохгүй
Шувуу	Шарэлэгт хөмрөг	*Emberiza aureola*				Судалгаа шинжилгээний чухал амьдрах орчинд мөн БОННБҮ-ий нөлөөллийн бүсд нүүдлийн байдлаар тохиолдоно (түгээмэл бус)
Төрөл зүйлийн бүрдэл	Боржин чулуун гаршын ургамлын бүлгэмдэл	-	Зэрэгл эл 2	-	-	Ханбогд ба бусад массивууд
Амьдрах орчин	Сайр дагуух хайлаас мод	-	-	-	-	Ихэвчлэн Ундай голын сайр
Амьдрах орчин	Түр зуурын нуур тойрмууд	-	-	-	-	Өмнө зүгийн дов толгодын ойролцоо тархсан
Амьдрах орчин	Заган ой	-	-	-	-	Голчлон цооногийн талбай ба хотгор газар
Амьдрах орчин	Зүүн Говийн цөл-хээр	-	-	-	-	Тус бүсд тохиолдох томоохон амьдрах орчин- түгээмэл
Амьдрах орчин	Алашаны тэгш өндөрлөг хагас цөл	-	-	-	-	Тус бүсд тохиолдох томоохон амьдрах орчин- түгээмэл
Ургамал	Монгол буурцгана гэх мэт 18 зүйлийн	-	-	-	-	Алаг цоог тархасан – нөлөөллийн бүсэд

Ангилал зүйн нэгж	Биологийн төрөл зүйлийн бүрэлдэхүүн хэсэг	Шинжлэх ухааны нэр	Чухал амьдрах орчин	ОУБХХ-ны Улаан дансны статус	Монгол Улсын улаан дансны статус	Судалгааны нэгж хэсэг дэхь байдал
	ховор ургамлууд					тохиолдсон буюу тохиолдох магадлалтай нэн ховор 18 ургамлыг төлөөлөх үүднээс авч үзсэн.

EN = Устаж болзошгүй; VU = Эмзэг; NT = Ховордож болзошгүй; LC = Анхааралд өртөхөөргүй

Тэмдэглэл: Бүх чухал, тэргүүлэх ач холбогдолтой амьтан, ургамал нь төслийн нөлөөлөлд өртөхгүй юм. БТЗТҮ-ийн Хавсралт 3-т заахдаа “Оюу Толгой төслийн нөлөөлд өртөхгүй боловч Ханбогд сумын нутагт байрших чухал ач холбогдолтой амьтан, ургамалд: цасны ирвэс, соотон алагдай, Козловын хайруулдай, боржин илэрцийн ургамлын бүлгэмдэл болон түр зуурын нуур болон тогтоол ус”

7.7 ТҮРЭМГИЙ ТӨРӨЛ ЗҮЙЛҮҮД

Оюу Толгойн НБ нь уугуул болон түрэмгий төрөл зүйлүүдийн нөлөөлөлд өртөөгүй. Говийн бэлчээр газруудад явуулсан судалгаагаар энэ бүс нутагт асуудал үүсгэж буй хөл газрын ургамал тогтоогдоогүй байна. 2004 оны байдлаар Монгол улсад хор хөнөөлтэй төрөл зүйлүүдийн бүртгэл жагсаалт байгаагүй байна (Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 2004).

Байгаа мэдээллээс үзэхэд нь аливаа түрэмгий ургамлын зүйлүүд өмнөд Говийн бүсийн ургамалжилт, ургамлын аймгийн чухал элемент болно гэж үзэхгүй байна. Цөөн тооны түрэмгий зүйлүүдийн дотроос *Amaranthus retroflexus*, *Fagopyrum esculentum*, ба *Triticum aestivum* зэргийн ургамлыг харьцангуй өргөн тархацтай гэж тогтоосон (Ж. Санжид).

Бүртгэгдсэн түрэмгий харь амьтад нь байр сууц, бусад байгууламжуудтай холбоотой гарч ирдэг гэрийн хулгана, харх зэрэг юм. Тэжээвэр мал амьтдыг малчид цаг үргэлж маллаж хариулдаг бөгөөд бус нутагтаа эргэж зэрлэгшээгүй.

7.8 ХУУЛИЙН ДАГУУ ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ БОЛОН ОЛОН УЛСАД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДСӨН ГАЗАР НУТГУУД

7.8.1 Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгууд

Дэлхий дээр хамгийн анхны дархлагдсан газруудын нэг бол Улаанбаатар хотын ойролцоо орших Богдхаан уул бөгөөд 1778 онд Дархан цаазат газар болгон тогтоож байсан байна. Тэр цагаас хойш Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тогтолцоо өргөжиж Монгол улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар хамгаалагдсан 69 газар нутгийг (2010 оны 1 дүгээр сарын байдлаар) хамрах болсон бөгөөд нийт газар нутгийн 14-өөс илүү хувийг эзэлж, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ нь улсын газар нутгийн 10 гаруй хувийг эзлэх болсон байна (Чимэд-Очир, 2010). Үндэсний хэмжээнд хамгаалагдсан газар нутгууд нь дөрвөн төрөлд хуваагдана. Дархан цаазат газар нь хамгаалалтын хамгийн хатуу түвшинг төлөөлөх бөгөөд Байгалийн цогцолборт газар үүний араас орно. Байгалийн нөөц газрыг экологийн, биологийн, палеонтологийн, геологийн дурсгалыг хамгаалах зорилготой байгуулдаг бол Байгалийн дурсгалт газрыг байгалийн болон түүх, соёлын дурсгалт гэж ангилдаг (Чимэд-Очир, 2010).

Өмнийн говийн томоохон газар нутгуудыг тусгай хамгаалалттай газар нутгийн статустайгаар тогтоосон байдаг. Үүний хамгийн том нь Говийн их дархан цаазат газар бөгөөд ГБДЦГ-тай төстэй, мөн “А”, “Б” гэж томъёологдох хоёр хэсэгт хуваагддаг. Их говийн биосферийн нөөц нь төв Азийн говь цөлийг төлөөлж байдаг бөгөөд говь цөл, уулын хээрийн ховор ургамлын аймгийг хадгалж байдаг. Энэ нь цасны ирвэс (*Uncia uncia*), янгир (*Capra sibirica*), аргал (*Ovis ammon*), бөхөн (*Saiga tatarica mongolica*), мазаалай (*Ursus arctos gobiensis*), хавтгай (*Camelus ferus bactrianus*) зэрэг устаж болзошгүй олон төрөл зүйлүүдийн амьдрах орчин болж өгдөг. Говийн их дархан цаазат газрыг 1976 онд үндэслэн байгуулсан бөгөөд 1990 онд Дэлхийн Биосферийн нөөц газрын сүлжээнд багтаасан ба үүнийг дэлхий дээрх хамгийн том (5.3 сая га талбайтай) биосферийн нөөц газруудын нэг гэж үздэг байна.

Гэвч Монгол улс дахь тусгай хамгаалалттай газар нутгуудад хууль журмыг хэрэгжүүлэх, дагаж мөрдөх явдал сул байгаа бөгөөд үүнийг дагаад тусгай хамгаалалттай газар нутгийн үр дүнтэй байдлын талаарх ойлголт мөн дутмаг байгааг саяхны судалгаагаар тэмдэглэжээ. Иймд Монгол орон даяар улсын тусгай хамгаалалтанд авсан газар нутгуудыг үр дүнтэй удирдах загварыг бий болгох, менежментийг хэрэгжүүлэх туршилтын төслүүдийг хэрэгжүүлж эхлээд байна[20]. Үүний зэрэгцээ удирдлага, менежментийн үр дүнг дээшлүүлэх НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хөтөлбөр хэрэгжиж байгаа билээ[21].

7.8.2 Өмнөговь аймаг дахь тусгай хамгаалалттай газар нутгууд

Өмнөговь аймгийн хэмжээнд байгаа улсын тусгай хамгаалалттай газрууд нь нийт 3,490,894 га талбайг (нийт нутаг дэвсгэрийн 21.1%) хамардаг бөгөөд дараах газруудаас бүрдэнэ:

- 1 Дархан цаазат газар (ГБДЦГ),
- 1 Байгалийн цогцолборт газар, ба
- 1 Байгалийн нөөц газар.

Хүснэгт 7.9-д Өмнөговь аймаг дахь тусгай хамгаалалттай газар нутгуудын талаарх ерөнхий мэдээллийг үзүүлсэн болно. Зураг 7.26-д Өмнөговь аймаг дахь бүсийн хэмжээний тусгай хамгаалалттай газар нутгуудыг харуулав. Тус аймагт орон нутгийн хамгаалалтын статустай боловч, улсын тусгай хамгаалалттай газрын нутгийн түвшний жагсаалтанд ороогүй хэд хэд хамгаалагдсан газрууд байдаг. ГБДЦГ-ын танилцуулга болоод шувуудад чухал газруудын талаарх мэдээллийг доор дурдав.

Хүснэгт 7.9: Өмнөговь аймаг дахь улсын тусгай хамгаалалттай газар нутгууд

Тусгай хамгаалалттай газар нутгууд	Нийт талбай (га)	Өмнөговь аймгийн нутагт хамаарах талбай (га)
Говийн Бага Дархан Цаазат Газар А ба Б хэсэг	1,839,176	1,291,927
Говь Гурван Сайхан Байгалийн Цогцолборт Газар	2,694,737	2,171,737
Загийн Ус Байгалийн Нөөц Газар	273,606	27,230
Нийт	***4,807,519***	***3,490,894***

[20] Р.Грэйсон, Н. Ээнжин ба С. Доржсүрэн. Богд Хан уулын ойн менежментийг үр дүнтэй явуулснаар Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгуудыг дахин сэргээх. Дэлхийн Банк. 2010 оны 5-р сар.

[21] НҮБ-н Хөгжлийн Хөтөлбөр, Монгол улсын Тусгай Хамгаалалттай Газар нутгуудын Сүлжээг Бэхжүүлэх (ТХГНСБ).

Зураг 7.26: Өмнөговь аймаг дахь Тусгай хамгаалалттай газар нутгууд ба Шувуудад чухал газрууд



7.8.3 Говийн Бага Дархан Цаазат Газар

ГБДЦГ нь ОУБХХ-ны “Ib” ангилалд багтах газар бөгөөд Оюу Толгойн лицензит талбайгаас баруун урагш 36 км зайд орших А хэсэг, зүүн урагш 70 км-т орших Б хэсэг гэсэн 2 тусдаа хэсгээс бүрддэг. ГБДЦГ нь Өмнөговь аймгийн Номгон, Баян-Овоо, Ханбогд болон Дорноговь аймгийн Хатанбулаг сумдын нутаг дэсвгэрийг дамнан орших 1,839,176 га талбай бүхий нутагтай. Баруун талд орших А хэсэгт нь байгаль хамгаалагчид болон хилийн цэргийн ангийг эс тооцвол бараг хүн амьтан нутагшаагүй байдаг бол зүүн талд нь байрлах Б хэсэгт малчид улирлын чанартайгаар нүүдэллэн суурьших ба баруун захаар нь Гашуун Сухайт чиглэлийн шороон зам хөндлөн гарна.

Тухайн үед мал бэлчээрлэлт болон ан агнуур зэрэг нөлөөлөл харьцангуй бага байсан тул ГБДЦГ-ыг зүүн өмнийн Говийн бүс нутгийн экосистемийн төлөөлөл болгон 1993 онд байгуулсан байна (УИХ-ын 83-р тогтоолоор). Хүмүүсийн дунд уг тусгай хамгаалалттай газрыг бий болгох төлөвлөгөө гарах үед дунд хэсэгт нь газрын тосны хайгуулын лиценз олгосноор А ба Б гэсэн тусдаа хэсгүүдэд хуваасан гэсэн ам дамжсан яриа байдаг.

ГБДЦГ нь ОУБХХ-ны “Ib” ангилалд багтах газар юм. Энэ ангилал нь *хөндөгдөөгүй буюу бага зэрэг хөндөгдсөн, байгалийн унаган төрх нөлөөллөө хэвээр нь хадгалж үлдсэн, байнгын болон олон тооны хүн ам суурьшаагүй, түүний байгалийн суурь нөхцөл байдлыг хадгалах зорилгоор тусгай хамгаалалтанд аван менежментийн арга хэмжээ хэрэгжүүлж буй газар нутаг буюу далай тэнгист хамааралтай категори юм*.

ГБДЦГ нь хадан хясаа, элсэн манхан, хуурай нуур тойром, өргөн сайр, гол горхи бүхий баянбүрд зэрэг нь хулан, хар сүүлт зээр, аргал, янгир гэх мэт зүйл амьтдын чухал амьдрах орчин болдог байна.

2004 онд авто замын БОНБНҮ-ний хүрээнд хийгдсэн нийгэм-эдийн засгийн судалгаагаар ГБДЦГ-ын Б хэсэгт ойролцоогоор 4000 орчим толгой малтай 8 малчин айл өрх байгааг тогтоожээ (Эко-Трэйд, 2004). Эдгээр малчин өрхүүд нь уг газрыг тусгай хамгаалалтад авахаас өмнө суурьшсан байсан бөгөөд тэднийг нүүлгэн шилжүүлэх шаардлагыг тавиагүй байна. Байгаль хамгаалагчид нь гол төлөв тусгай хамгаалалттай бүсэд мал сүргээ хариулдаг малчид байдаг бөгөөд хууль бус ан хийхээс сэргийлэх эргүүлийн ажлыг хийдэг байна.

2006 онд ГБДЦГ-ын захиргааг Ханбогд суманд байгуулжээ. Уг захиргаа нь нийт 14 ажилтантай бөгөөд үүний 9 нь байгаль хамгаалагчид байна. Тусгай хамгаалалттай уг газрын газар нутгийн хэмжээтэй харьцуулахад дээрх тоо нь хангалтгүй бөгөөд иймд Оюу Толгой нь байгаль хамгаалагчдын тоог нэмэгдүүлэх талаарх дэмжих чиглэлийн хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа ба энэхүү асуудлыг D8: Биологийн төрөл зүйлийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан байгаа болно. Зураг 27-д ГБДЦГ ба Гашуун Сухайт хүрэх Оюу Толгойн замын хоорондын хамаарлыг харуулсан болно.

Төлөвлөж буй Оюу Толгойн замын урд хэсэг нь ГБДЦГ-ын Б хэсгийн орчны бүсээр 32 км газраар, хязгаарлалтын бүсээр 13 км газраар дайран өнгөрөх юм. Орчны бүс нь тусгай хамгаалалттай газар нутагт хамаарахгүй бөгөөд энэхүү бүсэд газар ашиглалтын төлөвлөгөө гаргадаг ба аливаа бүтээн байгуулалт тусгай хамгаалалттай газар нутагт сөрөг нөлөөллийг үзүүлэхгүй байх явдлыг хангахын тулд төлөвлөгөө боловсруулж хянадаг байна. Орчны бүсийн газар нутаг нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд хамаарахгүй юм. Орчны бүсийг дайран өнгөрөх замын 22 орчим км нь одоо байгаа зам, харин 10 км нь одоо байгаа нүүрс тээвэрлэдэг зам юм. Хязгаарлалтын бүсийг 13 км газраар дайран өнгөрөхдөө нүүрс тээвэрлэлтийн одоо байгаа замыг ашиглах болно. Монгол-Хятадын хилийн Гашуун Сухайтын хилийн шалган нэвтрүүлэх цэг нь бас ГБДЦГ дотор оршдог юм. Оюу Толгой компанийг Өвөр Монголын цахилгаан шугам сүлжээнд холбох цахилгаан дамжуулах шугам нь ГБДЦГ-с гадна буюу зөвхөн орчны бүсээр дамжин өнгөрнө. Тусгай хамгаалалттай газрын орчны бүсэд цахилгаан дамжуулах шугам болон зам барьж ашиглахыг хорьсон хууль зүйн заалт байдаггүй байна.

Тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрч болох үйл ажиллагааны жагсаалтыг 7.1.3-р Хэсэгт авч үзсэн.

ЕСБХБ-ны 6-р Гүйцэтгэлийн шаардлагын 15-р Бүлэг мөн ОУСК-н Гүйцэтгэлийн Стандартын 6-н 11-р Бүлэг заасны дагуу Оюу Толгой нь:

- БОНБНҮ-ий хүрээнд тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагууд, орон нутгийн иргэд болон БОАЖЯ гэх зэрэг гол оролцогч болон сонирхогч талуудтай зөвлөлдсөн бөгөөд Монгол улсын шаардагдах зөвшөөрлүүдийг авсан;
- ГБДЦГ-ын “Б” хэсгийг дайран өнгөрөх Гашуун Сухайтаас Оюу Толгой хүртэлх улсын чанартай замыг засаж сайжруулах ажлыг холбогдох байгууллагуудаар батлуулах явдлыг хариуцсан
- Төслийн байгаль орчны менежмент, нөлөөллийг бууруулах болон нөхөн хамгаалах үүрэг нь Тусгай Хамгаалттай Газар Нутгийн Менежментийн Төлөвлөгөөнд оруулсан менежментийн зорилтуудтай тохирох явдлыг хангасан
- Нөхөн хамгааллын менежментийн бодлогод тусгай хамгаалалттай газруудыг бэхжүүлэх нөхөн хамгааллын арга хэмжээнүүдийг тусгах явдлыг хангасан (*Бүлэг С6: Биологийн төрөл зүйлийн олон янз байдал ба Экосистемийн үйлчилгээнд нөлөөлөх байдлын үнэлгээ, Хавсралт С, 4.5-р хэсэг*).

Зураг 7.27: ГБДЦГ-г дайран өнгөрч буй замууд



7.8.4 Шувуудад Чухал Газрууд

“Бэрдлайф Интернэшнл” ОУБ нь дэлхийн хэмжээнд Шувуудад Чухал Газруудыг (ШЧГ) тодорхойлсон. ШЧГ-ууд нь хамгаалах үйл ажиллагааны чухал газрууд бөгөөд дэлхийн хэмжээнд ховордсон нэг буюу түүнээс дээш зүйл амьтад олон тоотойгоор оршин байгаа газар, хязгаарлагдмал тархацтай буюу тухайн тодорхой нэгэн биомийн хүрээнд тархацтай зүйлүүдийг тэтгэдэг газар мөн нүүдлийн болон конгрегатив зүйл амьтдын асар олон тоо толгой бүхий газрыг хэлнэ. Хэдийгээр Монгол улсад хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрч хамгаалсан статус байхгүй боловч энэхүү шувуудад чухал газруудыг олон улсад биологийн төрөл зүйлийн олон янз байдлын хувьд гол чухал газрууд хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд ОУСК ба ЕСБХБ-ны бодлогын дагуу эдгээр газруудад онцгой анхаарал тавихыг шаарддаг.

